2018 онд Монгол улсын хүний эрхийн Үндэсний комиссоос “Тавантолгойн бүлэг ордоос нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ” – г хийсэн байдаг бөгөөд, тус арга хэмжээний олон талт хэлэлцүүлэгт Цогтцэций сумын төв (Өгөөмөр баг) болон Цагаан-Овоо багийн иргэдээс авсан судалгаагаар 80 орчим хувь нь тоосжилт, агаарын бохирдлыг бууруулах асуудлыг хамгийн ихээр тулгамдаж буй асуудал гэж үзсэн байна.

Нүүрс тээврийн жолооч нарын асуудалд засгийн газраас анхаарч Цогтцэций суманд “Тээвэрчдийн хотхон” байгуулах ажил амжилттай хэрэгжиж байна. Ингэснээр 4 болон, 6 дахь гармын ойр орчимд байсан аж ахуйн нэгж, үйлчилгээний газар, хувь иргэдийг эмх цэгцэнд оруулж зохион байгуулалт сайжирсан. Тээвэрчдийн хотхон нь нэг ээлжиндээ 500 жолооч хүлээн авах хүчин чадалтай юм. Мөн гадна талбайдаа 1000 машины зогсоолтой, эмнэлэг, шатахуун түгээх, ачилт хүлээлгийн талбайтай юм. Тус цогцолбор бүрэн үйл ажиллагаанд орсноор, Цогтцэций сумын эмнэлгийн ачаалал болон, эмх замбараагүй сумын төвөөр явдаг тээврийн хэрэгслийг эмх цэгцэнд оруулах юм. Мөн байгаль орчинд хаягдах асар их хог хаягдлыг төвлөрсөн менежментэд шилжүүлж байгаа юм. Гашуун сухайтын 250 км авто замаар 14000 орчим машин нүүрс тээвэрт явж байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

ISO 14001:2016 байгаль орчны удирдлагын тогтолцооны стандартын дагуу компанийн зүгээс байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор байгаль орчны асуудлууд тэдгээрээс улбаатай байгаль орчны нөлөөллүүдийг тодорхойлж эрсдэлийн үнэлгээ хийсэн. Эрсдэлийн үнэлгээ нь байгаль орчны гол асуудлыг зөв таньж тодорхойлоход дөхөм болсноор компани байгаль орчны чиглэлээр хийх ажлын ач холбогдлын эрэмбэ дарааллыг тодорхойлон гаргав.

3.1 Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц

ISO 14001:2016 стандартын дагуу байгаль орчны гүйцэтгэлийн ач холбогдлын дарааллыг тодорхой болгох зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийсэн. Байгаль орчны асуудлыг тодорхойлж эдгээртэй холбоотой байгаль орчны нөлөөллийг тодорхойлсон. Нөлөөлөл тус бүрийн эрсдэлийн зэргийг тодорхойлсон.

Хүснэгт № 4. Эрсдэлийн үнэлгээний матриц

Магадлал	Үр дагавар				
	ялимгүй	бага	дунд	их	гамшиг
I бараг болохгүй	L	L	M	H	H
II магад болохгүй	L	L	M	H	E
III болзошгүй	L	M	H	E	E
IV магад болох	M	H	H	E	E
V лавтай болох	H	H	E	E	E

Хүснэгт № 5. Үр дагаварын үнэлгээний шалгуур

Түвшин	Зэрэг	Тайлбар
I	Бараг болохгүй	Онцгой нөхцөлд эрсдэлтэй байж магадгүй (<5%)
II	Болохгүй байж магад	Заримдаа эрсдэлтэй байж магадгүй (5-20%)
III	Болзошгүй	Заримдаа эрсдэл үүснэ (20-50%)
IV	Магад болох	Бараг бүх нөхцөл эрсдэл үүсгэж болзошгүй (50-70%)
V	Лавтай болох	Бараг бүх нөхцөл эрсдэлтэй (70-100%)

Хүснэгт № 6. Үр дагаварын үнэлгээний шалгуур

Зэрэглэл	Уршиг	Эрсдэлд өртөгч ба эрсдэлийн тодорхойлолт		Уршигийг бууруулах арилгах шийдэл
		Хүн ам	Эд хөрөнгө	
I	Ялимгүй	Техноген нөлөө арилахад хор уршиг арилна	Хохирол үгүй	Тусгай шийдэл шаардлагагүй
II	Бага	Бүс нутагт хуримтлагдах нөлөөлөл бий болгож био орчинд стресс учруулна	Багавтар хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн горимыг мөрдөх
III	Дунд	Урт хугацаанд дэлхийн дулааралд хувь нэмэр оруулна	Дунд зэрэг хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн чанд горимыг мөрдөх, зохион байгуулалтын өндөр түвшинд ажиллах
IV	Их	Хуримтлагдах сөрөг нөлөө үүсгэж урт хугацаанд экологийн тэнцвэр алдагдана	Их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил, Тодорхой хэмжээний хөрөнгө зардал шаардана
V	Гамшиг	Байгаль орчинд эргэж буцахааргүй уршиг учруулж экологийн тэнцвэрт байдал алдагдахад хүрнэ	Маш их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил. Их хэмжээний хөрөнгө оруулалт шаардана

3.2 Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээний хүснэгт

Хүснэгт № 7. Эрсдэлийн үнэлгээ

Үйл ажиллагаа	Асуудал	Нөлөөлөл	Магадлал	ҮД ¹	Э.З. ²	Хариу арга хэмжээ	Бүлэг
1	2	3	4	5	6	7	8
Ажилчдын хотхон эрхлэх	Дулаан түгээх	Хүлэмжийн хий үүснэ	4	1	II	Мод тарих	
			4	1	II	Түлш зарцуулалтын хяналт	
	Их хэмжээний хог хаягдал	Лэнд-филийн талбай нэмэгдэнэ	5	4	IV	Хог хаягдлын ангилан ялгалт	
			5	4	IV	Хог хаягдлын гарцыг хянах	
			5	4	IV	Биозадралд ордог бүтээгдэхүүн	
Барилга шинээр байгуулах	Барилгын хог гарах	хөрсний бохирдол	4	3	III	Хог хаягдлыг ангилан ялгалт, дахин боловсруулалт	
Гадаад тээвэр хийх	Техникийн хөдөлгөөн, салаа зам	Хөрсний эвдрэл	4	3	III	Тоос бууруулах арга хэмжээ	
			4	3	III	Хөдөлгөөний хязгаарлалт	
			4	3	III	Хөрсний өөрчлөлтийн хяналт	
Засвар, угсралт эрхлэх	Ашигласан сэлбэг, хэрэгсэл хаягдана	Хөрсний бохирдол	4	4	IV	Хог хаягдлыг ангилан ялгалт, дахин боловсруулалт	
			4	4	IV	Хог хаягдлын гарцыг хянах	
			4	4	IV	Ажлын байрны тогтмол үзлэг	
	4		3	III	Аюултай бодисын удирдлага		
	4		3	III	Хөрсний бохирдлын хяналт		
	4		4	IV	Асгаралтаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө		
	4		4	IV	Хөрсний бохирдлын хяналт		
	4		4	IV	Асгаралтаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө		

¹ Үр дагавар: 1

² Эрсдэлийн зэрэглэл: I – Бага, II – Дунд, III – Өндөр, IV – Маш өндөр

			4	4	IV	Аюултай бодисын хяналт, бүртгэл	
			4	4	IV	Ажлын байрны эмх цэгц	
Нүүрсний овоолго байгуулах	Бутарсан нүүрс овоологдох	Хүлэмжийн хий үүснэ	1	2	II	Уурхайн төлөвлөлт	
	Нүүрс газрын гадаргад гарна	Тоос үүснэ	5	4	IV	Тоос бууруулах арга хэмжээ	
			5	4	IV	Дэвшилтэт технологи судалгаа	
			5	4	IV	Аэрозолын хяналт	
Оффисын байрны үйл ажиллагаа	Дулааны хэрэглээ	Хүлэмжийн хий үүснэ	4	1	II	Мод тарих	
			4	1	II	Түлш зарцуулалтын хяналт	
Тэсэлгээ явуулах	Чичиргээ, дуу чимээ	Ард иргэдийн тав тух алдагдана	1	3	II	Нөхөн олговор	
			1	3	II	Дуу чимээний хяналт	
			1	3	II	Дуу чимээ тархалтын судалгаа	
Ус хангамж /ахуй/	Ус хэрэглэх	Усны эх үүсвэр багасна	4	2	II	Усны хэрэглээний хяналт	
4			4	IV	Нөөцийн хэмнэлт		
Ус хангамж /үйлдвэр/			4	4	IV	Усны хэрэглээний хяналт	
Уулын цулын тээвэр	Гадарга дээр зам үүсгэх	Хөрсний эвдрэл	3	2	II	Хаалтын зөв төлөвлөлт	
			3	2	II	Геозкологи орчны хяналт	Уулын ажлын тайлангийн архив
	Техникийн хөдөлгөөн	Тоос үүснэ	5	5	IV	Тоос бууруулах арга хэмжээ	
			5	5	IV	Аэрозолын хяналт	
			5	5	IV	Дэвшилтэт технологи судалгаа	
			5	5	IV	Тоос бууруулах арга хэмжээ	
Уурхайн барилга байгууламж	Орогнох зай бий болно	Хортон амьтан үүрлэх, олшрох	2	4	II	Барилга барихаас өмнө дизайныг бодолцох	БОННУ-д барилга байгууламжийн орон нутгийн онцлогт тохируулсан дизайны шаардлага
Хоол үйлдвэрлэл	Хог хаягдал үүснэ	Лэндфилийн талбай нэмэгдэнэ	5	2	III	Хог хаягдлыг ангилан ялгалт, дахин боловсруулалт	
			5	2	III	Хог хаягдлын гарцыг хянах	
	Уулын ахилт		4	2	II	БОЯБ дүйцүүлэн хамгаалах	

Хөрс хуулалт	Уулын ахилт, мөргөцөгөөс олборлох	Хүлэмжийн хий үүснэ	4	2	II	Хүлэмжийн хийн хяналт	
		Тоос үүснэ	5	4	IV	Тоос бууруулах арга хэмжээ	
			5	4	IV	Аэрозолын хяналт	
	Ухаш үүснэ	Аюултай гео орчин үүснэ	5	2	III	БОЯБ дүйцүүлэн хамгаалах	
			5	2	III	Геоэкологи орчны хяналт	Уулын ажлын тайлангийн архив
		Хөрсний эвдрэл	5	3	IV	БОЯБ дүйцүүлэн хамгаалах	
Хөрсний овоолгын ажил	Чулуулаг газрын гадаргад гарч өгөршилд орно	Тоос үүснэ	4	3	III	Нөхөн сэргээлт явуулах	
			4	3	III	Аэрозолын хяналт	
	Чулуулаг устай харилцах	Хүчлийн урсац үүснэ	3	2	II	Нөхөн сэргээлт явуулах	
			3	2	II	Геохимийн хяналт	
Цахилгааны хэрэглээ, оффис байр	Цахилгаан хэрэглэх	Хүлэмжийн хий үүснэ	5	1	II	Нөөцийн хяналт	
			5	1	II	Цахилгааны хэрэглээний хяналт	
Цахилгааны шугам	Шувууны анхааралд өртөнө	Шувуу эндэх	3	4	IV	Дизайны сайжруулалт	
			3	4	IV	БОЯБ мониторинг	

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Тавантолгойн нүүрсний орд газар дахь ил уурхайн үйл ажиллагаанд байгаль орчны нийцлийг хангуулах гол зорилготой.

Төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорилт болгоно.

Үүнд:

- ✓ ISO 14001 байгаль орчны удирдлагын тогтолцооны элементүүдийг хэрэгжүүлэх;
- ✓ Байгаль орчны аудит, БОННУ-ний шаардлагуудыг биелүүлэх;
- ✓ Компанийн стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;
- ✓ Гэрээт байгууллагуудын байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, түүний гүйцэтгэлд хяналт тавих, аргагүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах;
- ✓ Уурхайн үйл ажиллагааны талбайн хүрээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангуулахад анхаарч ажиллах;
- ✓ “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уурхайн хэмжээнд байгаль орчны бодлого, дүрэм, журмыг хэрэгжилтийг хангах;
- ✓ Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын газар ашиглалтын байдалд хяналт тавьж төрийн болон хяналтын байгууллагуудад мэдээ хүргэх;
- ✓ БОМТ-нд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг тодорхойлох;
- ✓ ОХШХ-нд талуудын оролцоог хангах, ил тод нээлттэй байх зарчмыг баримтлах;

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

5.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
5.1.1	Тоос бууруулах бодисыг технологийн замд ашиглах	15 км	Тайлант онд Цанхийн уурхайд нийтдээ 8.45 км технологийн автозамд тоос барьцалдуулагч DUST-LOC PLUS болон Лигносульфит төрлийн Бодисыг ашигласан. Үүнээс Цанхийн зүүн уурхайд “Эко сойл” ХХК-ны нийлүүлдэг DUST-LOC PLUS бодисыг 5 км технологийн замд, Цанхийн баруун уурхайд мөн адил бодисыг 0.55 км технологийн замд, Лигносульфит бодисыг 2.9 км технологийн замд ашигласан байна.	56.3%
5.1.2	Уурхайн ашиглалтын замыг сайжруулах, материал, дэвсэлт хийх	15 км	Тайлант онд Цанхийн баруун уурхайд нийтдээ 72.9 га, 338.2 км зам талбайд 95,591 м3 шаварлаг материал дэвсэж сайжруулах ажил, Цанхийн зүүн уурхайд нийтдээ 11.8 га, 3.8 км зам талбайд 88,113 м3 шаварлаг материал дэвсэж сайжруулах ажил, Цанхийн нийт уурхайн хэмжээнд 84.7 га талбайд 183,704 м3 шаварлаг материал дэвсэж нийт 342 км технологийн автозамд сайжруулах ажил хийгдсэн байна.	100%

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
5.1.3	Уурхайн зам талбай, нүүрсний агуулах, гаалийн талбайд усалгааны машиныг тогтмол ажиллуулах	5-аас доошгүй	Уурхайн өдөр шөнийн ээлжинд Цанхийн баруун уурхайд 18 усны машин, Цанхийн зүүн уурхайд 10 усны машин, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2 усны машин, нүүрсний агуулах болон гаалийн хяналтын талбайд 3 усны машин, нийт 33 машин ажиллаж усалгаа хийгддэг ба энэ оны эхний 10-н сарын байдлаар нийт 866,571 м ³ усыг зам усалгаанд ашигласан байна. Үүнээс 540,688 м ³ хур борооны хуримтлагдсан ус, 88,428 м ³ уурхайн шүүрлийн ус, 74,043 м ³ цэвэршүүлсэн саарал ус, 125,783 м ³ гүний усыг авч ашигласан байна.	100%
5.1.4	Уурхайн дотоод зам талбайд шороон зам дээгүүр зорчиж буй хөнгөн тэрэг болон уулын машин механизмуудад хурдны хязгаар тогтоож, гэнэтийн хэмжилт шалгалт хийж хяналт тавих	Сард 3	Уурхайн замын хөдөлгөөнд оролцож буй техникүүдийн хурд хэмжилтийг “Эрдэнэс Тавантолгой” ХК болон гэрээт туслан гүйцэтгэгч байгууллагуудын Хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн нар тогтмол 7 хоног бүр гэнэтийн хэмжилтийг хийдэг бөгөөд оны эхний 10 сарын байдлаар Цанхийн зүүн уурхайд 227 удаа, Цанхийн баруун уурхайд 558 удаа, нийт 785 удаа хурдны хэмжилт хийсэн байна.	100%
5.1.5	Ачаа тээврийн авто машинуудыг хатуу хучилттай авто замаар зорчуулах тал дээр хяналт тавьж ажиллах	2.9 км	Цогтцэций-Даланзадгад чиглэлийн замаас Баруун нарангийн автозам хүртэлх 7.4 км автозамын арчилгаа хийх хуваарийг Салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны газрын даргаар батлуулан гэрээт байгууллагуудын сар бүрийн төлөвлөгөөнд тусган тухай бүрт хийлгүүлэн ажилласан.	100%
5.1.6	Нүүрс тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх	Тогтмол	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Нүүрс ачилт, логистикийн хэлтэст 4-н ээлжинд нийт 32 хучигч ээлжээр ажилладаг ба нүүрс тээврийн ачаатай машиныг хучих ажлыг хариуцан гүйцэтгэдэг тул хучилт хийлгээгүй машин уурхайн бүсээс гарах боломжгүй байдаг.	100%
5.1.7	Ашиглаж буй техник хэрэгслүүдийг автотээврийн хяналтын үзлэгт оруулах	-	Уурхайн хөдөлгөөнт техникүүд болох экскаватор, өөрөө буулгагч, дугуйт ачигч, грейдэр, бульдозерууд болон хөнгөн тэргийг тус тус тээврийн хэрэгслийн техникийн үзлэг, оношилгоонд бүрэн хамруулсан.	100%
5.1.8	Агаарын чанарын хяналтын станцын тоог нэмэгдүүлэх	3 ш	2025.03.31-ний өдөр “Грийн трендс” ХХК-тай байгуулсан ЭТТ-2025/96 дугаартай гэрээний дагуу Aeroqual AQM65 агаарын чанарын 1 ширхэг станц худалдан авч байрлуулан хэмжилтийг тогтмол хийж байна.	33%

5.1.1 Тоос бууруулах бодисыг технологийн замд ашиглах

2021-2023 онуудад тоосжилтыг бууруулах зорилгоор замын гадаргууг хайрга, дайргаар хучих, замын гадаргуугийн чийгийн агууламжийг нэмэгдүүлж усалгаа хийх мөн

ус үл нэвтрүүлэх давхарга үүсгэх, хөрсийг барьцалдуулж нягтруулан бүрхүүл үүсгэх зэрэг аргуудаас тохиромжтой хувилбарыг сонгохоор 2-3 төрлийн тоос бууруулах бодисыг Цанхийн уурхайн хэмжээнд турших ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

2024 онд уг туршилтад үндэслэж уурхайн нийт гадаргын замын хэмжээг гаргаж түүнд шаардагдах тоос бууруулах бодисын тооцоог гаргасан. Тооцоогоор уурхайн нийт гадаргын зам 43.4 км байгаа ба өмнөх туршилт хийгдсэн бодисуудаас “Эко сойл” ХХК-ийн нийлүүлдэг Лигно уусмал харьцангуй өндөр үр дүнтэй гэж үзсэн.


Тайлант онд Цанхийн уурхайд нийтдээ 8.45 км технологийн автозамд тоос барьцалдуулагч DUST-LOC PLUS болон Лигносульфит төрлийн бодисыг ашигласан. Үүнээс Цанхийн зүүн уурхайд “Эко сойл” ХХК-ны нийлүүлдэг DUST-LOC PLUS бодисыг 5 км технологийн замд, Цанхийн баруун уурхайд мөн адил бодисыг 0.55 км технологийн замд, Лигносульфит бодисыг 2.9 км технологийн замд ашигласан байна.

Цанхийн зүүн уурхайн олборлолтоос үүсэж буй орчны тоосжилт бууруулах, технологийн замын байгуулалтыг стандартын дагуу гүйцэтгэх зорилгоор Хөрсний 3-р овоолгын 2-р замын 2.5 км урттай, 2 эгнээ бүхий (нийт 5 км) технологийн замд DUST-LOC PLUS бүтээгдэхүүн хэрэглэж, өмнөх болон дараах үеийн 48 цагийн харьцуулсан хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Тоосны харьцуулсан хэмжилтээр тоосжилт 77.03%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Технологийн замд тоос бууруулах бодис ашиглаж эхлэхээс өмнө замын суурь бүтцийг сайтар засаж бэлдэх нь дараагийн ажилд ихээхэн тустай болохыг 2024 онд хийгдсэн туршилт судалгааны явцад анзаарагдсан тул тайлант онд тоос бууруулах бодис ашиглаж эхлэхээс өмнө замын суурь бүтцийг сайжруулах ажил хийгдсэн. Уг ажлаар Технологийн замын 5 км урттай 15 метрийн өргөнтэй хэсэгт хийгдэх нийт 78750 м² талбайд 20 см зузаантайгаар дэвсэлт хийн нягтруулахад 15750 м³ дэвсэлтийн материал буюу шар 4725 м³ (30%), саарал 11025 м³ (70%) материал шаардлагатайг уурхайн ахилтаас гарч буй хаягдал хөрснөөс шаардлага хангаж буй материалыг түүвэрлэн авч нөөцлөн хооронд нь хольж багсарч бэлтгэсэн.



Зураг № 2. Шар, саарал материалыг нөөцөлсөн талбайгаас тусад нь салган , 70:30 харьцаагаар холилт хийж, зам дээр дэвсэхэд бэлдэж буй байдал



Зураг № 3. Цанхийн зүүн уурхайн тоос бууруулах бодис ашигласан замын байршлын зураг


Тоос бууруулах бодисыг усанд найруулах замаар гадаргууд тэгш хүртээмжтэй байдлаар цацаж хэрэглэдэг бөгөөд усан дахь натрийн өндөр агууламжтай (цахилгаан дамжуулах чанар $EC > 1.5 \text{ ms/cm}$) усанд полимерийн бүтэц задрах, бодис шингэн хэлбэрт жигд уусаж, гадаргууд тархах чадвар, наалдац муудаж, тоос дарах чадварт нөлөөлдөг болох нь туршилтуудаар тогтоогдсон байдаг тул бодисыг найруулах усны шинжилгээг Цанхийн зүүн уурхайн ашиглалтын худгууд дундаас дээж авч шинжилгээнд хамруулан сонголтыг хийсэн.

Хүснэгт № 8. Усны дээжийн шинжилгээний хариу


№	Усны эх үүсвэрийн дугаар	pH	Цахилгаан замжуулах чадвар, EC, ms/cm
1	Худаг №18	7.71-7.75	0.960
2	Худаг №20	7.20	1.619
3	Худаг №22	7.73	0.954
4	Худаг №24	6.98-7.29	12.23-13.52
5	Загийн усны хоолойн гүний ус	8.37	3.37
6	Гадаргын тогтоол ус	8.37	0.681

2025 оны VIII сард хур бороо олон удаа, давтамжтай орсны улмаас S талбайн урд талын ус хураах талбайд тогтоол ус нэлээд хэмжээгээр хуримтлагдсан ба уг тогтоол усыг ашиглах боломжийг судалж, дээж авч, лабораторийн EC шинжилгээнд хамруулахад усны EC үзүүлэлт нь стандарт шаардлагад нийцэж, тоос бууруулах бүтээгдэхүүн найруулахад технологийн хувьд тохиромжтой болох нь батлагдсан. Гэвч тогтоол усны шаврын хэмжээг хянах боломжгүй нөхцөл байдлын улмаас бодис найруулах усаар 18 болон 22-р худгийн усыг сонгон авсан.

2024 оны туршилтаар тоос бууруулах бодис ашиглах замын суурь бүтцийг сайжруулсанаар бодисын ашиглалтын хугацаа уртсах, зарцуулах бодисын хэмжээ буурах дагаад зарцуулах хөрөнгө буурахаар байсан тул тайлант онд бодис ашиглах замыг дараах байдлаар сайжруулалт хийхээр төлөвлөсөн.



Зураг № 4. Замын суурь бүтцийн сайжруулалт хийх төлөвлөгөөний зураг



Зураг № 5. Замын зорчих хэсгийн хөндлөн огтлолын зураг

Дээрх төлөвлөгөөний дагуу нийт бодис ашиглах замын зорчих хэсгийн гадна талруу 2%-ын налуутай байхаар замын хотгор хэсгийг урьдчилан бэлтгэж хураасан дэвсэлтийн материалаар дүүргэлт хийсэн.



Зураг № 6. Зорчих хэсгийн налуууг 2% болгосон байдал болон налуууг даган ус урсаж буй байдал

Анхны төлөвлөснөөр зөвхөн замын хонхор хэсгүүдэд саарал материалаар дүүргэлт хийсэн боловч их хэмжээний борооны нөлөөгөөр зарим хэсэгт цөмрөлт үүссэн байна. Үүний улмаас замын даац болон ашиглалтын найдвартай байдлыг хангах зорилгоор зорчих хэсгийн бүхэлд нь саарал материалаар дэвсэлт хийж, харин хонхор, хэвгий хэсгүүдэд илүү зузаан дүүргэлт хийж сайжруулсан.



Зураг № 7. Замын хотгор хэсэгт 30-40 см зузаантай дүүргэлт хийсэн байдал

Хур тунадас орсон үед зорчих хэсэг дээрх ус нэг тал руугаа шуудуугаар дамжин зайлуулагдана. Шуудууны гүн 50 см байна. Хэрвээ хөмсөгнөөс нурж орсон материал (түйрэн) шуудууг дүүргэвэл тодорхой давтамжтай сэргээх, дахин хэлбэржүүлэх ажил хийгдэнэ.



Зураг № 8. Замын ус зайлуулах шуудуйны төлөвлөлтийн зураг




Зураг № 9. Замын ус зайлуулах шуудуйг хийж буй байдал

Тоосжилт бууруулах бүтээгдэхүүнийг хэрэглэх үед цаг агаарын нөхцөл, ялангуяа температурын нөлөө чухал үүрэгтэй байдаг. Хурц нартай, халуун өдөр бүтээгдэхүүн хурдан ууршиж, үр нөлөө буурах хандлагатай тул цацалтын ажлыг агаарын температур ойролцоогоор 20°C-ээс доош сэрүүвтэр нөхцөлд хийхийг зорьсон. Иймд бүтээгдэхүүнийг цацах ажлыг өдрийн температурын нөхцлийг тогтмол харгалзан төлөвлөж хэрэгжүүлсэн.

Хүснэгт № 9. Бүтээгдэхүүний найрлагын шинж чанарын тодорхойлолт болон замд ашиглах харьцаа

№	Бүтээгдэхүүний нэр	Олон улсын нэршил	Физик, химийн шинж чанар, үйлчлэл	Хэрэглэх DUST-LOC PLUS бодисын найрлага, харьцаа
1	Лигнин	Lignit	Цайвар цагаан, шингэвтэр. Усанд сайн уусна	2.5 тонн
2	Синтетик полимер	Synthetic copolymer	Сүүн цагаан. Хөрс барьцалдуулагч	4 тонн
3	Битум эмульс	Bituminous emulsion	Бараан бор, шингэвтэр. Хөрс тогтворжуулагч	1 тонн



Зураг № 10. Тоос бууруулах бодис ашиглах ажлын технологи дараалал



Зураг № 11. Замын өнгөн хэсгийг автогрейдрээр суллаж бодисийн эхний холилт хийж буй байдал



Зураг № 12. Бодис цацсан замыг автогрейдэрээр холилт хийн индүүдэж нягтруулах, нягтруулсаны дараах гадаргуугын бодис цацалт хийж буй байдал



Зураг № 13. Бодисыг замын гадаргад цацалт хийсний дараагаар техникээр дугуйн мөр даруулж нягтруулж буй байдал

Хүснэгт № 10. Бодисыг технологийн замд ашиглах давтамжийн хүснэгт

Зарцуулалт	Эхний цацалт Замын хөрстэй холих	Хоёрдахь цацалт	Гуравдахь цацалт	Дөрөвдэх цацалт
Устай найруулах харьцаа	1/4 (40%) 1/9* (10%)	1/9* (10%)	1/9* (10%)	1/9* (10%)
Цацалт хоорондын давтамж	-	Дараагийн 7 хоногт 1 удаа	Дараагийн 14 хоногт 1 удаа	Сард 1 удаа
1м ² талбайд цацалт хийх зарцуулалт	-Хөрстэй холиход DUST-LOC PLUS 7-8 л/м ² -Гадаргын цацалт DUST-LOC 1-2 л/м ²	DUST-LOC 1 л/м ²	DUST-LOC 0.5-1 л/м ²	DUST-LOC 0.5-1 л/м ²




Зураг № 14. Тоосжилт бууруулах ажлын дараах замын дроны зураг (3.1-р зам, 3.2-р замын харьцуулалт)



Зураг № 15. Тоос бууруулах бодис ашигласны дараах тоосжилт буурсан байдал


Тоос бууруулах бодис ашигласан замын суурь бүтцийн засвар үйлчилгээ хийх ажлыг нийтдээ 24 хоногийн хугацаанд 9 төрлийн техник ашиглаж 624.8 мото/цаг ажил хийгдсэн. Бодис ашиглах, цацах ажилд нийт 35 хоногийг зарцуулсан ба 8 төрлийн техник ашиглаж 953.9 мото/цаг ажилласан. Ингэснээр уг ажилд нийтдээ 13 техник 1578.7 мото/цаг ажилласан байна.



Диаграмм № 1. Нарийн ширхэгт тоосны хэмжилтийн үр дүнгийн диаграмм

Тоосжилтын түвшнийг DUST-LOC PLUS бүтээгдэхүүн хэрэглэхийн өмнө болон дараа харьцуулсан хэмжилт хийхэд тухайн замын нөхцөлд тоосжилтыг 77.03 хувиар бууруулсан, үр нөлөө өндөртэй болох нь хэмжилтийн дүнгээс харагдаж байна. (Хавсралт №2. Хуудас 2-52)

Цанхийн баруун уурхайд тоос бууруулах бодис ашиглах ажлын хүрээнд Үндэсний оператор түншлэлийг төлөөлж “Эрдэс Майнинг Оператор” ХХК нь “Майнинг технологи экуйпмент” ХХК-тай Лигносульфани төрлийн бодис худалдан авах №2025/05 дугаартай гэрээт байгуулан Цанхийн баруун уурхайн хөрсний 3-р овоолгын технологийн 2-р замын 2.9 км технологийн замын 80387 м² талбайд тоос бууруулах бодис ашигласан.



Зураг № 16. Цанхийн баруун уурхайн хөрсний 3-р овоолгын тоос бууруулах бодис ашиглах талбайн байршлын зураг

Бодис ашиглахын өмнө 3-р овоолгын технологийн 2-р замын эвдрэлтэй хэсгүүдэд шороон материалаар дэвсэлт хийж гадаргуугын тэгш байлгах байдлыг хангасан.




Зураг № 17. Бодис ашиглах талбайн зам арчилгааг хийж бэлэн болгосон байдал

Тоос бууруулах бодисыг усны машинд хийж зохих хэмжээгээр найруулан технологийн замд цацах ажлыг хийж гүйцэтгэсэн. (Хавсралт №2. Хуудас 2-52)




Зураг № 18. Тоос бууруулах Бодисыг усны машинд найруулан цацаж буй байдал


“Үндэсний манлайлал түншлэл”-ийг төлөөлж “Макс гүүр транс” ХХК нь “Эко сойл” ХХК-тай гэрээ байгуулан DUST-LOC PLUS бодисыг Цанхийн баруун уурхайн технологийн 5-р замын 0.55 км технологийн замын 4950 м² талбайд бодис ашиглах ажил хийгдсэн. (Хавсралт №2. Хуудас 2-52)



Зураг № 19. Тоос бууруулах бодис ашигласан замын байршлын зураг болон бодис цацах замыг сийрүүлж буй байдал



Зураг № 20. Тоос бууруулах бодис хольсон хөрсийг тараан автогрейдэр индүүгээр нягтруулж буй байдал



Зураг № 21. Тоос бууруулах Бодисыг гадаргууд дахин цацаж буй байдал




Зураг № 22. Тоос бууруулах бодис ашигласны дараах байдал

Тайлант онд Цанхийн уурхайд нийтдээ 8.45 км камд тоос бууруулах бодис ашиглаж буй бөгөөд зөвхөн эдгээр замд ашиглах тоос бууруулах бодис худалдан авах зардалд ойролцоогоор 1.9 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгээд байна.

5.1.2 Уурхайн ашиглалтын замыг сайжруулах, материал, дэвсэлт хийх

Уулын ашиглалт болон төлөвлөлтийн нэгжтэй хамтран уурхайн технологийн зам талбай болон хөрсний овоолгын ачаалал ихтэй, тоосжилт ихээр үүсгэж буй зам талбай, уулзвар эргэлтийг тодорхойлж тоосжилтыг бууруулах зорилгоор зам талбайг чийглэх усалгааны уламжлалт аргыг хэрэглэж байгаагаас гадна замын арчилгааг тогтмол хийж улаан шаварлаг материал, хайрга, дайрга дэвсэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлдэг.



Зураг № 23. Цанхийн уурхайнуудын сарын зам арчллаганы төлөвлөгөөний зураг

Гэрээт байгууллагууд тухайн төлөвлөгөөний дагуу шаардлагатай хайрга дайрга, улаан шаварлаг материалыг татан авч өдөр шөнийн ээлжинд заагдсан талбайд дэвсэж,

түйрэнг хусан замын арчилгааг хийж гүйцэтгэн KPI үнэлгээний тайланд тухайн сарын зам арчилгааны тайлан мэдээг тогтмол ирүүлж ажилладаг.



Зураг № 24. Технологийн замд улаан шаварлаг материал дэвсэж сайжруулалт хийж буй байдал

Тайлант онд Цанхийн баруун уурхайд нийтдээ 72.9 га, 338.2 км зам талбайд 95,591 м³ шаварлаг материал дэвсэж сайжруулах ажил, Цанхийн зүүн уурхайд нийтдээ 11.8 га, 3.8 км зам талбайд 88,113 м³ шаварлаг материал дэвсэж сайжруулах ажил, Цанхийн нийт уурхайн хэмжээнд 84.7 га талбайд 183,704 м³ шаварлаг материал дэвсэж нийт 342 км технологийн автозамд сайжруулах ажил хийгдсэн байна. (Хавсралт №3. Хуудас 53-69)

5.1.3 Уурхайн зам талбай, нүүрсний агуулах, гаалийн талбайд усалгааны машиныг тогтмол ажиллуулах

Уурхайн өдөр шөнийн ээлжинд Цанхийн баруун уурхайд 18 усны машин, Цанхийн зүүн уурхайд 10 усны машин, “Эрдэнэс Таванолгой” ХК-ийн 2 усны машин, нүүрсний


агуулах болон гаалийн хяналтын талбайд 3 усны машин, нийт 33 машин ажиллаж усалгаа хийгддэг ба энэ оны эхний 10-н сарын байдлаар нийт 738,062 м³ усыг зам усалгаанд ашигласан байна. Үүнээс 459,654 м³ хур борооны хуримтлагдсан ус, 88,428 м³ уурхайн шүүрлийн ус, 69,665 м³ цэвэршүүлсэн саарал ус, 120,315 м³ гүний усыг авч ашигласан байна. Энэ нь өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад зам талбайн тоосжилт дарах усалгаанд ашигласан нийт усны хэмжээ 2.5 дахин, хур борооны хуримтлагдсан усны хэрэглээ 2.85 дахин, шүүрлийн ус 2 дахин, саарал усны хэрэглээ 2 дахин нэмэгдэж, гүний худгаас буюу газрын гүний усны хэрэглээ мөн адил 2 дахин нэмэгдсэн байна.

Ашигласан усны хэрэглээг үндэслэн 2025 онд Өмнөговь аймгийн төрийн сангийн дансанд 92,134,305.47 төгрөг төвлөрүүлсэн байна. (Хавсралт №4. Хуудас 70-72)

Хүснэгт № 11. 2025 оны эхний 10 сарын дараах байдлаар усны хэрэглээний хүснэгт

Зориулалт	Зам усалгаа				Унд ахуй	Мод усалгаа	Нийт	
Нийт	828,942				28,854	8,776		
Эх үүсвэр	Хур бороо	Шүүрэл	Худаг	Саарал ус	Худаг	Худаг	Нийт	
I	29,360	3,562	15,237	5,775	3,038	-		56,972
II	23,075	8,037	15,591	4,530	2,892	-		54,125
III	55,526	16,654	11,760	8,896	2,768	24		95,627
IV	53,410	14,866	13,626	14,164	2,828	980		99,874
V	68,657	23,914	9,412	6,053	2,243	1,700		111,979
VI	54,329	15,121	14,780	6,185	2,711	1,366		94,492
VII	46,186	740	17,053	4,981	3,208	1,285		73,453
VIII	44,814	5,534	13,977	13,268	3,610	1,285		82,488
IX	84,297	-	8,879	5,813	2,857	1,577		103,423
X	81,034	-	5,468	4,378	2,699	559		94,138
Нийт	540,688	88,428	125,783	74,043	28,854	8,776	866,571	

Зам усалгаанд ашигласан 828,942 м³ уснаас Цанхийн баруун, зүүн уурхайн болон нүүрс ачилтын талбайн ус ашиглалтын байдлыг авч үзвэл Цанхийн зүүн уурхай нийт ашигласан усны 40%-ийг, Цанхийн баруун уурхай 50%-ийг Нүүрс ачилтын хэсэгт 10%-ийг тус ашигласан байна.




Диаграмм № 2. Зам усалгаанд ашиглаж буй усны эх үүсвэрийн диаграмм

5.1.4 Уурхайн дотоод зам талбайд шороон зам дээгүүр зорчиж буй хөнгөн тэрэг болон уулын машин механизмуудад хурдны хязгаар тогтоож, гэнэтийн хэмжилт шалгалт хийж, хяналт тавьж ажиллах

Салбарын захирлын А/32 тоот тушаалаар “Уурхайн замын хөдөлгөөний журам” (ЭТТ-СА-Ж17-ХАБ-Ж03-Х03) дугаар бүхий журмыг 2023 оны 06-р сарын 06-ны өдөр батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Уг журамд Технологийн зам (уурхайн

ухаш, гадаргуу, овоолго)-д 40 км/цаг, налуу замд 20 км/цаг, ачилт болон буулгалтын талбайд 20 км/цаг, засвар болон зогсоолын гадна талбайд 10 км/цаг, засварын байр болон автожин дээр 5 км/цаг хурдтай байхаар зааж өгсөн.



Зураг № 25. Батлагдсан Уурхайн замын хөдөлгөөний журмын зураг

Уурхайн замын хөдөлгөөнд оролцож буй техникүүдийн хурд хэмжилтийг “Эрдэнэс Тавантолгой” ХК болон гэрээт туслан гүйцэтгэгч байгууллага болгон Хөдөлмөрийн аюулгүй байдлын инженер нар тогтмол 7 хоног бүр гэнэтийн хэмжилтийг хийдэг бөгөөд оны эхний 10 сарын дараах байдлаар Цанхийн зүүн уурхайд 227 удаа, Цанхийн баруун уурхайд 558 удаа, нийтдээ 785 удаа хэмжилтийг хийсэн байна.



Зураг № 26. Хурдны гэнэтийн шалгалт хийж буй байдал

Газрын хэргэсний хураангуйн хэргэсний тайлан					
Бичлэг	Хүснэгт	Хүснэгт	Хүснэгт	Хүснэгт	Хүснэгт
1	135.30	7001	Тонли	39	ГМ
2		7765	МТЭ	36	ГМ
3		7447	Наша	35	ММЭ
4		7004	Тонли	29	ГМ
5		7767	МТЭ	32	ГМ
6		7747	Наша	29	ГМ
7		7764	МТЭ	26	ГМ
8		7008	Тонли	20	ГМ
9		7150	Наша	29	ММЭ
10		6078	Лондон	32	ЭМЭ
11		7767	МТЭ	34	ГМ
12		7451	Наша	28	ММЭ
13	10:45	7008	Тонли	24	ГМ
14		7748	Наша	30	ГМ
15		7003	Тонли	30	ГМ
16		7479	Наша	32	ММЭ
17		7762	МТЭ	29	ГМ
18		7001	Тонли	30	ГМ
19		7732	Наша	24	ГМ
20		7749	Наша	26	ГМ
21		7766	МТЭ	26	ГМ
22		7442	Наша	32	ММЭ
23		7006	Тонли	33	ГМ

Зураг № 27. Хурд хэмжилтийн бүртгэлийн хуудасны зураг

5.1.5 Кемп хоорондын шороон зам болон ачаа тээврийн авто машинуудыг хатуу хучилттай авто замаар зорчуулах тал дээр хяналт тавьж ажиллах

Цогтцэций-Даланзадгад чиглэлийн замаас Баруун нарангийн автозам хүртэлх 7.4 км автозамын арчилгаа хийх хуваарийг Салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны газрын даргаар батлуулан гэрээт байгууллагуудын сар бүрийн төлөвлөгөөнд тусган тухай бүрт хийлгүүлэн ажилласан. (Хавсралт №24. Хуудас 178-180)

БАТЛАВ,
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ
БАЙДАЛ,БАЙГАЛЬ ОРЧНЫ
ГАЗРЫН ДАРГА

Б.БАТСАЙХАН

2025 оны 01 дүгээр сарын 30-ний өдөр

Өмнөговь, Цогтцэций сум

НҮҮРС ТЭЭВРИЙН 7.4 КМ САЙЖРУУЛСАН ШОРООН ЗАМЫН
АРЧИЛГАА ХИЙХ ХУВААРЬ
















№	Аж ахуйн нэгжийн нэр	I/24- II/24	II/25- III/25	III/26- IV/26	IV/27- V/27	V/28- VI/28	VI/29- VII/29	VII/30- IX/30	X/01- XI/01	XI/02- XII/02
1	"Ти Эн Түншлэл"									
2	"Кэй Эй Майнинг" ХХК									
3	"Үндэсний Оператор Түншлэл"									
4	"Үндэсний Уурхайчид Түншлэл"									
5	"Үндэсний Мянгайлал Түншлэл"									
6	"Овоот толгой ресурс" ХХК									
7	"Кэй эй рентал сервис" ХХК									
8	"Ти Ти Жи Ви Си Өү" ХХК									
9	"Спейшл мейнинг сервис" ХХК									

Санамж:

- Хуваарьт хуугаанд 7 хоногт нэг удаа зам арчилгааг (шороон даланг сэргээх, зам хусах, түйрэнг түрэх гэх мэт) хийж;
- Замын хоёр талын хөвөөнөөс 2 тийш 100 метрийн радиуст 14 хоног тутамд хог хаягдлыг цэвэрлэх, дэмж зайлуулах;
- Замын эхлэлээс төгсгөл цэг хүртэл зам усалгааг өдөр бүр хийж;
- Замын арчилгаа, хог хаягдлын цэвэрлэгээ, усалгаа хийх бүрт тайлан боловсруулах;
- "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн байгаль орчны инженерт мэдэгдэж газар дээр нь хяналт, үзлэг хийж тайланг баталгаажуулах;
- Маягтын дагуу боловсруулж, баталгаажуулсан тайланг environment@erdensas.tmn хаяг руу илгээх;
- Баталгаажуулаагүй тайлан илгээсэн тохиолдолд гүйцэтгэсэн ажлын хүчингүйд тооцогүй анхаарах;
- Хуваарийн дагуу даралгийн сард зам арчилгаа хийх компанийн байгаль орчны мэргэжилтэнд талбайг хуульчилж өгөх.

Зураг № 28. Батлагдсан зам арчилгааны хуваарь

Батлагдсан зам арчилгааны төлөвлөгөөний дагуу гэрээт байгууллага бүр зам арчилгааг хийж гүйцэтгэж дараагийн сард тухайн замыг үргэлжлүүлэн арчлах компани болон захиалагч талын Байгаль орчны инженерүүдийг байлцуулан хүлээлгэн өгч ажиллаж байна.

САЙЖУУЛСАН ШОРООН ЗАМ АРЧИЛГААНЫ ТАЙЛАН				
Зам арчилгаа хийсэн огноо:	2025.04.27-05.31	Тайлангийн дугаар:	1	
Компанийн нэр:	ТУТ	Ажилтны овог нэр:	Б.Болортуяа	
Утас:	99251703	Адрес/Тухайлбал:	Байгаль орчны мэргэжилтэн	
Зам арчилгаа хийсэн газрын байршил:	Нууц тээврийн 7.4 км зам Б	Баруун наран-Тост №6 зам	<input type="checkbox"/>	
Арчилгаа хийсэн замын эхлэл болон төгсгөл цэг:	Эхлэл: 43°45'56.68"N 105°26'28.24"E	Төгсгөл: 43°42'17.72"N 105°28'59.77"E		
Байршлын талаарх нэмэлт тайлбар:	Нууц тээврийн 7.4 км сайжруулсан шороон зам дагуу Сайжруулсан шороон зам дагуу Шороон далавг сэргээх зам хураах, хөг цэвэрлэгээ, зам усалгаа			
Зам арчилгаа хийсэн төмөр (мотор бууцаж, шороо):	GR481 LO431 LO430	Зам усалгаа хийсэн төмөр (мотор бууцаж, шороо):	WT-426	Портр 4936 УУН.144229
Ажилласан мото цэг:	48	Ажилласан мото цэг:	12	Ажилласан мото цэг: 40
Түшмэл зарчлалт (т/м²):	680 л	Түшмэл зарчлалт (т/м²):	180	Түшмэл зарчлалт (т/м²): 24 л
Арчилгаа хийсэн замын урт (км):	7.4 км	Заруулсан усны хэмжээ (т/м³):	80	Цэвэрлэсэн хөг хангалтын хэмжээ (т/м³): 7 тн
Арчилгаа хийгээг өмнөх байдал		Арчилгаа хийсний дараах байдал		
				
				
				
				
Хөг хангалтын цэвэрлэгээ хийгээг өмнөх байдал		Хөг хангалтын цэвэрлэгээ хийсний дараах байдал		
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				
				

5.1.6 Нүүрс тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Нүүрс ачилт, логистикийн хэлтэст 4-н ээлжинд нийт 32 хучигч ээлжээр ажилладаг ба нүүрс тээврийн ачаатай машиныг хучих ажлыг хариуцан гүйцэтгэдэг тул хучилт хийлгээгүй машин уурхайн бүсээс гарах боломжгүй байдаг.



Зураг № 31. Ачилтаас гарч буй тээврийн хэрэгсэлд хучлага хучиж буй байдал


2025 оны эхний 3-н улирлын буюу 10-р сарын 01-ны байдлаар 80172 ширхэг нүүрс тээврийн машины ачааг хучиж тээвэрт гаргасан байна.

5.1.7 Уурхайд ажиллаж буй тээврийн хэрэгслүүдийг автотээврийн хяналтын үзлэгт оруулах

Монгол улсын Зам, Тээврийн яамнаас 2024 оны 08-р сарын 05-ны өдрийн 07/20 дугаартай албан бичгээр “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”, “Автотээврийн тухай хууль” болон олон улсын гэрээ конвенц түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хүрээнд зөвхөн нийтийн хэрэгцээний авто замаар хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгсэлд улсын бүртгэлийн дугаар олгож, жил бүрийн техникийн хяналтын үзлэгт хамруулах зохицуулалттай тул уул уурхайд ашигладаг техник хэрэгслийг жил бүр техник хяналтын үзлэгт хамруулах шаардлагагүй тухай мэдэгдсэний дагуу Уурхайн хөдөлгөөнт техникүүд болох экскаватор, өөрөө буулгагч, дугуйт ачигч, грейдэр, бульдозеруудад хяналтын үзлэгт хамруулалгүй зөвхөн хөнгөн тэрэг болон үйлчилгээний автомашинуудыг 2025 оны 04-р сарын 24-ны өдөр Өмнөговь аймгийн “Автотээврийн үндэсний төв”-ийн явуулын оношилгооны инженерээр тээврийн хэрэгслийн техникийн үзлэг, оношилгоонд бүрэн хамруулсан. (Хавсралт №5. Хуудас 73-79)

Хүснэгт № 12. Техник хяналтын улсын үзлэгт хамрагдсан техникүүдийн тоо хэмжээ

№	Уурхай	Компани	Хяналтын үзлэгт орсон техникийн тоо
1	ЦЗУ	“Ти ти жи ви си өү” ХХК	48
2		“Нормаунт” ХХК	32
3		“Эрдэнэс Тавантолгой” ХК	71
4		“Кэй Эй Майнинг” ХХК	24
5	ЦБУ	“Үндэсний Оператор Түншлэл”	20
6		“Овоот толгой ресурс” ХХК	52
7		“Үндэсний манлайлал түншлэл”	23
8		“Үндэсний уурхайчин түншлэл”	37



The image displays three screenshots of the Smartcar website interface, each showing the technical inspection history for a specific vehicle. Each screenshot includes a green summary box on the left and a table of inspection dates on the right.

Улсын дугаар	Зэвгар	Үйлдвэрлэсэн он	Үзлэгт орсон огноо	Үзлэгт дахин орох огноо	Тэнцсэн эсэх
2175VET	Toyota Land Cruiser	2023	2025/04/24	2026/04/24	Тэнцсэн
2617УБХ	NISSAN Patrol	2007	2025/06/06	2026/06/06	Тэнцсэн
2706УАВ	HOWO ZZ1257M4341W	2019	2025/04/24	2026/04/24	Тэнцсэн

Зураг № 32. Техник хэрэгслүүдийг Автотээврийн улсын үзлэгт хамруулсан байдал

5.1.8 Агаарын чанарын хяналтын станцын тоог нэмэгдүүлэх

2025 оны 01 дүгээр сарын 31-нд “Грийн трендс” ХХК-тай ЭТТ-2025/96 дугаар бүхий “Агаарын чанарын суурин станц нийлүүлэх гэрээ”-г байгуулсан. 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр “Грийн трендс” ХХК-тай байгуулсан гэрээгээр Aeroqual AQM65 агаарын чанарын станц худалдан авч грийн центрийн хойно байрлуулан хэмжилтийг тогтмол хийж байна.

<p>БАТЛАВ ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХХ-ийн Гүйцэтгэх Захиулын Үүрэг Гүйцэтгэгч / Х.МӨНӨОКАРГАЛ</p> <p>АГААРЫН ЧАНАРЫН СУУРИН СТАНЦ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ 2025 оны 01 сарын 01 өдөр №ЭТТ-2025/01 Улаанбаатар хот</p> <p>Энэ гэрээг Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, "Эрдэнэс Тавантолгой" ХХ-ийн ЭТТ/ХХ/2024/0102061 дугаартай тендер шалгаруулалтын дүн, 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01/1/04 дугаартай "Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл"-ийг тус тус үндэслэн нэг талаас 5435528 регистрийн дугаартай "Эрдэнэс Тавантолгой" ХХ (цаашид "Захиалагч" эх), түүнийг төлөөлж Хөдөлмөрчин аюулгүй байдал, байгаль орчны газрын дарга Б.Батсайхан, нөгөө талаас 5551358 регистрийн дугаартай "Грийн трендс" ХХК (цаашид "Нийлүүлэгч" эх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Батжаргал (цаашид хэвлэлд нь "Талууд" эх) нар дараах нөхцөлөөр харицдан төмөрлөхөд "Агаарын чанарын суурин станц нийлүүлэх гэрээ" цаашид "Гэрээ" эхэж байгуулав</p> <p>НЭГ, НИЙЛЛЭГ ҮНДЭСЛЭЛ</p> <p>1.1. Энэхүү гэрээгээр Нийлүүлэгч нь техникийн тодорхойлолт (Гэрээний хавсралт №3)-т заасан шаардлага хангасан Агаарын чанарын суурин станц (цаашид "Бараа" эх)-ийг энэ гэрээнд заасны дагуу Өмнөговь аймгийн Цогцолцай суманд байрлах Захиалагчийн уурхайн хүрээ нийлүүлэх, Захиалагч гэрээнд заасан Барааны үнийг төлөхөд холбогтойгоор Талуудын хөрөнд уусаж харилцааг зохицуулна.</p> <p>ХОЁР, ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА</p> <p>2.1. Энэхүү гэрээ нь байгуулагдсан өдрөөс хойш 6 (зургаа) сарын хугацаатай байна.</p> <p>2.2. Барааг гэрээ байгуулснаас хойш хуулийн 60 хоногийн дотор нийлүүлнэ. Нийлүүлэгч нь гэрээнд заасан үүрэг бүрэн биелүүлж, үйлдвэрийн болон механик ямар нэгэн гэмтэл доромжгүйгараа Захиалагчид хүлээлгэн өгч, Талууд бараа хүлээлгэн болон гэрээ дүнгэсн акт үйлдэнэ.</p> <p>2.3. Барааны баталгааг хугацаа бараа нийлүүлснээс хойш 12 сар байна.</p> <p>ГУРАВ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ</p> <p>3.1. Гэрээний үнэ буюу нийт төлбөр 228,104,384.3 (хоёр зуун хорин найман сая нэг зуун дөрвөн мянган зургаа зуун найн дөрвөн төгрөг гучин мөнгө) төгрөг ба энэ үндэс НБАТ болон бусад татвар, хуримал, Захиалагчийн салбар уурхайд хүрээж хүлээлгэн өгөх зэрэг шаардлагатай бүх төлбөр багтсан болно.</p>	<p>ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТ 2025 оны 01 сарын 01 өдөр Улаанбаатар хот</p> <p>Нэг, Ерөнхий зүйл</p> <p>1.1.Нэг талаас "Эрдэнэс Тавантолгой" ХК (цаашид "Захиалагч" гэх), нөгөө талаас "Грийн трендс" ХХК (цаашид "Нийлүүлэгч") нар (хамтад нь "Талууд" гэх) -ын хооронд 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр байгуулсан ЭТТ-2025/96 дугаартай "Агаарын чанарын суурин станц нийлүүлэх гэрээ" цаашид "Гэрээ" гэх)-ээр хүлээсэн талуудын үүрэг дуусгавар болсонтой холбогдуулан гэрээг дүгнэж, тооцоо нийлэв.</p> <p>Хоёр, Гэрээний дүгнэлт</p> <p>2.1. Нийлүүлэгч гэрээний 2.2-т заасан хугацаанд буюу 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Захиалагчийн Өмнөговь аймгийн Цогцолцай суманд байрлах Салбар уурхайд ирж гэрээний хавсралт 3-т заасан техникийн тодорхойлолтын дагуу шаардлага хангасан агаарын чанарын суурин станц (цаашид "Бараа" гэх)-ыг холбогдох тоноглолуудын хамт суурилуулан, уусгарч, төхөөрөмжийн ашиглалттай холбоотой сургалт, танилцуулга орж Талууд бараа хүлээлгэсэн акт үйлдсэн.</p> <p>2.2. Захиалагч нь гэрээний 3.1-т заасны дагуу гэрээний нийт үнэ болох 228,104,384.3 (Хоёр зуун хорин найман сая нэг зуун дөрвөн мянга зургаа зуун найн дөрвөн төгрөг гучин мөнгө) төгрөгөөс чанарын баталгааны 5 хувь болох 11,405,219.215 (Арван нэгэн сая дөрвөн зуун таван мянга хоёр зуун арван есөн төгрөг хоёр зуун арван таван мөнгө) төгрөгийг хасах үлдэх төлбөр болох 216,699,165.085 (Хоёр зуун арван зургаан сая зургаан зуун ерэн есөн мянга нэг зуун эхрэн таван төгрөг найн таван мөнгө) төгрөгийг холбогдох баримт бичгийг үндэслэн энэхүү гэрээ дүнгэсн акт үйлдэгдсэнээс хойш 14 хоногийн дотор Нийлүүлэгчийн нэр дээрх Голтумт банкны 1205032674 тоот дансанд шилжүүлнэ.</p> <p>2.3 Энэхүү гэрээ дүгнэх актыг үйлдсэнээр гэрээний 2.3-т заасан Нийлүүлэгчийн баталгааг хугацааны үүрэг дуусгавар болохгүй бөгөөд барааны баталгааг хугацаа 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болоход гэрээний 3.3-т заасан чанарын баталгааг Нийлүүлэгч талд буцаан олгоно. Энэ хугацаанд бараанд илэрсэн аливаа доголдлыг Нийлүүлэгч өөрийн зардлаар хүлээн зөвшөөрөв.</p> <p>Гурав, Бусад</p> <p>3.1. Талууд энэхүү гэрээ дүгнэх актад гарын үсэг зурж баталгаажуулснаар гэрээг дуусгавар болсныг хүлээн зөвшөөрсөн бөгөөд энэхүү гэрээ дүнгэсн актын талаар аливаа гомдол, нэхэмжлэл гаргахгүй байхвар харилцан тохиролцов.</p>
--	--


Зураг № 33. Багаж худалдан авах гэрээ болон гэрээ дүгнэсэн акт




Зураг № 34. Агаарын чанарын суурин станцыг суурилуулан хэмжилт хийж буй байдал

Тайлант онд нийт 3-н байршилд агаарын чанарын станц байрлуулах байснаас одоогийн байдлаар нэг байршилд байгуулсан бол үлдсэн 2 байршилд байрлуулах багажний төсвийг компанийн 2025 оны төсөвт суулган захиалгыг 2025 оны 02-р сарын 27-ны өдөр Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн.

Компанийн мөнгөн хөрөнгийн эргэлт болон санхүүгийн байдал, компанид онц дэглэм тогтоосон зэргээс шалтгаалан энэ худалдан авалт хойшилсон бөгөөд 2025 онд багтаан тендер шалгаруулалтыг хийхээр төлөвлөж ажиллаж байна.



Зураг № 35. Агаарын чанарын суурин станц захиалгын хуудас



Зураг № 36. Агаарын чанарын суурин станцын дата мэдээлэл харагдаж буй байдал


5.2 Гадаргын болон газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
5.2.1	Ашиглалтын худгуудад бохирдол үүсэхээс сэргийлэн холбогдох шаардлага, стандартын дагуу худгийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих	Нийт худаг	Унд ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж буй худгуудын усны чанар, түвшингийн өөрчлөлт, ундарга зэргийг тогтмол хянах зорилгоор түвшингийн хэмжилтийг 7 хоногт 2 удаа, ундаргын тооцооллыг сард 1 удаа, усны шинжилгээг улиралд 1 удаа тус тус хийж гүйцэтгэн ажиллаж байна. Мөн хэмжилтийн үр дүнг боловсруулж, хагас жил болон жилийн эцсийн байдлаар ус ашиглалтын тайланг боловсруулж, Өмнөговь аймгийн БОАЖГ, ГӨДСГ, Усны газарт тус тус тогтмол тайлагнан ажиллаж байна.	100%
5.2.2	Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрлийг холбогдох журмын дагуу авч, ус ашиглах гэрээ байгуулан ажиллах	1	Цанхийн зүүн уурхайн 2025 оны ус ашиглах дүгнэлтийг 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Е-2501-000417 дугаартай, Цанхийн баруун уурхайн ус ашиглах дүгнэлтийг 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Е-2502-000031 дугаартай гаргуулсан. (Хавсралт №6. Хуудас 80-83) “Галба Өөш Долоодын Говийн Сав газрын захиргаатай 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 2025/16, ЕТТ-2025/354, 2025/15, ЕТТ-2025/355 дугаартай Ус ашиглах гэрээг байгуулсан. (Хавсралт №7. Хуудас 84-86)	100%
5.2.3	Усны нөөц ашиглуулах дүгнэлтэд заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй ашиглах, ус ашигласны төлбөр хураамжийг төлж барагдуулах	Сар бүр	Худгаас ашигласан усны ашиглалт тус бүрээр үзвэл унд ахуйн усны хэрэглээ 3%, мод усалгаанд ашиглаж буй усны хэрэглээ 1%, зам усалгаанд ашиглаж буй усны хэрэглээ 96% байна. Нийт ашигласан усанд эзлэх Худгийн усны хэрэглээ 14.5%, шүүрлийн усны хэрэглээ 10.2%, гадаргын усны хэрэглээ 62.4%, дахин ашигласан буюу саарал усны хэрэглээ 8.54%-ийн гүйцэтгэлтэй байна. (Хавсралт №4. Хуудас 70-72)	100%
5.2.4	Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрлийг холбогдох журмын дагуу авч, гэрээ байгуулан ажиллах	Улирал бүр	Хаягдал ус зайлуулах зөвшөөрлийг үндэслэн “Хаягдал усыг байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй байгуулах ус бохирдуулсны төлбөрийн гэрээ”-г 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр Галба-Өөш, Долоодын Говийн сав газрын захиргаатай 2025/01, ЭТТ-2025/272 дугаартай гэрээг байгуулсан. (Хавсралт №9. Хуудас 88) Гэрээний дагуу улирал тутам цэвэрлэх байгууламжуудын оролт, гаралтын бохир уснаас дээж авч лабораторид шинжлүүлэн Усны газраар төлбөрийн тооцоог гаргуулан төлбөрийг тогтмол төлж байна. (Хавсралт №10. Хуудас 89-91)	100%

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
5.2.5	Хаягдал усыг стандартын шаардлага хангасан цэвэрлэх байгууламжид цэвэршүүлэн саарал ус гаргаж зам талбайн тоосжилт дарах, мод усалгаанд ашиглах		2025 оны эхний 10 сарын байдлаар нийт 42,971.0 м3 саарал усыг дахин ашигласан бөгөөд эдгээр усыг “Энержи ресурс” ХХК-ны цэвэрлэх байгууламж болон “КА майнинг” ХХК-ны цэвэрлэх байгууламжаас авч нүүрс ачилтын талбайн тоосжилт дарах усалгаанд ашигласан байна.	100%
5.2.6	Газрын доорх усны нөөц, чанарт тогтмол хяналт тавих	3 цэгт	Унд ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж буй худгуудын усны чанар, түвшингийн өөрчлөлт, ундарга зэргийг тогтмол хянах зорилгоор түвшингийн хэмжилтийг 7 хоногт 2 удаа, ундаргын тооцооллыг сард 1 удаа, усны шинжилгээг улиралд 1 удаа тус тус хийж гүйцэтгэн ажиллаж байна. Мөн хэмжилтийн үр дүнг боловсруулж, хагас жил болон жилийн эцсийн байдлаар ус ашиглалтын тайланг боловсруулж, Өмнөговь аймгийн БОАЖГ, ГӨДГСГ, Усны газарт тус тус тогтмол тайлагнан ажиллаж байна.	100%
5.2.7	Ус ашиглалтын бүх эх үүсвэрээс ашиглах усны хэмжээг зөв тодорхойлох зорилгоор тоолууржуулах		Уурхайн ашиглалтын худгуудыг бүрэн тоолууржуулсан. Сар бүр ус ашиглалтын хэмжээг гаргаж Сумын Уул уурхай ус хариуцсан байцаагчаар акт үйлдэж баталгаажуулсан.	100%

5.2.1 Ашиглалтын худгуудад бохирдол үүсэхээс сэргийлэн холбогдох шаардлага, стандартын дагуу худгийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих

Салбар уурхайд 2025 оны байдлаар унд ахуй үйлдвэрлэлийн зориулалтаар 25 худаг ашиглаж байна. Худгуудын тоолуурын баталгаажуулалт болон худгийн үйл ажиллагаанд үзлэг шалгалтыг тогтмол хийж гүйцэтгэсэн.



Зураг № 37. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн эзэмшлийн худгуудын байршилн зураг

Унд ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж буй худгуудын усны чанар, түвшингийн өөрчлөлт, ундарга зэргийг тогтмол хянах зорилгоор түвшингийн хэмжилтийг 7 хоногт 2 удаа, ундаргын тооцооллыг сард 1 удаа, усны шинжилгээг улиралд 1 удаа тус тус хийж гүйцэтгэн ажиллаж байна. Мөн хэмжилтийн үр дүнг боловсруулж, хагас жил болон жилийн эцсийн байдлаар ус ашиглалтын тайланг боловсруулж, Өмнөговь аймгийн БОАЖГ, ГӨДСГЗ, Усны газарт тус тус тогтмол тайлагнан ажиллаж байна. Энэ тайлангийн 6.2.7-р бүлэг болон 13.2 Усны хяналт шинжилгээний бүлгээс дэлгэрэнгүй тайлантай танилцах боломжтой.

5.2.2 Ус ашиглах дүгнэлт гаргуулж, ус ашиглах гэрээ байгуулах

Усны тухай хуулийн 28.4-т заасны дагуу Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас Цанхийн зүүн уурхайн 2025 оны ус ашиглах дүгнэлтийг 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Е-2501-000417 дугаартай, Цанхийн баруун уурхайн ус ашиглах дүгнэлтийг 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Е-2502-000031 дугаартай гаргуулсан. (Хавсралт №6. Хуудас 80-83)

УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2025 оны 3 дугаар сарын 18 -ний өдөр Улаанбаатар хот
Утас: 265526, 265570

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

Оноосон нэр: Эрдэнэ Таван толгой
Улсын бүртгэлийн дугаар: 5435526
Регистрийн дугаар: 5435526
Захирал: Мөнхжаргал
Холбоо барих дугаар: 75055555
Факс:
И-мэйл хаяг:

2. Төслийн нэр байршил

Төслийн нэр: Цанхийн зүүн уурхай
Байршил: Өмнөговь, Цогтцэций, 3-р баг, Цагаан-Овоо
Харьяалагдах сав газар: Галба-Өөш Долоодын говийн сав газар
Хамарах салбар: Уун уурхай
Төслийн дэлгэрэнгүй: Тавантолгой ордны геологийн тогтоц, судалгааны түвшин, уулын нөхцөл зэрэгээс шалтгаалан Цанхи, Бортээг, Ончараат /Эүүн/, Орсоогч /Баруун Өмнөд/, Бортолгой, Ухаахууд гэсэн 6 хэсэгт хуваагддаг. "Эрдэнэ-Таван толгой" ХК нь Тавантолгойн орд газарт MV-011943, MV-011953, MV-011954, MV-011955, MV-011956, MV-016881, MV-016882, MV-016883 тоот ашиглалтын тусгай зөвшөөрүүдийг тус тус эзэмшдэг. MV-011943 дугаар бүхий 2,036.33 га, MV-016883 дугаар бүхий 700.39 га тусгай зөвшөөрлийн талбайд Цанхийн зүүн хэсгийн уурхайн үйл ажиллагааг 2010 оны 8 дугаар сард эхлүүлсэн.

3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр
Эрдэнэ Таван толгой

4. Ажиллах горим, хүчин чадал

Үргэлжлэх хугацаа	Ажиллах горим	Жилд ажиллах хоног	Хоногт ажиллах ажилчдын тоо	Хоногт ажиллах цаг
1	2 ээлжээр	365	0	24

УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2025 оны 3 дугаар сарын 18 -ний өдөр Улаанбаатар хот
Утас: 265526, 265578

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

Оноосон нэр: Эрдэнэ Таван толгой
Улсын бүртгэлийн дугаар: 5435528
Регистрийн дугаар: 5435528
Захирал: Мөнхжаргал
Холбоо барих дугаар: 75055555
Факс:
И-мэйл хаяг:

2. Төслийн нэр байршил

Төслийн нэр: Цанхийн баруун уурхай
Байршил: Өмнөговь, Цогтцэций, 3-р баг, Цагаан-Овоо
Харьяалагдах сав газар: Галба-Өөш Долоодын говийн сав газар
Хамарах салбар: Уун уурхай
Төслийн дэлгэрэнгүй: Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших MV-016881, MV-016882 дугаар үндсэн, MV-011956, MV-011954 дугаар нэмэлт ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Цанхийн баруун хэсгийн ил уурхай нь эхний жилдээ 8.44 сая тн, 2 дахь жилдээ 15.35 сая тн, 3 дахь жилдээ 18.1 сая тн нүүрс обьолор 4 дэх жилдээ төслийн бүрэн хүчин чадлаар ажиллах буюу жил тутам 20.0 сая тн нүүрс обьолорно.

3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр
Эрдэнэ Таван толгой

4. Ажиллах горим, хүчин чадал

Үргэлжлэх хугацаа	Ажиллах горим	Жилд ажиллах хоног	Хоногт ажиллах ажилчдын тоо	Хоногт ажиллах цаг
5	2 ээлжээр	365	0	24

5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжээ нэгж	Тайлбар
Уурхайн ууллагад шүүрэн орж	85.9	м3	БОННУТ-д Цанхийн баруун уурхайн гүн 1478-1223 м гүнд

Зураг № 38. Ус ашиглах дүгнэлт

Тус Цанхийн баруун зүүн уурхайн ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн "Галба Өөш Долоодын Говийн Сав газрын захиргаатай 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 2025/16, ЕТТ-2025/354, 2025/15, ЕТТ-2025/355 дугаартай Ус ашиглах гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. (Хавсралт №7. Хуудас 84-86)

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2025 оны 06 дугаар сарын 23 өдөр № 2025/16 Дорноговь аймаг, Сайншанд хот
2025.06.23

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу, Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын гаргасан 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Е-2501-000417 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны даргын 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/31 дугаар тушаалыг тус тус үндэслэн,

Нэг талаас Ус ашиглуулагч /цаашид "Захиргаа" гэх/-ийг төлөөлж Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны Усны чанар, экологи, төлбөрийн асуудал харьцсан мэргэжилтэн О.Амгалан, нөгөө талаас Ус ашиглагч /цаашид "Ус ашиглагч" гэх/-ийг төлөөлж Өмнөговь аймаг Цогтцэций сумын нутагт байрлах "Эрдэнэ Тавантолгой" ХК /улсын бүртгэлийн дугаар 9010001097, регистрийн дугаар 5435528/-ийн төлөөлж Салбарын захирал С.Гансүх нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны үйлчлэлээр байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт:

- 2.1.1. Уурхайгаас шавхан зайлуулах шүүрлийн ус;
- 2.1.2. Уурхайн өрөмдлөг ашиглахад;
- 2.1.3. Зам, талбайн тоосжилт дарахад;
- 2.1.4. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд;
- 2.1.5. Биологийн нөхөн сэргээлтэд ашиглахад;
- 2.1.6. Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд;

2.2. Ашиглах усны хэмжээ:

- 2.2.1. Уурхайн ухлага, барилгын сууриас шавхан зайлуулах шүүрлийн ус – 133,152.00 м³/жил;
- 2.2.2. Уурхайн өрөмдлөг ашиглах ус-140,782.00 м³/жил
- 2.2.3. Зам, талбайн тоосжилт дарахад худага авч ашиглах ус – 712,410.24 м³/жил;

Зураг № 39. Цанхийн уурхайн ус ашиглах гэрээ

5.2.3 Усны нөөц ашиглуулах дүгнэлтэд заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй ашиглах, ус ашигласны төлбөр хураамжийг төлж барагдуулах

2025 оны ус ашиглалтын хэмжээг Цанхийн баруун уурхай болон Цанхийн зүүн уурхайн ус ашиглуулах дүгнэлтэд заасан хэмжээтэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт № 13. Ус ашиглалтын байдлыг ус ашиглах дүгнэлттэй харьцуулсан хэмжээ

Дүгнэлт	Шавхан зайлуулах ус, м ³	Зам талбайн тоосжилт дарах газрын доорх ус, м ³	Ногоон байгууламж, нөхөн сэргээлтэд газрын доорх ус, м ³	Ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд газрын доорх ус, м ³
ЦБУ-н ус ашиглуулах дүгнэлт	30,623.50	998,488.07	400,464.00	226,665.00
ЦЗУ-н ус ашиглуулах дүгнэлт	133,152.00	712,410.24	485,001.00	103,970.00
Ус ашиглуулах дүгнэлтэд заасан нийлбэр хэмжээ	163,775.50	1,710,898.31	885,465.00	330,635.00
2025 оны 1-10 сарын ашиглалт	88,428.00	125,783.00	8,776.00	28,854.00
Ашиглалтын хувь	53.9%	7.35%	0.99%	8.73%

2025 оны хувьд ус ашиглалтын байдал ус ашиглах дүгнэлтэд заагдсанаар дунджаар 17.77% ашиглалттай байгаа бөгөөд энэ нь уурхайн зам усалгаанд хур борооны усыг түлхүү ашиглаж байгаатай холбоотой юм.

Ус ашигласны төлбөрт эхний 10-н сарын байдлаар нийт 92.1 сая төгрөгийг төлсөн бөгөөд үүнээс 88.7 сая төгрөг нь зам усалгаанд, 2.7 сая төгрөгийг ахуйн хэрэглээнд, 631 мян.төгрөгийг мод усалгаанд ашигласан усны төлбөр байна. Сар бүрийн 25-ны өдөр усны хэрэглээний актыг боловсруулж Цогтцэций сумын байгаль хамгаалагчаар баталгаажуулдаг ба ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэхийн дагуу Өмнөговь аймгийн Төрийн сангийн дансанд усны хэрэглээний төлбөрийг шилжүүлдэг. (Хавсралт №4. Хуудас 70-72)

Хүснэгт № 14. 2025 оны усны төлбөр төлсөн байдал


Огноо	Шүүрэл	Мод усалгаа	Зам усалгаа	Унд ахуй	Нийт
2025.01	2,562,075.36		3,044,352.60	291,356.35	5,897,784.31
2025.02	5,780,853.36		3,115,081.80	277,354.37	9,173,289.53
2025.03	11,978,889.12	1,690.31	2,349,648.00	265,414.32	14,595,641.75
2025.04	10,692,816.48	70,489.44	2,722,474.80	271,216.51	13,756,997.23
2025.05	17,200,861.92	122,277.60	1,880,517.60	215,112.67	19,418,769.79
2025.06	10,876,232.88	98,253.65	2,953,044.00	259,995.74	14,187,526.27
2025.07	532,267.20	92,427.48	3,407,189.40	307,660.03	4,339,544.11
2025.08	3,980,495.52	92,427.48	2,792,604.60	346,213.44	7,211,741.04
2025.09		113,430.46	1,774,024.20	273,997.73	2,161,452.38
2025.10		40,207.75	1,092,506.40	258,844.90	1,391,559.05
Нийт	63,604,491.84	631,204.16	25,131,443.40	2,767,166.06	92,134,305.47

Хүснэгт № 15. 2025 оны эхний 10 сарын дараах байдлаар ус ашиглалтын байдал

Зориулалт	Зам усалгаа				Унд ахуй	Мод усалгаа	Нийт
	828,942						
Нийт	828,942				28,854	8,776	Нийт
Эх үүсвэр	Хур бороо	Шүүрэл	Худаг	Саарал ус	Худаг	Худаг	
I	29,360	3,562	15,237	5,775	3,038	-	56,972
II	23,075	8,037	15,591	4,530	2,892	-	54,125

III	55,526	16,654	11,760	8,896	2,768	24	95,627
IV	53,410	14,866	13,626	14,164	2,828	980	99,874
V	68,657	23,914	9,412	6,053	2,243	1,700	111,979
VI	54,329	15,121	14,780	6,185	2,711	1,366	94,492
VII	46,186	740	17,053	4,981	3,208	1,285	73,453
VIII	44,814	5,534	13,977	13,268	3,610	1,285	82,488
IX	84,297	-	8,879	5,813	2,857	1,577	103,423
X	81,034	-	5,468	4,378	2,699	559	94,138
Нийт	540,688	88,428	125,783	74,043	28,854	8,776	866,571

Ашигласан усны ашиглалт тус бүрээр үзвэл унд ахуйн усны хэрэглээ 3.33%, мод усалгаанд ашиглаж буй усны хэрэглээ 1.01%, зам усалгаанд ашиглаж буй усны хэрэглээ 95.66% байна.



Диаграмм № 3. Ус ашиглалтын байдлын диаграмм

Нийт ашигласан усанд эзлэх гүний усны хэрэглээ 14.52%, шүүрлийн усны хэрэглээ 10.2%, гадаргын усны хэрэглээ 62.39%, дахин ашигласан буюу саарал усны хэрэглээ 8.54%-ийн гүйцэтгэлтэй байна.

5.2.4 Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ байгуулан төлбөр төлж барагдуулах

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль 2020 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Усны газрын дараах хаягдал усны дүгнэлтийг үндэслэн Галба-Өөш, Долоодын Говийн сав газрын захиргаанаас хаягдал ус зайлуулах зөвшөөрөл авсан. Үүнд:

- ✓ 2025 оны 01 дугаар сарын 27-ны өдрийн Е-2412-000251 тоот хаягдал усны дүгнэлтийг үндэслэн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 28,232 м³ хаягдал усыг зайлуулах зөвшөөрөл /сунгалт/ (Хавсралт №8. Хуудас 87)

Хаягдал ус зайлуулах зөвшөөрлийг үндэслэн “Хаягдал усыг байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй байгуулах ус бохирдуулсны төлбөрийн гэрээ”-г 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр Галба-Өөш, Долоодын Говийн сав газрын захиргаатай байгуулсан. (Хавсралт №9. Хуудас 88) Гэрээний дагуу улирал тутам цэвэрлэх байгууламжуудын оролт, гаралтын бохир уснаас дээж авч лабораторид шинжлүүлэн Усны газраас төлбөрийн тооцоог гаргуулан төлбөрийг тогтмол төлж байна.

2025 оны I, II, III-р улиралд нийт 37,898 м³ ахуйн хэрэглээний усыг Цанхи хотхон, Эрдэнэс хотхон, НБҮ-ийн иргэний барилга, грийн центрийн цэвэрлэх байгууламжид нийлүүлсэн ба ус бохирдуулсны төлбөрт 8,197,770.61 төгрөг төлсөн байна. (Хавсралт №10. Хуудас 89-91)

Хүснэгт № 16. Цэвэрлэх байгууламжид нийлүүлсэн усны хэмжээ /м³/

Цэвэрлэх байгууламж	1-р улирал	2-р улирал	3-р улирал	Нийт
Цанхи хотхон	3,791.00	7,106.00	4,096.00	14,993.00
НБҮ-ийн иргэний барилга	4,169.00	3,848.00	2,647.00	10,664.00
Грийн центр	4,188.00	3,797.00	4,256.00	12,241.00

НИИТ	12,148.00	14,751.00	10,999.00	37,898.00
------	-----------	-----------	-----------	-----------

Хүснэгт № 17. Ус бохирдуулсны төлбөрийн тооцоолол

№	Улирал	Хаягдал усны дүгнэлтийн огноо, дугаар	Нийт ноогдуулсан төлбөр /төг/
1	I улирал	2025.Е-2504-000302	911,100.00
2	II улирал	2025.07.08 Е-2507-000022	3,181,738.97
3	III улирал	2025.10.17 Е-2510-000114	4,104,931.64
НИИТ			8,197,770.61

5.2.5 Хаягдал усыг стандартын шаардлага хангасан цэвэрлэх байгууламжид цэвэршүүлэн саарал ус гаргаж зам талбайн тоосжилт дарах, мод усалгаанд ашиглах

Уурхайн ажилчдын хотхон, захиргааны барилгын цэвэрлэж байгууламж болох “Грийн центр” цэвэрлэх байгууламжийн хувьд зүгшрүүлэх тохируулгын ажил хийгдэж байгаа бөгөөд одоогоор цэвэршүүлсэн саарал усыг улирал бүр лабораторид шинжүүлж стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж байна. Шинжилгээний хариуг MNS4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал усны ерөнхий шаардлага стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан үзүүлэлттэй байгаа тул зам усалгаанд ашиглаагүй болно.

Цанхийн уурхайн зам усалгаанд стандартын шаардлага хангасан “Энержи ресурс” ХХК, “Кэй Эй Майнинг” ХХК, “Ти ти жи ви си өү” ХХК-ийн цэвэрлэх байгууламжийг цэвэршүүлсэн саарал усыг ашигласан.

№	ЭЛЕМЕНТ	НӨГЖ	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН	ЗӨВШӨӨРӨГДӨХ ҮЭР ХӨДӨӨНӨЙ МНС 4943:2015	СТАНДАРТ АРГА
1	pH		7.57	4.4	MNS 360 1633:2006
2	Монгол Улсын УС	мл/л	-0.020		
3	Улаанбаатарын УС	мл/л	0.000	0.000	MNS 4475:1997
4	Улаанбаатарын УС	мл/л	-0.0	0.0	
5	Шинжлэх ухааны үндэслэл	мл/л	12.32	20	
6	Хүрээлэн байгаа орчин	мл/л	21.00	50	MNS 500 6862:2001
7	Хүрээлэн байгаа орчин	мл/л	7.87	20	MNS 500 6862:2001
8	Хүрээлэн байгаа орчин	мл/л	-0.10	0.5	MNS 7397:2006
9	Хүрээлэн байгаа орчин	мл/л	-0.005	0.005	MNS 500 1390:2001
10	Хүрээлэн байгаа орчин	мл/л	-0.011	0.7	
11	Хүрээлэн байгаа орчин	мл/л	-0.04	0.6	
12	Хүрээлэн байгаа орчин	мл/л	0.14	0.70	
13	Хүрээлэн байгаа орчин	мл/л	-0.01	1.5	
14	Хүрээлэн байгаа орчин	мл/л	-0.005	0.005	
15	Хүрээлэн байгаа орчин	мл/л	-0.000	0.007	
16	Хүрээлэн байгаа орчин	мл/л	-0.000	0.03	
17	Хүрээлэн байгаа орчин	мл/л	-0.000	0.3	
18	Хүрээлэн байгаа орчин	мл/л	-0.002	1.0	
19	Хүрээлэн байгаа орчин	мл/л	0.36	1.0	
20	Хүрээлэн байгаа орчин	мл/л	0.22	0.5	MNS 1000 1180:2011
21	Хүрээлэн байгаа орчин	мл/л	-0.000	0.3	
22	Хүрээлэн байгаа орчин	мл/л	-0.002	0.2	
23	Хүрээлэн байгаа орчин	мл/л	1.20	1.20	
24	Хүрээлэн байгаа орчин	мл/л	-0.01	0.1	
25	Хүрээлэн байгаа орчин	мл/л	0.015	0.02	
26	Хүрээлэн байгаа орчин	мл/л	0.027	0.02	
27	Хүрээлэн байгаа орчин	мл/л	0.52	2.0	
28	Хүрээлэн байгаа орчин	мл/л	0.01	0.01	
29	Хүрээлэн байгаа орчин	мл/л	-0.10	0.10	
30	Хүрээлэн байгаа орчин	мл/л	0.01	2.0	
31	Хүрээлэн байгаа орчин	мл/л	-0.02	0.005	MNS 3040 6308:2006
32	Хүрээлэн байгаа орчин	мл/л	-0.002	0.005	MNS 3040 6308:2006
33	Хүрээлэн байгаа орчин	мл/л	-0.001	0.005	MNS 4710:1997

Зураг № 40. Саарал усыг шинжилгээнд хамруулсан байдал

2025 оны эхний 10 сарын байдлаар нийт Нийт ус ашиглалтын 6% буюу 42,971.0 м³ саарал усыг дахин ашигласан бөгөөд эдгээр усыг “Энержи ресурс” ХХК, “Кэй Эй Майнинг” ХХК, “Ти ти жи ви си өү” ХХК-ийн цэвэрлэх байгууламжаас авч уурхайн зам усалгаа болон нүүрс ачилтын талбайн тоосжилт дарах усалгаанд ашигласан байна.

5.2.6 Уурхайн газрын доорх усны нөөц, чанарт байнгын хяналт тавих

Унд ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж буй худгуудын усны чанар, түвшингийн өөрчлөлт, ундарга зэргийг тогтмол хянах зорилгоор түвшингийн хэмжилтийг 7 хоногт 2 удаа, ундаргын тооцооллыг сард 1 удаа, усны шинжилгээг улиралд 1 удаа тус тус хийж гүйцэтгэн ажиллаж байна. Мөн хэмжилтийн үр дүнг боловсруулж, хагас жил болон жилийн эцсийн байдлаар ус ашиглалтын тайланг боловсруулж, Өмнөговь аймгийн БОАЖГ, ГӨДГСГ, Усны газарт тус тус тогтмол тайлагнан ажиллаж байна. (ОХШХ бүлэг)



Зураг № 41. Ашиглалтын худаг болон малчны худгуудын түвшний хэмжилт хийж буй байдал

Тавантолгой ордын хэмжээнд гидрогеологийн болон газрын доорх усны нөөц батлуулах хайгуул судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр 2025 оны 10-р сарын 01-ны өдөр ЭТТ-2025/601 дугаартай гэрээг “Говь караван” ХХК-тай байгуулсан бөгөөд ажлыг 2026 оны хаврын улиралд эхлүүлэхээр төлөвлөөд байна.

5.2.7 Ус ашиглалтын бүх эх үүсвэрээс ашиглах усны хэмжээг зөв тодорхойлох зорилгоор тоолууржуулах

Уурхайн ашиглалтын худгууд болон шүүрлийн усны хэмжээг тогтмол тоолууржуулж тоолуурын гэрчилгээ дууссан үед сунгуулж болон ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.


Хүснэгт № 18. Ашиглалтын худгийн тоолууржуулсан байдал

№	Худгийн дугаар	Тоолуур	Гэрчилгээ
1	Худаг №3		
2	Худаг №4		


<p>3</p> <p>Худаг №5</p>		<p>Худаг №5</p> <p>СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ № ЭУ 113466</p> <p>Эрдэнэс Таван Толгой ХК (хэрэглэгчийн нэр)</p> <p>ашиглаж байгаа LXLG загварын 40 м³/ц хэмжих хязгаартай, 50 мм-ийн голчтой № 2104000610 -ын халуун, хүйтэн усны тоолуурыг № 085 лацаар битүүмжилж (доогуур зураж) 2027 оны 11 -р сарын 20 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.</p> <p>Шалгалтын дараах заалт: 029766 м³</p> <p>18 Лабораторийн тэмдэг Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг 2025 оны 11 -р сарын 20 -ны өдөр</p>
<p>4</p> <p>Худаг №6</p>		<p>Худаг №6</p> <p>СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ № ЭУ</p> <p>Эрдэнэс Таван Толгой ХК (хэрэглэгчийн нэр)</p> <p>ашиглаж байгаа LXLG загварын 63031 м³/ц хэмжих хязгаартай, 50 мм-ийн голчтой № 202001199 -ын халуун, хүйтэн усны тоолуурыг № 011 лацаар битүүмжилж (доогуур зураж) 2028 оны 12 -р сарын 06 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.</p> <p>Шалгалтын дараах заалт: 00001</p> <p>03 Лабораторийн тэмдэг Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг 2025 оны 12 -р сарын 06 -ны өдөр</p>
<p>5</p> <p>Худаг №7</p>		<p>7-р худаг</p> <p>СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ № ЭУ 113470</p> <p>Эрдэнэс Таван Толгой ХК (хэрэглэгчийн нэр)</p> <p>ашиглаж байгаа LXLG загварын 40 м³/ц хэмжих хязгаартай, 50 мм-ийн голчтой № 2104000692 -ын халуун, хүйтэн усны тоолуурыг № 085 лацаар битүүмжилж (доогуур зураж) 2027 оны 11 -р сарын 20 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.</p> <p>Шалгалтын дараах заалт: 022828 м³</p> <p>18 Лабораторийн тэмдэг Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг 2025 оны 11 -р сарын 20 -ны өдөр</p>
<p>6</p> <p>Худаг №8</p>		<p>Худаг №8</p> <p>СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ № ЭУ 113463</p> <p>Эрдэнэс Таван Толгой ХК (хэрэглэгчийн нэр)</p> <p>ашиглаж байгаа LXLG загварын 40 м³/ц хэмжих хязгаартай, 50 мм-ийн голчтой № 2104000637 -ын халуун, хүйтэн усны тоолуурыг № 085 лацаар битүүмжилж (доогуур зураж) 2027 оны 11 -р сарын 20 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.</p> <p>Шалгалтын дараах заалт: 099000 м³</p> <p>18 Лабораторийн тэмдэг Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг 2025 оны 11 -р сарын 20 -ны өдөр</p>

7	Худаг №9		
8	Худаг №12		
9	Худаг №13		
10	Худаг №14		

11	Худаг №16		
12	Худаг №17		
13	Худаг №18		
14	Худаг №20		

15	Худаг №22		
16	Худаг №23		
17	Худаг №24	 <p>Oct 24, 2025 07:31:13 Cogt-Cecii Ömnögovi</p>	
18	Худаг №25		

<p>19</p>	<p>Худаг №26</p>		
<p>20</p>	<p>Худаг №27</p>		
<p>21</p>	<p>Худаг №28</p>		

22	Худаг №29		
23	Худаг №30		

5.3 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
5.3.1	Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгын технологийн горимын мөрдөлтийг хангуулах, хяналт тавиж ажиллах	12	Цанхийн уурхайд нийтдээ 27 ш шимт хөрсний овоолго үүссэн байна. Шимт хөрсний овоолгууд дээр нийт 6226.9 мян.м ³ шимт хөрс хадгалагдаж байна.	100%
5.3.2	Тусгай зөвшөөрлийн талбай дээрх ААН-ийн судалгаа хийх, Сумын ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудтай хамтран зөрчил арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх	1	Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа иргэн, аж ахуйн нэгж, объектын тооллогыг 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрөөс 4 дүгээр сарын 4-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Нийт 446 иргэн, аж ахуйн нэгж, бусад объектуудыг бүртгэлжүүлсэн.	100%

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
5.3.3	Ахилтад өртөх талбайн шимт хөрсийг >0.3 метр зузаантай хуулж, стандартын дагуу шимт хөрсийг хадгалах	Тухай бүр	Тайлант оны эхний 10 сарын байдлаар Цанхийн зүүн уурхайд нийт 35 зөвшөөрөл олгогдож 824,955.5 м ³ шимт хөрс хуулсан, Цанхийн баруун уурхайд нийт 53 зөвшөөрөл олгогдож 881,995.6 м ³ шимт хөрсийг хуулсан байна. Шимт хөрс хуулсан даруйд төлөвлөгдсөн овоолго руу зөөн байршуулсан байна.	100%
5.3.4	Дүүрсэн шимт хөрсний овоолгуудыг стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг харгалзан үзэж акт үйлдэн хаах	Овоолгын дүүрэлтээс шалтгаална	Цанхийн баруун уурхайд 4.2.13, 7.1.1 дугаартай шимт хөрсний овоолгууд дүүрч тухайн овоолгуудыг хэлбэржүүлэн, акт үйлдэн хаах ажил хийгдсэн. Тус овоолгуудад нийт 86,658 м ³ шимт хөрс хадгалагдаж байна.	100%
5.3.5	Шимт хөрс хуулах зөвшөөрлийг тухай бүр олгож холбогдох журмын дагуу овоолгод байршуулах	Жилийн турш	Шимт хөрс хуулах зөвшөөрлийн дагуу хуулагдсан талбайд байнгын хяналт тавьж, шимт хөрсийг гүйцэт хуулан, зохих овоолгод байршуулан хадгалдаг.	100%
5.3.6	Гэрээт байгууллагуудын ажилчдын хотхон – Уурхай чиглэлд зорчих замын маршрутыг гаргаж, мөрдүүлэх	-	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сум дахь салбараас Барууннаран-Ухаахудаг автозамаас урагш салаалсан Цанхийн баруун уурхайн ажилчдын ээлж солих сайжруулсан шороон замын шинэ маршрут батлуулах албан хүсэлтийг 2025 оны 05-р сарын 21-ний өдрийн 03/120 дугаартай албан бичгээр Цогтцэций сумын ЗДТГ-т хүргүүлэн батлуулсан.	100%
5.3.7	Хөрс бохирдохоос сэргийлж Цогтцэций сумын төвийн зорилтот бүлгийн зарим өрхөд эко жорлон суурилуулах	30ш	Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр Өмнөговь аймгийн Цогтцэций сумын зорилтот бүлгийн 17 өрхөд био ариун цэврийн байгууламжийг суурилуулж хүлээлгэн өгсөн байна. Үлдсэн айлыг 2025 онд багтаан био ариун цэврийн байгууламжтай болгохоор ажиллаж байна.	56%
5.3.8	Ажилчдын хотхоны хог хаягдлын цэгт бактерийн бохирдлоос сэргийлж ариутгал хийх	-	Тайлант онд катерингийн үйлчилгээ үзүүлэгч компани маань “Хүслэн-Од” ХХК-тай гэрээ байгуулан сард 3-4 удаа 5-н хогийн цэгт ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгүүлж байна.	100%

5.3.1 Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгын технологийн горимын мөрдөлтийг хангуулах, хяналт тавьж ажиллах

Уурхайн ахилт, бүтээн байгуулалт, зам талбай, хөрсний овоолго хийгдэх талбайн шимт хөрсийг хуулж, стандартын дагуу овоолго үүсгэж, хадгалдаг ба Цанхийн уурхайд нийтдээ **27** ш шимт хөрсний овоолго үүссэн байна. Шимт хөрсний овоолгууд дээр нийт **6226.9** мян.м³ шимт хөрс хадгалагдаж байна.



Цанхийн баруун уурхайд шимт хөрсний овоолго

Баруун уурхайд нийтдээ 9 шимт хөрсний овоолгод 2475.5 мян.м³ хөрс хадгалагдаж байна.

Шимт хөрсний овоолго

Цанхийн зүүн уурхайд шимт хөрсний овоолго

Зүүн уурхайд нийтдээ 18 шимт хөрсний овоолгод 3751.4 мян.м³ хөрс хадгалагдаж байна.

Шимт хөрсний овоолго

Зураг № 42. Шимт хөрсний овоолгуудын байршлын зураг

5.3.2 Тусгай зөвшөөрлийн талбай дээрх ААН-ийн судалгаа хийх, Сумын ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудтай хамтран зөрчил арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 сарын 21-ний өдрийн А/149 дугаартай тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах” журмын 6.1-т “Жил бүрийн гуравдугаар улиралд багтаан тусгай зөвшөөрлийн талбайд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэл хийнэ” гэж заасан байдаг.


Энэ журмын 6.1-д заагдсаны дагуу тусгай зөвшөөрлийн талбайд байгаа иргэн, аж ахуйн нэгж, объектын тооллогыг хийх ажлын хэсгийн тушаалыг 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Салбарын захирлын тушаалаар батлуулсан. Тусгай зөвшөөрлийн талбайд үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын тооллого, бүртгэлийн ажлыг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 25-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь тусгай зөвшөөрлийн 68471.43 га талбайгаас 2025 оны 8 дугаар сарын байдлаар 76 нэгж талбарын 11887.93 га талбайг газрыг эзэмших эрхийн гэрчилгээгээр баталгаажуулж гэрээнд заасан нөхцөлийн дагуу эзэмшиж байна. Мөн Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлагдсан 31 нэгж талбарын 9055 га талбайг шинээр эзэмших үйл явц, Цогтцэций сумын Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/409, А/410, А/411 дугаар захирамжаар шийдвэрлэгдэж гэрчилгээ авч, гэрээ байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна.




Диаграмм № 4. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн эзэмшилд авсан нэгж талбарын тоо хэмжээ

Тусгай зөвшөөрлийн талбайд нийт 344 нэгж талбарын 12164 га талбайг иргэн, аж ахуй нэгж эзэмшиж, ашиглаж байх ба тэдгээрийн үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж буй 31 худаг, уст цэг байна. Газрын эзэмшигчээр нь ангилж үзвэл гадаад улсын хуулийн этгээд 13, Монгол улсын хуулийн этгээд 157, Төрийн захиргааны байгууллага 2, иргэн 133 байгаа бол бусад газар ашиглагчийн мэдээлэл тодорхой бус байна.



Диаграмм № 5. Тусгай зөвшөөрлийн талбайн ашиглалтын байдлын диаграмм




Зураг № 43. Тусгай зөвшөөрлийн талбайн газар эзэмших, ашиглалтын байдал

Тусгай зөвшөөрлийн талбайд зөвшөөрөлгүй газар эзэмшиж, ашиглаж байгаа 65 иргэн, аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрийг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт № 19. Зөвшөөрөлгүй газар эзэмшилт, ашиглалт үйл ажиллагааны чиглэлээр

№	Зориулалт	Тоо ширхэг
	Өвөлжөө, хаваржаа	
	Худалдаа, үйлчилгээ	
	Шатахуун түгээх станц	
	Ажилчдын амрах байр болон тээврийн машины зогсоол	
	Хайгуулын өрөмдлөгийн талбай	
	Үйлдвэрийн газар	
	Оршуулгын газар	
	ТТАМ олборлож буй талбай	
	Нийт	

Уурхайн тэсэлгээний бүсэд орж үйл ажиллагаа нь зогссон, газар эзэмших эрхгүй зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан аж ахуй нэгжүүд газар ашиглах явцдаа хөрсийг эвдрэл, элэгдэлд оруулах тослох материал их хэмжээгээр асгах, барилгын хог хаягдал үүсгэх эсхүл газар ухаж булах зэрэг ноцтой хохирол учруулж Хог хаягдлын тухай хууль, Газрын тухай хууль, Байгаль орчны тухай хуулийг зөрчсөн үйлдэл түгээмэл байгаа тул компанийн зүгээс Цогтцэций сумын ЗДТГ-т хамтран эдгээр үйл ажиллагаа явуулж буй иргэдийг албадан нүүлгэх ажлыг зохион байгуулах тухай албан бичгийг хүргүүлсэн.



Зураг № 44. Зөвшөөрөлгүй газар ашиглаж буй иргэн, ААН-ийн байгаль бохирдуулсан байдал

Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хуульд заасны дагуу ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл, газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээг төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр авч, үйл ажиллагаа явуулж байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд зөвшөөрөлгүй газар ашиглаж үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжид мэдэгдэл хүргүүлэн ажиллаж байна.



ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ
ХҮҮБЦААТ КОМПАНИ
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ЦОГЦЭЦНИ СУМ ДАМЬ САЛБАР

46043 (Өвөрхангай аймаг), Цогцолцай сум, Цайтмы-Орлоо байр
Утас: 7500-9993
И-мэйл: ettd@erdenees.tav.tolgoi.mn | www.ett.mn

№ ДЭС 10/12 № 03/279

Мэдэгдэл хүргүүлэх тухай

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас дэвшүүлсэн бодлого, зорилтуудын биелэлтийг хангах хүрээнд Тавантолгой стратегийн орддыг түшиглэн хөгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, нүүрс оборлолын хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх зорилго тавин уурхайн талбайг тогтмол ахиулан ажиллаж байна.

Энэ хүрээнд Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хуульд заасны дагуу ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл, газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээг төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр авч, үйл ажиллагаагаа явуулж байна.

Таны ашиглаж буй газар нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эзэмшлийн нэгж талбарын 4604013306 дугаартай уул уурхайн үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зориулалт бүхий газартай давхцаж байх тул тусгай зөвшөөрлийн талбайг чөлөөлөн нөхөн сэргээлт хийж, төрийн эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө үү.

Мөн энэхүү мэдэгдлийн хариуг 2025 оны 10 дугаар сарын 20-ны дотор ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн

САЛБАРЫН ЗАХИРАЛ  С.ГАНСҮХ

1125080332

Зураг № 45. Мэдэгдэл хүргүүлсэн тухай албан бичиг

5.3.3 Ахилтад өртөх талбайн шимт хөрсийг >0.3 метр зузаантай хуулж, стандартын дагуу шимт хөрсийг хадгалах

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь шимт хөрснөөс гадна шимэрхэг чулуулгийн тодорхой чанартай хэсгийг ашиглаж болохыг судлан тогтоож нөхөн сэргээлтэд ашиглахыг зорьж байна. Үүний дагуу уурхайн хэмжээнд Салбарын захирлын батласан ЭТТ-СА-Ж14-БО-Ж09-Х03 дугаартай “Өнгөн хөрстэй ажиллах журам”-ыг баримтлан ажиллаж байна. Энэхүү журамд заасны дагуу шимт хөрс хуулах ажил эхлэхээс өмнө холбогдох инженерүүдээс зөвшөөрөл авч баталгаажуулсны дараа шимт хөрс хуулах ажил хийгддэг. Шимт хөрс хуулах үйл явцад “Газар хөндөх журам”-ын дагуу газар хөндөх зөвшөөрлийг мөн адил авна.

Тайлант оны эхний 10 сарын байдлаар Цанхийн зүүн уурхайд нийт 35 зөвшөөрөл олгогдож 824,955.5 м³ шимт хөрс хуулсан, Цанхийн баруун уурхайд нийт 53 зөвшөөрөл олгогдож 881,995.6 м³ шимт хөрсийг хуулсан байна. Шимт хөрс хуулсан даруйд төлөвлөгдсөн овоолго руу зөөн байршуулдаг.

Шимт хөрс хуулах, зөөх үйл явцад цаг агаарын нөхцөл байдлыг харгалзан үзэж салхи, шуургатай үед шимт хөрс салхинд их хэмжээгээр хийсэхээс сэргийлж тухайн ажлыг хэсэгчлэн зогсоох арга хэмжээг авдаг.




Зураг № 46. Шимт хөрсийг хуулж овоолгоод байршуулахаар ачиж буй байдал

5.3.4 Дүүрсэн шимт хөрсний овоолгуудыг стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг харгалзан үзэж акт үйлдэн хаах

2025 оны эхний 10 сарын дараах байдлаар Цанхийн баруун уурхайд 4.2.13, 7.1.1 дугаартай шимт хөрсний овоолгууд дүүрч хэлбэржүүлэн, акт үйлдэн хаах ажил хийгдсэн. Уг овоолгуудад нийт 86,658 м³ шимт хөрс хадгалагдаж байна. (Хавсралт №11. Хуудас 92-93)

Хүснэгт № 20. Акт үйлдэж хаасан шимт хөрсний овоолгын хэмжээ

№	Уурхай	Овоолгын дугаар	Шимт хөрсний хэмжээ
1	Цанхийн баруун уурхай	4.2.13	48,889
2	Цанхийн баруун уурхай	7.1.1	37,769
Нийт			86,658



Зураг № 47. Цанхийн баруун уурхайд хаасан шимт хөрсний овоолгын акт

5.3.5 Шимт хөрс хуулах зөвшөөрлийг тухай бүр олгож холбогдох журмын дагуу овоолгод байршуулах

Цанхийн уурхайд шимт хөрс хуулах үйл ажиллагаа нь Салбарын захирлын батласан ЭТТ-СА-Ж14-БО-Ж09-Х03 дугаартай “Өнгөн хөрстэй ажиллах журам”-ыг баримтлан хийгддэг бөгөөд эхний ээлжинд гэрээт байгууллагын Байгаль орчны мэргэжилтэн Шимт хөрс хуулах зөвшөөрлийн маягтыг бөглөж “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн холбогдох мэргэжилтнүүдээр хянуулан гарын үсгээр баталгаажуулдаг. Хамгийн сүүлд Байгаль орчин хариуцсан нэгжид уг зөвшөөрлийг өгч цахимд бүртгүүлэн албан ёсоор шимт хөрс хуулах ажил эхлэх боломжтой болдог.




Зураг № 48. Шимт хөрс хуулах зөвшөөрлийн маягт болон дагалдах байршлын зураг

2025 оны эхний 10 сарын дараах байдлаар Цанхийн зүүн уурхайд нийт 35 зөвшөөрөл олгогдож 824,955.5 м³ шимт хөрс хуулсан, Цанхийн баруун уурхайд нийт 53 зөвшөөрөл олгогдож 881,995.6 м³ шимт хөрсийг хуулсан байна. Шимт хөрс хуулсан даруйд төлөвлөгдсөн овоолго руу зөөн байршуулдаг.


5.3.6 Гэрээт байгууллагуудын ажилчдын хотхон – Уурхай чиглэлд зорчих замын маршрутыг гаргаж, мөрдүүлэх

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сум дахь салбараас Барууннаран-Ухаахудаг автозамаас урагш салаалсан Цанхийн баруун уурхайн ажилчдын ээлж солих сайжруулсан шороон замын шинэ маршрут батлуулах албан хүсэлтийг 2025 оны 05-р сарын 21-ний өдрийн 03/120 дугаартай албан бичгээр Цогтцэций сумын ЗДТГ-т хүргүүлсэн.



Зураг № 49. Маршрут батлуулахаар хүргүүлсэн албан бичиг болон маршрутын зураг

Цогтцэций сумын Засаг даргын 2025 оны 08-р сарын 14-ны өдрийн А/396 дугаартай “Сайжруулсан шороон замын трасс тогтоох тухай” захирамжаар замын маршрут албан ёсоор батлагдсан бөгөөд гэрээт байгууллагын тээвэр бүгд тус замаар маршрутын дагуу тээвэрлэлтийн ажлыг хийж гүйцэтгэж байна. (Хавсралт №12. Хуудас 94)



Зураг № 50. Шороон замын трасс батлах тухай засаг даргын захирамж

5.3.7 Хөрс бохирдохоос сэргийлж Цогтцэций сумын төвийн зорилтот бүлгийн зарим өрхөд эко жорлон суурилуулах

Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр Өмнөговь аймгийн Цогтцэций сумын зорилтот бүлгийн 30 өрхөд Цогтцэций сумын ЗДТГ-аас санал авч Ти Эн Түншлэл 5, Үндэсний манлайлал түншлэл-5, Кэй Эй Майнинг ХХК-0, Үндэсний оператор түншлэл 3, Үндэсний уурхайчин түншлэл-1, Овоот толгойт ресурсес 3 тус тус дараах айлуудад Био ариун цэврийн байгуулах ажлыг хийж гүйцэтгэн акт үйлдэн баталгаажуулсан. Ажлын гүйцэтгэл 56%-тай явж байгаа буюу 2025 онд багтаан үлдсэн айлуудад био ариун цэврийн байгууламжийг суурилуулахаар ажиллаж байна. (Хавсралт №13. Хуудас 95-97)

Хүснэгт № 21. Цогтцэций сумаас ирүүлсэн био ариун цэврийн байгууламж хийлгэх өрхийн мэдээлэл болон харууцан гүйцэтгэсэн компанийн мэдээлэл

№	Нэр	Баг	Гэрийн хаяг	Утасны дугаар	Хариуцсан Компани, тайлбар	Суурилуулсан эсэх	
						тийм	үгүй
1	Н.Амгаланбаатар	Сийрэст	Алимдын нүхэн	88720256	Ти Эн Түншлэл	✓	
2	Ц.Сүх-Өлзий	Сийрэст	Цагаан-овоо 907	88890987		✓	
3	Ц.Цэрэнханд	Сийрэст	Шинэ хотхон	88952258		✓	
4	Н.Цогтгэрэл	Сийрэст	Бумбан овоо 9-902	89703131		✓	
5	Х.Мөнхбурам	Сийрэст	Цагаан босго	88537518		✓	
6	Л.Шатархүү	Сийрэст	Их ус 1-14	80222440	Үндэсний манлайлал түншлэл	✓	
7	Ц.Чулуунбаатар	Цагаан Овоо	Бумбан Овоо 4-428	88434229		✓	
8	Ц.Доржсүрэн	Сийрст	Цагаан Овоо 3-20	88210625		✓	
9	С.Ойров	Билгэх	Цагаан Овоо 1316	88487170		✓	
10	О.Байгаль	Билгэх	Ямаан хүрэн 9.9	98161814		✓	
11	Х.Сумьяа	Билгэх	Шинэ хотхон	88370903	Кэй Эй Майнинг ХХК 26.4 сая төгрөгийн захиалга 2025.09.15-ны		-
12	Б.Амартүвшин	Өгөөмөр	Их усын 5-531	88145853			-
13	Н.Өлзийсүрэн	Цагаан Овоо	Зүүн суу 4-405	88376115			-


14	О.Хүүхэн	Цагаан Овоо	Баруун суу 5-305	90901169	өдөр хийгдсэн. Худалдан авалт хийгдээгүй байна.		-
15	Ж.Дэмбэрэл	Цагаан Овоо	Зүүн суу 4-2 104	86857198	өдөр хийгдсэн. Худалдан авалт хийгдээгүй байна.		-
16	Ч.Түмэн-Аюуш	Билгэх	Цагаан овоо-925 тоот	86838066	ҮОТ-2024 онд Эко-ОО хийлгүүлсэн.	✓	
17	С.Чулуун	Цагаан Овоо	Цагаан овоо 4-428 тоот	88762106	ҮОТ-Хийгдээгүй. Холбогдсон хөдөө амьдардаг./Т одорхой хугацаагаар хойшлуулсан/		-
18	С.Бямбаа	Билгэх	Зүүн суу-609 тоот	88830627	ҮОТ-Хийгдээгүй. Дугаар буруу байсан шалтгаанаар		-
19	Н.Туяажаргал	Сийрст	Цагаан овоо-725 тоот	80215750	Үндэсний оператор түншлэл	✓	
20	Л.Энхтуул	Цагаан Овоо	Бумбан овоо-305 тоот	88994732		✓	
21	П.Сосорбура м	Сийрст	Өгөөмөр-731	88562205	ҮҮТ-хийгдээгүй. 2025 онд багтаан хийхээр ажиллаж байна.		-
22	Д.Мягмар	Цагаан Овоо	Цэций уул 5-130	88536900			-
23	Б.Мөнхгэрэл	Цагаан Овоо	Цэций уул 5-15	80074742			-
24	Ц.Отгонбаяр	Цагаан Овоо	Хонгор овоо 4-446	88808564			-
25	Д.Алтанчимэг	Билгэх	Зүүн суу-621	89700053	Үндэсний уурхайчин түншлэл	✓	
26	С.Аюурцэрэн	Билгэх	Зүүн суу-725	88404903	Овоот толгойт ресурсес ХХК	✓	
27	Ц.Баяраа	Цагаан овоо	Ямаан хүрэн-312	88548604		✓	
28	Цэрэндиваа	Цагаан овоо	Хонгор овоо-3-311	90053562		✓	
29	Э.Амарсанаа	Билгэх	Цагаан овоо 1а-41	88538493, 80188101			-
30	Ө.Болорцэцэг	Цагаан Овоо	Бумбан овоо 419	88200657			-

5.3.9 Ажилчдын хотхоны хог хаягдлын цэгт бактерийн бохирдлоос сэргийлж ариутгал хийх

Тайлант онд катерингийн үйлчилгээ үзүүлэгч компани маань “Хүслэн-Од” ХХК-тай гэрээ байгуулан сард 3-4 удаа 5-н хогийн цэгт ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгүүлж байна. (Хавсралт №14. Хуудас 98-101)



Зураг № 51. Ариутгал халдваргүйтгэл хийх батлагдсан хуваарь



Зураг № 52. Гэрээт байгууллагаас ирсэн сарын тайланд ариутгал хийсэн байдал тусгагдсан байдал

5.4 Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ


№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
5.4.1	Зөвшөөрөлгүй газар хөндөхөөс сэргийлж, аливаа газар хөндөх ажлыг эхлүүлэхээс өмнө газар хөндөх зөвшөөрөл олгох, хөндөгдсөн газрын бүртгэлийг мэдээллийн санд оруулах	Тухай бүр	Салбарын захирлын 2021.12.11-ний өдөр А/145 дугаар тушаалаар баталсан “Газар хөндөх журам”-ын дагуу газар хөндөх зөвшөөрөл олгосны үндсэн дээр газар шорооны ажлыг хийж гүйцэтгэдэг. Зөвшөөрөл олгосон тухай бүртгэл, хөтлөлт хийн, мэдээллийн сан үүсгэсэн.	100%

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
5.4.2	Тусгай зөвшөөрлийн талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын явуулж буй ААН судалгаа хийх	Жилд 1 удаа	2024.03.14-ний өдөр А/300 дугаартай Өмнөговь аймгийн Засаг даргын захирамжаар НБҮ-ийн авто замын бүтээн байгуулалтад ашиглах ТТАМ ашиглах түр зөвшөөрөл авсан. Үүний дагуу 2024.05.03-ны өдөр Цогтцэций сумын Засаг даргатай ЭТТ-2024/1104 дугаартай ТТАМ ашиглуулах гэрээг байгуулан ажиллаж байна.	100%

5.4.1 Зөвшөөрөлгүй газар хөндөхөөс сэргийлж, аливаа газар хөндөх ажлыг эхлүүлэхээс өмнө газар хөндөх зөвшөөрөл олгох, хөндөгдсөн газрын бүртгэлийг мэдээллийн санд оруулах

Салбарын захирлын 2021 оны 12 дугаар сарын 11-ний өдөр А/145 дугаар тушаалаар баталсан “Газар хөндөх журам”-ын дагуу холбогдох цахилгааны, сүлжээний, сантехникийн, хөдөлмөрийн аюулгүй байдлын, байгаль орчны инженерүүдээс газар хөндөх зөвшөөрөл олгосны үндсэн дээр газар шорооны ажлыг хийж гүйцэтгэдэг. Зөвшөөрөл олгосон тухай бүртгэл, хөтлөлт хийн, мэдээллийн сан үүсгэсэн.

2025 оны эхний 10 сарын дараах байдлаар 267 газар хөндөх зөвшөөрөл олгоод байна.




Зураг № 53. Газар хөндөх зөвшөөрлийн маягт

№/д	Хүснэгт гаргасан өдөр	Хүснэгт гаргасан хэлтэс	Хүснэгт гаргасан ажилтан нэр	Алиан тушаал	Ажлын байршил	Байрлалын талаарх тайлбар	Газар хөндөх шалтгаан	Ажлын гэнэцгүүлэн өгсөн эсэх	Ажлын тодорхойлолт	Нөхөн сэргээлт хийж төгсө тэмдэглэгээ	Өргөх талбайн хэмжээ м2
1	2025-01-03	Хий эй мэдээний ХХК	О. Отгонбаяр	Б/Өмгөжигтэн	ЦЗУ	хөрөнө 34-р овоолго 3-12, 4-12	Овоолго тээлт	Байршлын зураг	Шийтгэж хуулах	Журмын дагуу мөрдөж ажиллана	34950
2	2025-01-04	Ти Эн тунцгал	Ц. Дэлгасүрэн	БО-ны ажилтан	ЦЗУ	Парк 3-ын үнд С5 1-н өргийн	ЦЗУ тээлт	Байршлын зураг	Холбоодог журмын дагуу ажиллана	Журмын дагуу мөрдөж ажиллана	12000
3	2025-01-05	Ти Эн тунцгал	Ц. Дэлгасүрэн	БО-ны ажилтан	ЦЗУ	Нүүрсний олоодны зуунгад С1 1-н блокын ард	ЦЗУ ХО 1 тээлт	Байршлын зураг	Холбоодог журмын дагуу ажиллана	Журмын дагуу мөрдөж ажиллана	45000
4	2025-01-08	Ти Эн тунцгал	Б.Балдан-Осор	БО-ны ажилтан	ЦЗУ	Парк 2-ийн баруун талд	2 зам холбож шинэ зам тавих	Байршлын зураг	Холбоодог журмын дагуу ажиллана	Журмын дагуу мөрдөж ажиллана	7200
5	2025-01-06	Овоолго талбайн ресурс ХХК	Б.Эрдэсчимэг	БОМ	ЦЗУ	Хөрсний 3-р овоолго WD31 5 1	Овоолго тээлт	Байршлын зураг	Шийтгэж хуулах	Журмын дагуу мөрдөж ажиллана	56000
6	2025-01-09	Утасны уурхайн тунцгал	Г.Баярмагдал	БО-ны мэргэжилтэн	ЦЗУ	хөрөнө овоолго 3-4 зуун хойд тал	хавьдал хөрөнө овоолго тээлт	Байршлын зураг	хавьдал хөрөнө 3-р овоолго тээлт	Журмын дагуу мөрдөж ажиллана	19916.57
7	2025-01-13	Утасны уурхайн тунцгал	Г.Баярмагдал	БО-ны мэргэжилтэн	ЦЗУ	Нүүрсний олоод	Нүүрсний олоодны тээлт	Байршлын зураг	Нүүрсний олоодны тээлт	Журмын дагуу мөрдөж ажиллана	4536.31
8	2025-01-14	Утасны оператор тунцгал	Г.Сэргэлтэн	БО-ны мэргэжилтэн	ЦЗУ	ВТ 1.4	Уурхайн ажилт	Байршлын зураг	Уурхайн ажилт	Журмын дагуу мөрдөж ажиллана	5387
9	2025-01-12	Ти Эн тунцгал	Ц.Цэнд-Мөнх	БО-ны мэргэжилтэн	ЦЗУ	ШТС-ын үнд талд	хөрөнө овоолго 3-4-ийн тээлт	Байршлын зураг	хөрөнө овоолго 3-4-ийн тээлт	Журмын дагуу мөрдөж ажиллана	120 000
10	2025-01-15	Овоолго талбайн ресурс ХХК	Э.Сандагдорж	БО-ны мэргэжилтэн	ЦЗУ	S өргөтгөлийн талбай	Нүүрсний олоодны тээлт	Байршлын зураг	Шийтгэж хуулах	Журмын дагуу мөрдөж ажиллана	58000
11	2025-01-15	Утасны оператор тунцгал	Ж.Энхцэцэг	БО-ны мэргэжилтэн	ЦЗУ	Нүүрсний S талбайн тээлт	Нүүрсний олоодны тээлт	Байршлын зураг	Шийтгэж хуулах	Журмын дагуу мөрдөж ажиллана	71678
12	2025-01-15	Ти Эн тунцгал	Б.Балдан-Осор	БО-ны ажилтан	ЦЗУ	ШО9-ийн зуун талд	Ато парк байгуулах	Байршлын зураг	Холбоодог журмын дагуу ажиллана	Шийтгэж хуулах	6500
13	2025-01-18	Утасны хангамжийн тунцгал	С.Анхдэлгэр	БО-ны мэргэжилтэн	ЦЗУ	Нүүрсний S талбайн тээлт зуун тал	Нүүрсний олоодны тээлт	Байршлын зураг	Шийтгэж хуулах	Журмын дагуу мөрдөж ажиллана	59100

Зураг № 54. Газар хөндөх журмын дагуу газар хөндөх зөвшөөрлийн бүртгэл үүсгэсэн байдал


5.4.2 Тусгай зөвшөөрлийн талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын явуулж буй ААН судалгаа хийх

2024.03.14-ний өдөр А/300 дугаартай Өмнөговь аймгийн Засаг даргын захирамжаар НБУ-ийн 10 км урттай авто замын бүтээн байгуулалтад ашиглах ТТАМ ашиглах түр зөвшөөрөл авсан. ТТАМ ашиглахыг зөвшөөрсөн талбай нь Цогтцэций сумын Сийрст багийн нутагт байрлах ба 24 га талбайг хамарна. (Хавсралт №15. Хуудас 102)



Зураг № 55. ТТАМ ашиглах түр зөвшөөрөл болон талбайн байрлалын зураг

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахын өмнө 2024.04.02-ны өдөр 2024/47 дугаартай албан бичгээр Өмнөговь аймгийн БОАЖГ-аас байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулсан ба нөхцөл болзолтойгоор ашиглуулах боломжтой гэсний дагуу 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж Өмнөговь аймгийн БОАЖГ-аар хянуулан батлуулсан.



Зураг № 56. Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2025 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Салбарын захирлын тушаалаар батлуулсан Тусгай зөвшөөрлийн талбайд үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын тооллого, бүртгэлийн ажлын үед давхар Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалт хийж буй газрын судалгааг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 25-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнд “Таны зам” ХХК нь Өмнөговь аймгийн Засаг даргын түр захирамжийн дагуу ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа нь бүртгэгдсэн. (Хавсралт №16. Хуудас 103)



Зураг № 57. "Таны зам" ХХК-ны захирамж

5.5 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
5.5.1	Уурхайн ахилтанд өртөж болзошгүй ховор болон, нэн ховор ургамлын байршлыг тогтоож, мэдээллийн санд оруулах, өртөх тохиолдолд шилжүүлэн суулгах	6-8-р сарын хооронд	Ахилтанд өртөх талбайд судалгаа хийж ховор ургамлын 10 ширхэг өргөст ортуузны бодгаль, 15 ширхэг улаан сухайг шилжүүлэн суулгасан.	100%
5.5.2	Нутгийн ургамлыг таниулах зорилго бүхий экологийн боловсрол олгох	2-оос багагүй удаа	Цогтцэций сумын ЕБС-ийн 150 ахлах, төгсөх ангийн сурагчдыг “Экологийн боловсрол олгох” удирдамжийн дагуу “Грийн Центр”-ийн хурлын танхимд сургалт хийж, “Эрдэнэс” агропарк, НБҮ-ийн үйл ажиллагаатай танилцуулсан.	100%

5.5.1 Уурхайн ахилтанд өртөж болзошгүй ховор болон, нэн ховор ургамлын байршлыг тогтоож, мэдээллийн санд оруулах, өртөх тохиолдолд шилжүүлэн суулгах

Цанхийн баруун зүүн уурхайн ахилтанд өртөж буй талбайгаас ургамлын тархалт, ховор ургамлын судалгааг гэрээт компанийн байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран төлөвлөгөөт ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн. Судалгаагаар ахилтанд өртсөн ургамлыг шилжүүлэн суулгах ажлыг зохион байгуулж өргөст ортууз, улаан сухайг авран хамгаалах ажлыг хийж гүйцэтгэсэн.



Зураг № 58. Ховор ургамлыг шилжүүлэн суулгасан байдал

5.5.2 Нутгийн ургамлыг таниулах зорилго бүхий экологийн боловсрол олгох

Салбарын захирлаар 2025 оны 09 сарын 18-ний өдөр батлуулсан "Экологийн боловсрол" олгох тухай удирдамжийн дагуу 09 сарын 21, 10 сарын 04-ны өдрүүдэд 2 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, Цогтцэций сумын ЕБС-ийн ахлах ангийн 150 сурагчдад ховор, нэн ховор ургамлын сургалт орж, "Эрдэнэс" агропарк хийгдэж байгаа ажлууд болон, НБҮ-ийн үйл ажиллагаатай танилцуулах аяллыг зохион байгуулсан.



Зураг № 59. Үйл ажиллагааны удирдамж болон нэгбүрийн хамгаалах хэрэгсэл тарааж буй байдал



Зураг № 60. Экологийн боловсрол олгох сургалт болон танилцах аялал хийж буй байдал

5.6 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
5.6.1	Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрч зэрлэг амьтдын идэш тэжээл ховордох үед хужир, долооц, мөс, өвс тэжээл байршуулан биотехникийн арга хэмжээг зохион байгуулах	>500 боодол	Цогтцэций сумын Засаг Даргын тамгын газраас 2025 оны 02 сарын 14-нд ирүүлсэн 1/115 тоот албан бичиг болон, БОМТ-нд туссаны дагуу "Биотехникийн арга" хэмжээг хэрэгжүүлсэн. Нийтдээ гэрээт байгууллагатай хамтран 5 удаагийн арга хэмжээгээр 530 боодол өвс, 10 боодол ногоон тэжээл, 600 кг хужир, 400 кг долооц Сийрст багийн "Хангинах"-ын хад болон "Цэций" хайрханд зэрлэг амьтанд зориулан байршуулсан. (Хавсралт №17. Хуудас 104)	100%

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
5.6.2	Зэрлэг амьтдад зориулсан ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах	2 ш	“Эрдэнэс Тавантолгой” ХК-иас Өмнөговь аймгийн Цогтцэций сумын байгаль хамгаалагчид Байршлыг тодорхойлуулах тухай утсаар холбогдож мэдээлсэн. Уг мэдээллийн дагуу Цогтцэций сумын байгаль хамгаалагчаас 2025 оны 07-р сарын 25-ны өдөр албан мэйл ирсэн бөгөөд уг мэйлд малчин иргэд ойлголтын зөрүүтэй байдлаас шалтгаалан энэ жил 2 байршилд хөв цөөрөм хийх байршил өгөх боломжгүй талаар мэдэгдсэн.	0%
5.6.3	Шувууны өртөлтийг багасгах зорилгоор өндөр хүчдэлийн шугамын трассаар хяналт хийж ажиллах	50 км	Шувууны өртөлтийн судалгааг гэрээт компанийн байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран Загийн усны хоолой, Цанхийн зүүн баруун уурхай, Таван толгой дэд станц зэрэг цахилгааны шугамын дагуу нийтдээ 126 км трасс бүхий газарт хийж гүйцэтгэсэн.	100%
5.6.4	“Эрдэнэс Тавантолгой” ХК болон гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын ажилтнуудад хулгайн ангаас сэргийлэх хууль эрхзүйн сургалтыг Цогтцэций сумын экологийн цагдаатай хамтран зохион байгуулах	>500 хүн	Цогтцэций сумын Экологийн цагдаатай хамтран “Грийн Центр”-ийн хурлын танхимд инженер техникийн ажилтнууд болон, гэрээт компанийн байгаль орчны мэргэжилтнүүдийг хамруулан 64 ажилтанд “Хулгайн антай тэмцэх” талаар сургалт орсон. Гэрээт байгууллагууд тус сургалтыг өөрсдийн 817 ажилтнуудад үргэлжлүүлэн сургалтыг зохион байгуулсан. Нийт 881 ажилтанд сургалтыг орсон байна.	100%

5.6.1 Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрч зэрлэг амьтдын идэш тэжээл ховордох үед хужир, долооц, мөс, өвс тэжээл байршуулан биотехникийн арга хэмжээг зохион байгуулах

Жил бүрийн “Биотехникийн арга” хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, БОМТ болон компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд, Цогтцэций сумын Засаг Даргын тамгын газраас 2025 оны 02 сарын 14-нд ирүүлсэн 1/115 тоот албан бичиг болон, албан бичгийн хавсралт төлөвлөгөөнд туссан заасан байршилд тус үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлсэн. Тус ажлыг гэрээт туслан гүйцэтгэгч “Ти Эн “ түншлэл, “ Үндэсний Уурхайчид” түншлэл, “Кэй Эй Майнинг” ХХК, “Овоот Толгой Ресурс” ХХК, “Үндэсний Оператор” түншлэл, “Үндэсний Манлайлал” түншлэлтэй хамтран Цогтцэций сумын Сийрст багийн “Хангинах”-ын хаданд хэрэгжүүлсэн. Мөн тус ажлыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг сайтар хангасан байсан учир нэмэлтээр сумын байгаль хамгаалагчийн хүсэлтээр Цэций хайрханд тус арга хэмжээг хэрэгжүүлсэн. Нийтдээ 5 удаагийн арга хэмжээгээр зэрлэг амьтдад зориулан 530 боодол өвс, 10 боодол ногоон тэжээл, 600 кг хужир, 400 кг долооц тус ажлын хүрээнд тараан байршуулсан. (Хавсралт №17. Хуудас 104)



Зураг № 61. Биотехникийн ажил зохион байгуулдаг талбайн байршлын зураг



Зураг № 62. Биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлж буй байдал

5.6.2 Зэрлэг амьтдад зориулсан ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах


Зэрэг ан амьтанд зориулсан хөв цөөрөм байгуулах ажлыг Цанхийн уурхайн олборлолтын гэрээт байгууллагуудын тухай жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хийлгэхээр тусгуулан БОМТ-г батлуулсан.

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК-ийн 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ		ka mining		БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	
4.2.1	Ариг тамгүй эрт их усны хэрэглээ	Усны зохицтой шилжлтийн талвар сургалт явуулах. Усны тэмдэглэлт	Уурхайн бүс	4	Жилд Уйл ажиллагааны зардал
4.2.1.1	Сүүрийн саврын боомтод гадаргын ус хуримтлуулах (хөв цөөрөм/инженерийн ЦЗУ-н КАМ-тай хамтран байгуулаж барих)	Уурхайн бүс	1	Жилд	Уйл ажиллагааны зардал
4.2.1.2	“Эрдэнэс Тавантолгой” ХК болон Цогтцэций сумын нөлөөллийн бүсийн 2 ширдэг малчдын худгийн ам лийдах болон худгийн байр барих ажлыг гүйцэтгэх	Нөлөөллийн бүс	2	7, 8,9 сард	Уйл ажиллагааны зардал
4.2.1.3	Уйлдвэрлэлийн 2 ш, унд ахуйн 1 ш хуудайг шинээр гаргаж, тоноглох	Уурхайн бүс	1	Жилд	Уйл ажиллагааны зардал
4.2.1.4	Шүүрийн ус гарсан хэсэгт болгоомжсон усны тоолуур суурталуулах, нөөц помпын болон байдлыг хангах	Уурхайн бүс	1	Тогтмол	

Зураг № 63. Гэрээт байгууллагын БОМТ-ийн төлөвлөгөөнд хөв цөөрөм байгуулах ажлыг тусгасан байдал


Гэрээт байгууллагуудаас зэрлэг ан амьтанд зориулсан хөв цөөрөм байгуулах байршлыг тодорхойлж өгөх тухай мэдэгдсэн дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас Өмнөговь аймгийн Цогтцэций сумын байгаль хамгаалагчид Байршлыг тодорхойлуулах тухай утсаар холбогдож мэдээлсэн. Уг мэдээллийн дагуу Цогтцэций сумын байгаль хамгаалагчаас 2025 оны 07-р сарын 25-ны өдөр албан мэйл ирсэн бөгөөд уг мэйлд

малчин иргэд ойлголтын зөрүүтэй байдлаас шалтгаалан энэ жил 2 байршилд хөв цөөрөм хийх байршил өгөх боломжгүй талаар мэдэгдсэн.



Зураг № 64. Цогтцэций сумын байгаль хамгаалагчаас ирүүлсэн албан мэйл

Компанийн зүгээс зэрлэг ан амьтанд зориулсан хөв цөөрмийг Биологийн олон янз байдал дүйцүүлэн хамгаалах ажил гүйцэтгэж буй Шангай, Дугантын хэц орчмын 99000 га талбайд хийхээр агаар сансрын зураг ашиглан ArcGIS программ дээр ус хурах талбайн судалгааг хийж гүйцэтгэсэн.



Зураг № 65. Дүйцүүлэн хамгаалах талбайд хийсэн хөв цөөрөм байгуулах боломжийн судалгаа

Уг судалгаагаар тохиромжтой гэж гарсан 4 байршил нь зөвхөн хур бороонд түшиглэсэн газар бөгөөд малчин айл ихтэй, зэрлэг ан амьтан ирж ус уух боломж маш ховор болох нь тогтоогдсон учир сумын байгаль хамгаалагч болон малчин иргэдийн саналыг харгалзан үзэхээс өөр боломжгүй нөхцөл байдал үүссэн.

5.6.3 Шувууны өртөлтийг багасгах зорилгоор өндөр хүчдэлийн шугамын трассаар хяналт хийж ажиллах

Шувууны өртөлтийн судалгааг төлөвлөгөөт ажлын хүрээнд гэрээт байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн. Үүнд: “Овоот Толгой Ресурс” ХХК, “Кэй Эй Майнинг” ХХК, “Үндэсний Манлайлал” түншлэл, “Ти Эн” түншлэл, “Үндэсний Оператор” түншлэл, “Үндэсний Уурхайчин” түншлэлтэй хамтран хийж гүйцэтгэв. Шувууд өндөр хүчдэлийн шугамнаас болж эндэх нь тухайн зүйлийн тоо толгой буурах гол үндэс болж байна. Судалгааны дараа хийгдэх үр дүнгээр цаашид хийгдэх ажлын зорилго тодорхойлогдоно.

Хүснэгт № 22. Шувуу өртөлтийн судалгаа хийсэн мэдээлэл

№	Судалгаа явуулсан байршил	Гэрээт байгууллага	Нийт трасс	Хугацаа
1	Цогтцэций сумын цахилгаан шугамын төв станцаас “Монгол Майнинг энд Эксплорейшн” ХХК-ийн хотхон, “Билгэх” баг буюу орон нутгийн тосгоны КТПА-аас “Үндэсний Оператор Түншлэл”-ийн оффис	“Үндэсний Оператор түншлэл”	23 км	IV/20
2	Загийн Усны хоолойн цахилгааны шугам дагуу	“Кэй Эй Майнинг” ХХК Үндэсний Уурхайчид Түншлэл	12.3 км	IV/21
3	Загийн Усны хоолойн цахилгааны шугам дагуу	“Кэй Эй Майнинг” ХХК	24.7 км	VIII/08
		Үндэсний Уурхайчид Түншлэл	36.9 км	
4	Цанхийн Зүүн болон Баруун уурхайн цахилгааны шугам	“Овоот Толгой Ресурс” ХХК	15.3 км	VIII/24
5	Таван толгой дэд станцаас 110 дэд станц хүртэл	Ти Эн Түншлэл	14.7 км	IX/27
6	“Үндэсний Манлайлал” Түншлэл	“Үндэсний Манлайлал” Түншлэл	20 км	X/18
Нийт			126 км	

Шаардлагатай бэлтгэл ажлыг хангаж (Газарзүйн байршил тогтоогч GPS, дуран, зургийн аппарат, агаарын шугамын байрзүйн зураг,) зэргийг бэлтгэн хүснэгтээр оруулсан хугацааны дагуу шувуу өртөлтийн судалгааны ажлыг хэрэгжүүлсэн. Судалгааг гүйцэтгэхдээ агаарын шугамын дагууд явганаар болон суудлын тэргээр бага хурдтайгаар цахилгааны шугам болон төмөр бетон тулгуурын эргэн тойронд шувууны сэг зэм, өд байгаа эсэхэд ажиглалт хийсэн. Судалгааны явцад цахилгаан дамжуулах агаарын шугамын болон тулгуур анкеруудын доор Цанхийн Зүүн болон Баруун уурхайн цахилгааны шугамын доор илэрсэн. Үүнд:

Хүчдэлийн шонгийн ойр орчимд эндсэн шувуудын 30% орчим нь хүчдэлийн шон доор байгаа бол 70% нь хүчдэлийн нөлөөллийн ойролцоо унаж эндсэн байна. Нийтдээ 84 тулгуурыг шалгахад нийт 5 зүйлийн 26 бодгаль шувуу шонгийн хүчдэлд цохиулж эндсэн. Үүнд: Шилийн сар (**Buteo hemilius**) зонхилох хувийг эзэлж байна. Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооны “Улаан Данс”-ны шалгуур үзүүлэлтээр олон улсын хэмжээнд “**устаж болзошгүй**” бүс нутгийн хэмжээнд “**эмзэг**” ангилалд орсон идлэг шонхор (**Falco chery**) 2ш бодгаль цахилгаанд цохиулж эндсэн байна.



Зураг № 66. Шувуу өртөлтийн судалгааг хийж буй байдал

5.6.4 “Эрдэнэс Тавантолгой” ХК болон гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын ажилтнуудад хулгайн ангаас сэргийлэх хууль эрхзүйн сургалтыг Цогтцэций сумын экологийн цагдаатай хамтран зохион байгуулах

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сум дахь салбарын “Грийн Центр”-ийн хурлын танхимд 2025 оны 10 сарын 20-нд Цогтцэций сумын Экологийн цагдаатай хамтран “Хууль бусаар ан агнах, загасчлах гэмт хэргийн талаарх ойлголт, түүнд хүлээлгэх хариуцлага” сэдэвт сургалтыг Цанхийн баруун зүүн уурхайн гэрээт байгууллагууд болох “Овоот Толгой Ресурс” ХХК, “Үндэсний Манлайлал” түншлэл, “Ти Эн” түншлэл, “Кэй Эй Майнинг” ХХК, “Үндэсний Уурхайчид” түншлэл, “Үндэсний Оператор” түншлэлийн байгаль орчны мэргэжилтэн болон уурхайн инженер техникийн ажилтнуудыг хамруулан зохион байгуулсан. (Хавсралт №18. Хуудас ...)



Зураг № 67. Сургалт зохион байгуулж буй байдал



Зураг № 68. Сургалтыг Цогтцэций сумын сум дундын Цагдаагийн тасагтай хамтран зохион байгуулж буй байдал

Тус сургалтын материалын дагуу гэрээт байгууллагын Байгаль орчны мэргэжилтэн нар тус тусын компанийн ажилтнуудад хулгайн антай холбоотой сургалтыг орсон бөгөөд “ТН түншлэл”-ийн 53 ажилтан, “Үндэсний оператор түншлэл”-ийн 225, “Кэй Эй Майнинг” ХХК-ийн 99, “Үндэсний уурхайчин түншлэл”-ийн 440 ажилтан, нийт 817 ажилтанд тус сургалтыг орсон байна.

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

6.1 Техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
6.1.1	Шартээг-13.5км автозамыг холбосон 2.9км хатуу хучилттай авто зам ашиглалтад орсны дараа хуучин шороон замыг нөхөн сэргээх	2.3 га	IDMN хотхоноос Цогтцэций сумын 13.5 км зам хүртэлх хуучин 2.9 км шороон зам буюу 2.76 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж Өмнөговь аймгаас томилогдсон ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.	100%
6.1.2	Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн авто зам дагуу 0-25 дахь км хүртэлх замын хажуугаар олон салаа шороон зам үүсэхээс сэргийлсэн шороон далан, шуудууг нөхөн сэргээх	1 га	Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн авто замын 0-25 км хүртэлх замын хажуугаар гарсан олон салаа замыг хааж, шороон далан, суваг шуудууг сэргээн татаж нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%
6.1.3	Шартээг-13.5км автозамыг холбосон 2.9 км хатуу хучилттай авто зам ашиглалтад орсны дараа Баруун нарангийн авто замаас салаалсан ачаа тээврийн 7.4 км шороон замыг хэсэгчлэн нөхөн сэргээх	7.4 га	Тавантолгой-Ханги мандал чиглэлийн автозам дагуух сайжруулсан 9 км шороон замын техникийн нөхөн сэргээлтийг Үндэсний манлайлал түншлэл, Кэй Эй майнинг ХХК, Овоот толгой ресурс ХХК-тай хамтран хийсэн. Тус 9 км замын 4 км замын дэвсгэлтийн шороог нь авч 4га талбайн ТНС-ийг ажлын хэсэгт хүлээлгэн өгч акт үйлдсэн.	100%

6.1.1 Шартээг-13.5км автозамыг холбосон 2.9км хатуу хучилттай авто зам ашиглалтад орсны дараа хуучин шороон замыг нөхөн сэргээх

2025 оны 10 дүгээр сарын 12-ний өдөр IDMN хотхоноос Цогтцэций сумын 13.5 км хүртэлх 2.9 км хуучин шороон зам болох 2.76 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг 2025 оны 10 дүгээр сарын 17-ний өдөр Өмнөговь аймгийн Байгаль орчны газрын ирсэн ажлыг хэсэгт хүлээлгэн өгч актаар баталгаажуулсан. (Хавсралт №19. Хуудас 108-116)



Зураг № 69. Техникийн нөхөн сэргээлт хийхийн өмнөх байдал



Зураг № 70. Техникийн нөхөн сэргээлт хийсний дараах байдал



Зураг № 71. Нөхөн сэргээлт хийсний дараах агаарын зураг

6.1.2 Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн авто зам дагуу 0-25 дахь км хүртэлх замын хажуугаар олон салаа шороон зам үүсэхээс сэргийлсэн шороон далан, шуудууг нөхөн сэргээх

Өмнөговь аймгийн Байгаль орчны газрын дүгнэлт, зөвлөмжийн дагуу Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн авто зам дагуух 0-25 дахь км хүртэлх олон салаа шороон зам, хаягдлын овоолго, шороон далан, шуудууг сэргээх ажлыг 2025 оны 07 сарын 31-ний өдөр “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны газрын даргын баталсан техникийн нөхөн сэргээлт хийх ажлын төлөвлөгөөний дагуу Цанхийн зүүн уурхайн “Ти Эн Түншлэлтэй” хамтран 2025 оны 10 дүгээр сарын 20-ний өдөр хийж гүйцэтгэсэн. Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн 0-25 км авто зам дагуу замын хажуугаар олон салаа шороон зам үүсэхээс сэргийлсэн шороон далан шуваг шуудууг нөхөн сэргээх ажлын хүрээнд зөвшөөрөлгүй гаргасан нийт 16 орц гарцыг хааж, зам дагуух шуудууг сэргээсэн.

Хавсралт-1			
НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУВААРЬ			
№	Гэрээт компанийн нэр	Газрын байршил/солбицол	Хугацаа
1		IDMN хотхон-13.5 км хүртэлх хуучин шороон зам	2025.08.01-2025.08.10
2	Ти Эн Түншлэл	Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн авто зам дагуу 0-25 км	2025.08.10-2025.08.20
3	Үндэсний оператор түншлэл	43°44'26.63"N, 105°41'32.38"E : 43°43'29.76"N, 105°40'9.26"E /Таван толгой-Ханги чиглэлийн хуучин нүүрс тээврийн шороон зам/	2025.08.01-2025.08.15
4	Үндэсний уурхайчид түншлэл	43°43'29.76"N, 105°40'9.26"E : 43°42'46.24"N, 105°38'36.01"E /Таван толгой-Ханги чиглэлийн хуучин нүүрс тээврийн хуучин шороон зам/	2025.08.01-2025.08.15
5	Овоот толгой ресурс	43°42'46.24"N, 105°38'36.01"E : 43°41'46.17"N, 105°37'56.94"E /Таван толгой-Ханги чиглэлийн хуучин нүүрс тээврийн хуучин шороон зам/	2025.08.01-2025.08.15
6	Үндэсний манлайлал түншлэл	43°41'46.17"N, 105°37'56.94"E : 43°40'36.59"N, 105°38'5.46"E /Таван толгой-Ханги чиглэлийн хуучин нүүрс тээврийн хуучин шороон зам/	2025.08.01-2025.08.15

Жич: Хуваарилагдсан талбайн хэсгийн хуучин шороон замын цөмрөн, ховил үүссэн газрын хэсгийг автогрейдер, дууруйт ачичвар сийрүүлж байгалийн унаван төрхөнд нь оруулах, түрж тэгшлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Зураг № 72. Техникийн нөхөн сэргээлт хийх батлагдсан хуваарь



Зураг № 73. Орц, гарц хааж суваг шуудууг сэргээж буй байдал

6.1.3 Шартээг-13.5км автозамыг холбосон 2.9 км хатуу хучилттай авто зам ашиглалтад орсны дараа Баруун нарангийн авто замаас салаалсан ачаа тээврийн 7.4 км шороон замыг хэсэгчлэн нөхөн сэргээх

Шартээг-13.5км автозамыг холбосон 2.9 км хатуу хучилттай авто зам ашиглалтад орсны дараа Баруун нарангийн авто замаас салаалсан ачаа тээврийн 7.4 км шороон замыг хэсэгчлэн нөхөн сэргээх ажлыг дүйцүүлэн Таван толгой-Ханги чиглэлийн хуучин нүүрс тээврийн 9 км авто замын нөхөн сэргээлтийн ажлыг 2025.08 сар, 9 саруудад Цанхийн баруун уурхайн Овоот толгой ресурс ХХК, Үндэсний манлайлал түншлэл,

Үндэсний уурхайчин түншлэл, Үндэсний оператор түншлэл компаниуд тус 9 км буюу 9 га талбай бүхий сайжруулсан шороон замыг сийрүүлэх, шороон далан,суваг шуудууг тэгшлэх нөхөн сэргээх, зам дагуу хогыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж ажилласан. 2025 оны 10-р сарын 07-ны өдөр Өмнөговь аймгийн Байгаль орчны газраас томилогдсон ажлын хэсэг Техникийн нөхөн сэргээлт хийсэн 4 га талбайд ажилласан бөгөөд “ТТСТ” ХХК-ны замын нөхөн сэргээлтийг нэмэлтээр сайжруулах байдлаар шаардлага хүргүүлсэн.



Зураг № 74. Техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал

2025 оны 11 сарын 18-23-ны хооронд ажлын хэсгээс өгсөн шаардлагын дагуу тус замын 0-4 км дэх дэвсэлтийн материалыг авч 4га талбайн ТНС-ийг ажлыг хийж ажлын хэсэгт хүлээлгэн өгч акт үйлдэн баталгаажуулсан.



Зураг № 75. Ажлын хэсэгт газар дээр нь ажиллаж буй байдал

6.2 Биологийн нөхөн сэргээлтийн бэлтгэл үе шат

№	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт
6.2.1	Хоёр жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлж олон наст өвслөг ургамал тариалах	3 га	Гэрээт компанитай хамтран хаагдсан шимт хөрсний овоолгын 11.3 га талбайд хаврын тарилтаар төлөвлөж 6 га талбайд тарилтыг ажлыг хийсэн.	100%
6.2.2	Модлог ургамлын үрийн нөөц бүрдүүлэх	>10 кг	Дүйцүүлэн хамгаалах талбайгаас шар модот хотирын үр 2 кг түүсэн. Мөн бүйлсний 10 кг, таримал жигд үр 4 кг, таримал агч 14 кг тус тус гэрээт компаниудтай хамтран үрийн нөөц бүрдүүлсэн.	100%

БАТЛАВ
САЛБАРЫН ГАЗРЫН ДАРГА
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ
БАЙГАЛЬ ОРЧНЫ
Б. БАТСАЙХАН

УУРХАЙН ШИМТ ХӨРСНИЙ ОВООЛГЫН ТАЛБАЙД БИОЛОГИЙН
НАХИН СЭРГЭЭЛТЭЙ ХИЙЖ АЖЛЫН ТӨЛӨВӨЛГӨӨ

ҮНДЭСЛЭЛ:
 ✓ Цанхийн уурхайн 2025 онд хэрэглүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө;
 ✓ Цанхийн уурхайн явц хуулиар, нууц олборлолтын ажил гүйцэтгэх гэрээт
 холбооны 2025 онд хэрэглүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө;
 ✓ Байгаль орчны нэгдсэн үйлчилгээний үйлчилгээний байрны 2015 оны А-78 дугаар
 тушаалын хавсралтаар батлагдсан "уур уурхайн үйл ажиллагааны улмаас явцдаг
 орон газар төмөр замын болон бусад хэргийг хамгаалах ажил" гэдэг;
 ✓ MNS 5014.2008 "Эвдрэлсн газрын нөхөн сэргээлт: Нэг томьёо, тэдгээрийнх" гэдэг;
 ✓ MNS 3915.2005 "уур уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар явцдаг газрын
 ажиллагаа" гэдэг;
 ✓ MNS 5016.2008 "Улаа болгоны ажил үнд шимт явц зуураг, хадгалах" гэдэг;
 ✓ MNS 5017.2008 "уур уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар явцдаг газрын
 нөхөн сэргээлт: Төмөр замын шаардлага" гэдэг;
 ✓ MNS 5018.2023 "Эвдрэлсн газрын ургамалжуулах: Төмөр замын шаардлага" гэдэг.

ЗОРИЛГО:
 Цанхийн уурхайн олборлолтын явцад өргөж буй хөрсний ажил үнд шимт явц зуураг, хадгалах, нөхөн сэргээх, мөн түүний ургамал үр болон олон наст ургамалаар тариажүүлж, хөрсний үрэг шимийг алдагдуулалгүйгээр эрчим хамгаалахад оршино.

ХАМРАХ ХҮҮРЭЭ:

№	Тайлбар	Холбоо
1	"ТИ ЭН ТҮНЦЛЭГ"	Цанхийн уурхайн
2	"ХЭЙ ЭН МАЙНИНГ" ХХК	ЭТТ-2024/1171 ЭТТ-2023/1487
1	ҮНДЭСНИЙ ОПЕРАТОР ТҮНЦЛЭГ	Цанхийн баруун уурхай
2	"ОБООТ ТОЛГОЙ РЕСУРС" ХХК	ЭТТ-2023/1444 ЭТТ-2024/448
3	ҮНДЭСНИЙ МАНЛАЙЛАЛ ТҮНЦЛЭГ	ЭТТ-2024/208
4	ҮНДЭСНИЙ УУРХАЙНД ТҮНЦЛЭГ	ЭТТ-2023/1487

ШИМТ ХӨРСНИЙ ХУВААРЬ:

№	Тайлбар	Норматив	Төрөл	Тайлбар
1	"ТИ ЭН ТҮНЦЛЭГ"	ETS-19.2.1 ETS-19.1.7	2.5	2.5
2	"ХЭЙ ЭН МАЙНИНГ" ХХК	WTS-4.2.3 WTS-4.1.5	2.5	2.5
3	ҮНДЭСНИЙ ОПЕРАТОР ТҮНЦЛЭГ	WTS-4.2.1 WTS-4.1.1	2.5	2.5
4	"ОБООТ ТОЛГОЙ РЕСУРС" ХХК	WTS-4.2.2 WTS-4.1.2	2.5	Тухай үед байршилг мэдэгдэнэ
5	ҮНДЭСНИЙ ОПЕРАТОР ТҮНЦЛЭГ	WTS-4.2.3 WTS-4.1.3	2.5	2.5
6	ҮНДЭСНИЙ УУРХАЙНД ТҮНЦЛЭГ	WTS-4.2.4 WTS-4.1.4	2.5	2.5

ХИНАСАН
 САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
 БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ХЭЛТСИЙН ДАРГА
 БАЙГАЛЬ ОРЧНЫ УСНЫ БОДЛОГЫН
 ОННОО: *[Signature]* МАНУДАРЬ

САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
 БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ
 УСНЫ БОДЛОГЫН ХЭЛТСИЙН АХУАЙНЖИД
 БАЙГАЛЬ ОРЧНЫ
 ОННОО: *[Signature]* Ц.БҮРЭНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:
 САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
 БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ
 УСНЫ БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ИНЖЕНЕР
 БАЙГАЛЬ ОРЧНЫ
 ОННОО: *[Signature]* Т.НАЦАГ

САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
 БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ
 УСНЫ БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ИНЖЕНЕР
 БАЙГАЛЬ ОРЧНЫ
 ОННОО: *[Signature]* Б.ОНОН

Зураг № 77. Шимт хөрсний овоолгод тарилт хийж хуваарь болон батлагдсан төлөвлөгөө



Зураг № 78. Шимт хөрсний овоолгод хийгдсэн тариалалтын ургасан байдал

6.2.2 Модлог ургамлын үрийн нөөц бүрдүүлэх

Говийн бүсэд дасан зохицох модлог ургамлын үр, олон наст зүлэг, цэцгийн мандалын үр түүж бэлтгэх, худалдан авах ажлыг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

Хүснэгт № 23. Модлог ургамлын үрийн хэмжээ

№	Модны нэр, төрөл	Тоо хэмжээ, кг	Үр түүсэн газар	Тайлбар
1	Шар хотир (<i>Zygophyllum xanthoxylon</i> Vge. Maxim.)	2	Цогтцэций сум Билгэх баг Дугантын задгай	Дүйцүүлэн хамгаалах талбай орчмоос түүсэн.
2	Агч	14	Худалдан авалтаар	Гэрээт байгууллагатай хамтран бэлтгэсэн.
3	Жигд	4		
4	Бүйлэс (<i>Amygdalus mongolica</i>)	10		
Нийт		30		

Дүйцүүлэн хамгаалах талбайгаас шар модот хотирын үр 2 кг түүсэн. Мөн бүйлсний 10 кг, таримал жигд үр 4 кг, таримал агч 14 кг тус тус гэрээт компаниудтай хамтран үрийн нөөц бүрдүүлсэн.



Зураг № 79. Шар модот хотирын үр түүж байгаа байдал

6.2.3 Модлог ургамлын мөчир бэлтгэх

Модлог ургамлын модлог мөчир бэлтгэх ажлыг Цогтцэций сум, Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт байрлах Тавантолгой тосгоны 0.45 га талбай бүхий эх модны талбайгаас модлог мөчир бэлтгэх ажлыг ургамлын тайван байдалд орсон үед буюу 2025 оны 1-2 сард зохион байгуулсан.

Хүснэгт № 24. Модлог ургамлын мөчир бэлтгэсэн байдал

№	Модны нэр, төрөл	Тоо ширхэг	Мөчир бэлтгэсэн газар	Тайлбар
Модлог ургамлын мөчир				
1	Лавр навчит улиас (<i>Populus laurifolia L.</i>)	5500	Цогтцэций сум Цагаан-овоо баг	Эх модны талбай
2	Мөнгөлөг улиас (<i>Populus alba L.</i>)	2000	Худалдан авалтаар	“Нормаунт” ХХК



Зураг № 80. Эх модны талбайн улиас, сухайн модлог мөчир авах бэлтгэл ажил хийж буй байдал

Эх модноос бэлтгэсэн мөчрийн тайрдсыг нүх ухаж цасаар хучиж өвөлжүүлсэн. Хавар 4 сард гаргаж мөчрийг тарилтанд бэлтгэж 20-25см урттай тайрч 5500 ширхэг харандаа хийж усанд 48 цаг дэвтээсний дараа мөчрийн бэлтгэсэн талбайд тариалсан.



Зураг № 81. Мөчрийг мөчирлөж, тарьц буй байдал

6.2.4 Хүнсний ногооны хаягдал ашиглан био компост бордоо бэлтгэх

Ажилчдын хотхоны нийтийн хоол үйлдвэрлэлээс гарсан ангилсан хүнсний хаягдлыг авч мод үржүүлгийн “Эрдэнэс” агропаркийн био компост боловсруулах бэлтгэсэн талбайд авчирж био компост бэлтгэх ажлыг хэрэгжүүлсэн. Био компост бэлтгэх зориулалттай тус бүр нь 300 литрийн багтаамж бүхий 10ш саванд бордоошуулагч ашиглан био компост бэлтгэсэн. Тус онд нийтдээ 3 тн орчим бордоог бэлтгэж бордоошуулаад байна.



Зураг № 82. Био компост бэлтгэх үйл явцын зураг

Өмнө жил бэлтгэсэн 3 тн биокомпостны шингэн бордоог мод үржүүлгийн “Эрдэнэс” агропаркийн талбайн хашааны урд талбайд шуудуулж тарьсан 3000ш сухай,

5000ш хайлаас модыг бордох ажлыг хийсэн. Тус бордоог шуудуунд усаар дамжуулан хийж ургалтын хувийг нэмэгдүүлсэн.



Зураг № 83. Өмнө жил бэлтгэсэн бордоогоор модлог ургамлыг бордож буй байдал

6.2.5 Модлог ургамлыг үр, мөчир хэлбэрээр үржүүлэх

“Эрдэнэс” агропаркийн 10 га мод үржүүлгийн 1450мкв бүхий хүлэмжийн талбай, ил талбайд далан үүсгэж, модны үр, мөчир тарих, үрсэлгээг бортгонд хөрс боловсруулж шилжүүлэх, услах зэрэг үе шаттай ажлууд хийгддэг. Мод үржүүлгийн ажлыг 4 инженер, 3 туслах ажилтан, 2 усны машины операторын бүрэлдэхүүнтэй 2 ээлжээр хийж гүйцэтгэсэн.



Зураг № 84. Агропаркад модлог ургамлыг үр мөчрөөр үржүүлж буй байдал

Зуны хүлэмжид өвөл 1-3 сард хар шороо хөрсийг шигшиж элстэй хольж бортгонд савлаж хүлэмж рүү зөөж өрсөн. Нэг хүлэмжид 5500 ширхэг бортого 3 эгнээ үүсгэж усалгааны системийг өөрчлөн газраар бороожуулагчийн хошуугаар хийж нийтдээ 16500 ширхэг бортогог бэлтгэж хавар тарилтыг 04 сарын 23-с эхлэн 5 сарын 20-г дуустал гэрээт компани ажилчид, хэлтсийн инженерүүдтэй хамтран 38 кг үр тарьж усалж ургуулсан.

Хүснэгт № 25. 2025 онд хүлэмжид үржүүлсэн модны тоо, хэмжээ

№	Модны төрөл	Хүлэмжийн төрөл, хэмжээ	Нэг хүлэмжийн бортогны тоо	Үрийн хэмжээ, кг	Амьдралтын хувь
1	Гүйлс	Зуны 6*20-1	5500	15	85
2	Харгана	Зуны 6*20-1	5500	3	10
3	Бүйлс	Зуны 6*20-1	5500	12	85
4	Жигд	Өвлийн 10*40	11100	6	90
5	Шар хуайс	Өвлийн 10*40	3100	2,7	85
Нийт			30700	38,7	



Зураг № 85. Үрээр тарилт хийж буй байдал

Ил талбайн хөрс боловсруулалт: Мод үржүүлгийн 10 га талбайд өмнөх жилийн 50:25м харьцаатай ил талбайд хөрсийг усалж, улиасны мөчрөөр нөхөн тарилт хийсэн. Нөхөн тарилт хийхээс өмнө хатсан мөчрийг сугалах, услах, хар плёнкийн урагдсан хэсгийг нөхөн зэрэг бэлтгэл ажлыг хангаж өөрсдийн бэлдсэн 7500 ширхэг улиасны мөчрийг тарьж усалгаа арчилгааг тогтмол хийж ажилласан.



Зураг № 86. Мөчрөөр үржүүлэх ил талбай бэлтгэж буй байдал

Эх модны талбайгаас өөрсдийн бэлтгэсэн лавр навчит улиасны мөчрийг тарилтанд бэлтгэж усанд дэвтээсэн. Тус талбайн дуслын усалгаагаар 12 цаг усалж 8 ширхэг даланд 7500ш мөчрийн тарилтыг 2024 оны 05 сарын 01-05-ний хооронд гэрээт компани ажилтнуудтай хамтран бэлтгэсэн талбайд тариалах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Тарилтын дараах усалгааг өдөр бүр хийж, давхар сухай мөчрийн усалгааг хийж нийлмэл бордоог хийж ургалтыг нэмэгдүүлсэн. 10 дугаар сарын байдлаар амьдралтын хувь 85 байхаар тооцож гаргасан.

Хүснэгт № 26. 2025 онд ил талбайд үржүүлсэн мөчрийн тоо, хэмжээ

№	Модны төрөл	Талбай хэмжээ	Мөчрийн тоо	Үрийн норм/гр	Амьдралтын хувь
1	Лавр навчит улиас	50*25	5500	-	85%
2	Мөнгөлөг улиас	50*25	2000	-	35%

Нийт	7500		
------	------	--	--



Зураг № 87. Мөчрөөр тарилт хийж буй байдал

Бүх нийтийн мод тарих өдөр: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 04 сарын 03-ны өдрийн Дугаар 44 “Тэрбум мод тарих” үндэсний өдөр зарлах тухай зарлигийн дагуу, Монгол улсын Ерөнхийлөгчийн 9 дүгээр сарын 01-ний өдрийн 1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг жил бүрийн 5, 9 дүгээр сарын Бямба, Ням гарагт тэрбум мод тарих өдөр болгон зарласны дагуу Хавар, Намрын мод тарих өдрийг тэмдэглэн хамт олноороо мод тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлж ажилласан.

Шаардлагатай бэлтгэл ажлыг хангаж, мод үржүүлгийн “Эрдэнэс” агропаркийн талбайд үрээр үржүүлсэн модны суулгацнаас хавар “Грийн Центр”-ийн засмал замын дагуу, намар мод үржүүлгийн 2 га талбайд мод тарих ажлыг хийж усалгаа, арчилгааг хийж гүйцэтгэсэн.



Зураг № 88. Бүх нийтийн мод тарих өдрийг зохион байгуулж буй байдал

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Дүйцүүлэн хамгаалах газар нутгийг тогтоохдоо уурхайн олборлолтын үйл ажиллагаа идэвхтэй явагдаж буй талбай болон нөлөөлөлд өртсөн талбайгаас ойр байх экологийн хувьд дүйцэхүйц байх зарчмыг баримтална. 2019 онд уурхайн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөх талбайн хэмжээг тодорхойлсны үндсэн дээр дүйцүүлэн хамгаалах талбайн хэмжээг тогтоосон бөгөөд Өмнөговь аймгийн Байгаль орчны газар болон сумын ЗДТГ-т танилцуулан дүйцүүлэн хамгаалал явуулах талбайн байршлыг тогтоосон. Дүйцүүлэн хамгаалахаар тогтоосон газар нь 28км өргөнтэй, 36км урттай нийт 99000га талбайг хамрах бөгөөд Цагаан-Овоо, Билгэх багийн нутгийг дамнан оршино.

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ нөлөөллийг бууруулах шатлал буюу зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах зарчмыг баримтална.



2019 оноос хойш тус талбайд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр холбогдох ажлуудыг мэргэжлийн байгууллагаар шат дараатайгаар гүйцэтгүүлж байгаа бөгөөд 2025 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөн хийж гүйцэтгээд байна.

7.1 Амьтны олон янз байдлыг хамгаалах

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
7.1.1	Махчин шувууд суух боломжтой хиймэл үүр суурилуулах	5 ш	Дүйцүүлэн хамгааллын талбайд махчин шувуу суух, үүрээ засах боломжтой үүрийг гар доорх материалаар хийж дугант, шангайн хэц орчмоор 5 ширхгийг байрлуулсан.	100%
7.1.2	Хууль бус хулгай антай тэмцэх ажлын хүрээнд орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах	-	2025 онд Цогтцэций сумын нутаг дэвсгэрт хулгайн антай тэмцэх ажлын хүрээнд олборлолтын гэрээт байгууллагуудын тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тус бүр 2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж зардлыг тусгуулан батлуулсан.	100%
7.1.3	Амьтны камерын өгөгдлийг цуглуулан боловсруулж, дүн шинжилгээ хийх	3	Дүйцүүлэн хамгаалах талбайн Дугант, шангайн хэц орчимд хоёр байршилд амьтны камерыг байрлуулан 5 сарын хугацаанд байршуулан өгөгдлийг цуглуулсан. Амьтны камерын өгөгдөлд ихэвчлэн 5 хошуу мал ихээр бичигдсэн бөгөөд тас шувуу, цармын бүргэд, цөлийн чогчиго зэрэг жигүүртэн шувууд өртсөн байна.	100%

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
7.1.4	Зүүнбаян чиглэлийн Төмөр замын орчимд хар сүүлтийг хүзүүвчлэн тандан судалгаа гүйцэтгэх	1	Дүйцүүлэн хамгаалах талбайд хийгдэх Зүүнбаян чиглэлийн төмөр замын орчимд хар сүүлт гөрөөсийг хүзүүвчлэн тандан судалгааны ажил гүйцэтгэх ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр захиалгын хуудсыг 2025 оны 02-р сарын 27-ны өдөр батлуулан компанийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Компанид тогтоосон онц байдлаас шалтгаалан одоогоор тендер шалгаруулалт зарлагдаагүй байна.	0%

7.1.1 Махчин шувууд суух боломжтой хиймэл үүр суурилуулах

Махчин шувууд ялангуяа шилийн сар, идлэг шонхор, хон хэрээ зэрэг шувууд өндөр хүчдэл дээр сууж, үүрээ засаж эндэх тохиолдол элбэг ажиглагдаж байна. Тус шувууны байрлалыг өндөр хүчдэлээс холдуулах зорилгоор 2025 оны 10 сарын 05-ний өдөр дүйцүүлэн хамгаалах талбайн дугант, шангайн хэц орчмоор махчин шувуу сууж, үүрлэх боломжтой хиймэл үүрийг 5 ширхэгийг суурилуулсан.



Зураг № 89. Шувуу сууж үүр засах суултыг бэлтгэж байрлуулсан байдал



Зураг № 90. Суулт байрлуулсан цэгийн байршлын зураг

7.1.2 Хууль бус хулгай антай тэмцэх ажлын хүрээнд орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах

2025 онд Цогтцэций сумын нутаг дэвсгэрт хулгайн антай тэмцэх ажлын хүрээнд олборлолтын гэрээт байгууллагуудын тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тус бүр 2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж зардлыг тусгуулан батлуулсан.

№	Төлөвлөгөөт ажил, ажлаас	Урьдчилсан тооцсон хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Төрөл	Шалтгаар
01	Байгаль орчны менежмент төлөвлөгөө болон Биедэлтийн тайлан боловсруулах	-	I, XI сард	Дураан	Төлөвлөгөөний хөдөлгөөн 80%-д оршжээ байх
02	Байгаль орчны чагцлалд хийгдэх ажил, ажлаас төлөвлөгөөний төлөвлөгөөний дэмжлэг үзүүлэх	-	Тухайн бүр	Ажил	Дэмжлэг үзүүлсэн байх
03	Төрийн захиргааны хуралд олон орон нутгаас зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд ЭТТ ХХ-ийг хамруулах	-	Жуулд	Ажил	Хамтран оролцсон байх
04	Замнаачтай газар ашиглах гэрээ байгуулах	-	-	Дураан	Гэрээ байгуулсан байх
05	Замнаачтай үс ашиглах гэрээ байгуулах	-	-	Дураан	Гэрээ байгуулсан байх
06	Акустай жиг хөндлүүдэг илтгэлээр гэрээ гүйцэтгэх ажиллагааг бүрэн хийж гүйцэтгэх	-	-	Дураан	Гэрээ байгуулсан байх
07	Хулгайн ан, байгаль орчны гэмт хэргийг бууруулах зорилгоор орон нутгийн Байгаль хамгаалалтын үйлдлийн байртай хамтран ажиллах зорилго дэмжлэг үзүүлэх, ягаж тусал төлөвлөгөөний төлөвлөгөөний төлөвлөгөө	1.0 сая ₮	-	Ажил	Дэмжлэг үзүүлсэн байх
08	Эмчилж хэрчилсэн ажиллах, хөндлөгч гэрээ байгуулах	-	-	Дураан	Гэрээ байгуулсан байх
09	Ногоолгийн бүсийн нэгдсэн ажил үйлдлийн тусгай хөндлөгч гэрээ байгуулах	2.0 сая ₮	III сард	Ажил/Дураан	Хамтран оролцсон байх
10	Байгаль орчны менежментийн 3 жил дараа "Төрийн захиргаа" өргөргүйг зохион байгуулж иргэд саналчилж үйлдлийн үйлдлийг	5.0 сая ₮	Тухайн бүр	Ажил	Хамтран ажиллах ажил хамтран оролцсон байх
11	Замнаачтай бүсийн 5 хөрөнгө ажлын байгуулж үйлдлийн үйлдлийг	-	Тухайн бүр	Ажил	Урьдчилсан ажил хамтран оролцсон байх

Зураг № 91. Гэрээт байгууллагуудын төлөвлөгөөнд хийгдэх ажлыг тусган батлуулсан байдал


Цогтцэций сум нь идэвхтэн байгаль хамгаалагчийг шинэчилж байгаа бөгөөд сумын байгаль хамгаалагчаас хэрхэн хамтран ажиллах талаар тодруулахад 10-р сарын 20-ны өдөр компанийн “Грийн центр”-ийн хурлын танхимд Цогтцэций сумын экологийн цагдаатай хамтран зохион байгуулсан “Хулгайн антай тэмцэх” сургалтын дараа уг ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

7.1.3 Амьтны камерын өгөгдлийг цуглуулан боловсруулж, дүн шинжилгээ хийх

Дүйцүүлэн хамгаалах талбайн Дугант, Шанхайн хэц орчимд хоёр байршилд амьтны камерыг байрлуулан 5 сарын хугацаанд байршуулан өгөгдлийг цуглуулсан. Амьтны камерын өгөгдөлд ихэвчлэн 5 хошуу мал ихээр бичигдсэн бөгөөд тас шувуу, цармын бүргэд, цөлийн чогчиго зэрэг жигүүртэн шувууд өртсөн байна. Амьтны камерт өртсөн зургаас дүгнэхэд дүйцүүлэн хамгаалах талбайн камер байрлуулсан цэгүүдийн ойр орчимд малчин айл өрх ихтэй учир зэрлэг амьтад болох хар сүүлт, цагаан зээр зэрэг амьтад айл өрхийн нөлөөнөөс дайжсан гэж дүгнэж байна.

Хүснэгт № 27. Амьтаны замер байршуулсан байршлын координат

№	Камерын байршил	Солбилцол
1	Дүйцүүлэн хамгаалах талбайн дугант хад	44° 0'55.47"N, 105°44'12.82"E
2	Дүйцүүлэн хамгаалах талбайн шанхийн хэц	44° 1'4.01"N, 105°42'44.54"E




Зураг № 92. Амьтны камер байрлуулсан байршлын зураг



Зураг № 93. Амьны камерт өртсөн амьтнуудын зураг

7.1.4 Зүүнбаян чиглэлийн Төмөр замын орчимд хар сүүлтийг хүзүүвчлэн тандан судалгаа гүйцэтгэх

Дүйцүүлэн хамгаалах талбайд хийгдэх Зүүнбаян чиглэлийн төмөр замын орчимд хар сүүлт гөрөөсийг хүзүүвчлэн тандан судалгааны ажил гүйцэтгэх ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр захиалгын хуудсыг 2025 оны 02-р сарын 27-ны өдөр батлуулан компанийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Компанид тогтоосон онц байдлаас шалтгаалан одоогоор тэндэр шалгаруулалт зарлагдаагүй байна. 2025 онд багтаан тендер шалгаруулалтыг зарлуулан ажлыг хийж гүйцэтгүүлэхээр ажиллаж байна.




Зураг № 94. Дүйцүүлэн хамгаалах талбайд хийгдэх ажлын захиалгын хуудас

7.2 Ургамлын олон янз байдлыг хамгаалах

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
7.2.1	Байгалийн ургамлыг таних, хамгаалах, зөв зохистой ашиглах талаар сургалт, дадлага зохион байгуулах	2 удаа	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах бүлгийн сурагчдад экологийн боловсрол олгох сургалт, дадлага зохион байгуулах ажлын хүрээнд салбарын захирлаар удирдамж батлуулан “Мөрөөдөл” сургуулийн ахлах бүлгийн 98 сурагчийг 2025 оны 09-р сарын 21-ны өдөр, “Т.Борын нэрэмжит сургууль”-ийн 65 сурагчдыг 10-р сарын 04-ны өдөр хүлээн авч зохион байгуулсан.	100%
7.2.2	Дүйцүүлэн хамгаалах талбайд тогтоосон бэлчээрийн хяналтын мониторинг хийх	12 цэгт	Дүйцүүлэн хамгаалах талбайн ургамлын мониторингийн байнгын 12 цэгт 2025 онд хийх мониторингийн ажлыг гэрээгээр нүүрс ачилтын үйл ажиллагаа явуулж буй “КЭРС” ХХК болон “МСДГ” ХХК-ны 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2025 оны 09-р сарын 01-ны өдөр хийц гүйцэтгэсэн. (Хавсралт №20. Хуудас 117-118)	100%
7.2.3	Говийн мод, сөөгний тарьц суулгац бэлтгэх талбайг арчилж хамгаалах	3.2 га	Дүйцүүлэн хамгаалах ажил гүйцэтгэж буй Шангай, Дунгант орчимд байрлах 99000 га талбайд 2019 оноос эхлэн говийн бүсийн мод, сөөгний тарьц бэлтгэх ажлын хүрээнд ойн зурвас, эх модны талбай байгуулах ажил хийгдэж эхэлсэн. Уг талбай нь 3.2 га хэмжээтэй бөгөөд 5000 орчим мод 90 гаруй хувийн ургалттай ургаж байна. Тайлант онд уг талбайн усалгаа арчилгааны ажлыг хамтран ажиллах санамж бичиг байгуулсан “Билигт малчин” хоршоо хариуцан усалгаа арчилгааг хийж гүйцэтгэж байна.	100%
7.2.4	Хөрсний шинж чанар, элэгдэл эвдрэл, физик болон хими шинж чанарыг тодорхойлох зорилгоор дээж авч, хөрсний бичиглэл хийх, зураг боловсруулах, доройтлын хүчин зүйлийг тодорхойлох	-	Дүйцүүлэн хамгаалах талбайд хийгдсэн хөрсний хээрийн судалгааг 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 10 дугаар сарын 08-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв. Хээрийн судалгааг хийхдээ хөрсний төлөөлөл болохуйц цэгт зүсэлт хийх, GPS-ийн хэмжилт, морфологи бичиглэл хийх, дээж авах зэрэг үйлдлийг гүйцэтгэхээс гадна тухайн талбайн хөрсний элэгдэл эвдрэл, бохирдолт, ялзмагт үеийн зузаан, намагжилт, давсжилт, өндөржилт, налуужилт, чулуужилт зэргийг тодорхойлсон.	100%

7.2.1 Байгалийн ургамлыг таних, хамгаалах, зөв зохистой ашиглах талаар сургалт, дадлага зохион байгуулах

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах бүлгийн сурагчдад экологийн боловсрол олгох сургалт, дадлага зохион байгуулах ажлын хүрээнд салбарын захирлаар удирдамж батлуулан “Мөрөөдөл” сургуулийн ахлах бүлгийн 98 сурагчийг 2025 оны 09-р сарын 21-ны өдөр, “Т.Борын нэрэмжит сургууль”-ийн 65 сурагчдыг 10-р сарын 04-ны өдөр хүлээн авч зохион байгуулсан.



Зураг № 95. Экологийн боловсрол олгох ажлын батлагдсан удирдамж

Тус ажлын хүрээнд нийтдээ Цогтцэций сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах бүлгийн 163 сурагч хамрагдсан байна.



Зураг № 96. Арга хэмжээнд оролцогчдын зураг

7.2.2 Дүйцүүлэн хамгаалах талбайд тогтоосон бэлчээрийн хяналтын мониторинг хийх

Дүйцүүлэн хамгаалах талбайн ургамлын мониторингийн байнгын 12 цэгт 2025 онд хийх мониторингийн ажлыг гэрээгээр нүүрс ачилтын үйл ажиллагаа явуулж буй “КЭРС” ХХК болон “МСДГ” ХХК-ны 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2025 оны 09-р сарын 01-ны өдөр хийц гүйцэтгэсэн. (Хавсралт №20. Хуудас 117-118)

Хүснэгт № 28. Ургамлын мониторингийн цэгийн байршил

№	Байршлын нэр	Өргөрөг	Уртраг	Өндөр
1	Дугант	105° 44' 49.67" E	44° 01' 04.59" N	1295
2	Сүүн толгой	105° 40' 39.24" E	44° 03' 42.91" N	1261
3	Наймдайн хөндий	105° 47' 50.68" E	44° 04' 25.07" N	1245
4	Сондуул	105° 52' 51.02" E	44° 04' 41.26" N	1219
5	Үнэгт	105° 48' 18.52" E	44° 01' 19.5" N	1326
6	Шар тээг	105° 54' 11.89" E	43° 59' 38.63" N	1313
7	Цооног	105° 54' 52.23" E	43° 55' 29.73" N	1344

8	Харганат	105° 46' 07.32" E	43° 53' 04.76" N	1377
9	Бүрхээс	105° 42' 57.7" E	43° 53' 24.23" N	1352
10	Цагаат Товогийн тал	105°37' 36.9" E	43° 52' 21.96" N	1350
11	Шороот ихэр	105° 43' 59.01" E	43° 55' 26.8" N	1353
12	Шангайн арын толгод	105° 39'33.84" E	44°01'38.28" N	1358

Трансектийн цэг тус бүрд 1х1м харьцаатай тор, солбицлыг тодорхойлох GPS, Фото аппарат, цагаан самбар, бичиглэлийн маягт, дээжийн уут болон бусад шаардагдах хэрэгслийг бэлтгэн авч явсан. Мониторинг хийхдээ цагаан самбар дээр цэгийн дугаар, он сар, солбицол бичиж цэг тус бүрд 5 н удаа хийж зонхилох ургамлын нэр, өндөр, хөгжлийн үе шат ургамлын нойтон ба хуурай жинг тодорхойлж дундаж ургацыг тодорхойлсон.



Зураг № 97. Ургамлын мониторингийн цэгийн байршлын зураг



Зураг № 98. Ургамлын мониторинг хийж буй байдал

7.2.3 Говийн мод, сөөгний тарьц суулгац бэлтгэх талбайг арчилж хамгаалах

Дүйцүүлэн хамгаалах ажил гүйцэтгэж буй Шангай, Дунгант орчимд байрлах 99000 га талбайд 2019 оноос эхлэн говийн бүсийн мод, сөөгний тарьц бэлтгэх ажлын хүрээнд ойн зурвас, эх модны талбай байгуулах ажил хийгдэж эхэлсэн. Уг талбай нь 3.2 га хэмжээтэй бөгөөд 5000 орчим мод 90 гаруй хувийн ургалттай ургаж байна. Тайлант онд уг талбайн усалгаа арчилгааны ажлыг хамтран ажиллах санамж бичиг байгуулсан “Билигт малчин” хоршоо хариуцан усалгаа арчилгааг хийж гүйцэтгэж байна.



Зураг № 99. Модны талбайд усалгаа хийж буй байдал



Зураг № 100. Модны талбайн усалгааны системийг засварлаж буй байдал

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Байгаль орчин, усны бодлогын хэлтсийн мэргэжилтнүүд шаардлагатай тохиолдолд уг талбайн засвар үйлчилгээг тухай бүрт гүйцэтгэн ажиллаж байна.



Зураг № 101. Модны талбайд засвар үйлчилгээ хийж буй байдал

7.2.4 Хөрсний шинж чанар, элэгдэл эвдрэл, физик болон хими шинж чанарыг тодорхойлох зорилгоор дээж авч, хөрсний бичиглэл хийх, зураг боловсруулах, доройтлын хүчин зүйлийг тодорхойлох

Дүйцүүлэн хамгаалах талбайд хийгдсэн хөрсний хээрийн судалгааг 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 10 дугаар сарын 08-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв. Хээрийн судалгааг хийхдээ хөрсний төлөөлөл болохуйц цэгт зүсэлт хийх, GPS-ийн хэмжилт, морфологи бичиглэл хийх, дээж авах зэрэг үйлдлийг гүйцэтгэхээс гадна тухайн талбайн хөрсний элэгдэл эвдрэл, бохирдолт, ялзмагт үеийн зузаан, намагжилт, давсжилт, өндөржилт, налуужилт, чулуужилт зэргийг тодорхойлсон. (Хавсралт №21. Хуудас 119)

Хүснэгт № 29. Дүйцүүлэн хамгаалах талбайн хөрсний үндсэн хэв шинж, эзлэх хувь


№	Хөрсний төрөл	Талбай /га/	Нийт талбайд эзлэх хувь
1.	Нугын хужир / Чийгт хэлбэрийн хужир хөрс	1491	1.5%
2.	Цөлөрхөг хээрийн бор хөрс	67320	61%
3.	Уулын цөлөрхөг хээрийн бор хөрс	33644	33%
4.	Цөлөрхөг хээрийн нугат далд глейрхэг бор хөрс	4768	4.6%
Нийт		102572	100%

Судалгааны талбайд хуурай ба говийн хөрсний хэв шинж зонхилж байна. Хөрсний үржил шимийн дундаж түвшин бага–дунд, чийгийн горим сул, харин нам дор хэсэгт чийг хадгалалт илүүтэй байна. Хөрсний хамгаалалт шаардлагатай хэсгүүдэд уулын налуу, элэгдэлд өртөмтгий бор хөрстэй бүсүүд хамаарч байна. Нөхөн сэргээлтийн чадавх сайтай хэсгээр нугархаг, чийг хадгалалттай (нугын хужир, глейрхэг бор) бүсүүд ажиглагдсан байна.



Зураг № 102. Хөрсний хээрийн судалгаа хийж буй байдал

Дүйцүүлэн хамгаалах талбайн 102572 орчим га талбайд хөрсний зүсэлт, зураглал хийж, 4 үндсэн хэв шинж тодорхойлогдсон бөгөөд тэдгээрийн дийлэнх нь цөлөрхөг хээрийн бор хөрс байна. Эдгээр хөрсний үржил шим бага, чийгийн ууршилт ихтэй тул нөхөн сэргээлт, ургамалжуулалт хийхдээ хуурайд тэсвэртэй ургамлын зүйлийг ашиглах нь зүйтэй гэж үзэв. Нугархаг, ус чийг хадгалах нөхцөлтэй хэсэгт (нугын хужир, глейрхэг бор хөрс) нөхөн сэргээлтийн суурь болгон ашиглах бүрэн боломжтой нь харагдаж байна.



Зураг № 103. Хөрсний хэв шинжийн зураг

Нугын хужир буюу чийгт хэлбэрийн хужир хөрс нь Цогтцэций сумын нам дор, ус чийг тогтдог нугархаг хотгор хэсэгт тархсан, давсжилт илэрсэн боловч ургамлын бүрхэц харьцангуй сайн, нугархаг шинж давамгай ажиглагдаж байна. Энэ хөрс нь ус чийгийн горим тогтворгүй, шүлтлэг шинжтэй тул тариалангийн зориулалтад тохиромжгүй боловч бэлчээрийн болон нөхөн сэргээлтийн зориулалтаар ашиглахад боломжтой гэж үнэлэгдсэн.

7.3 Уст цэгийн хүрэлцээ хангамжийг сайжруулах

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
7.3.1	Ус хангамжийг сайжруулах зорилгоор булгийн эхийг хашиж хамгаалах	1 ш	“Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Сийрст багийн нутаг дэвсгэрт орших “Хээрийн булаг”-н (Зүүн) булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд зохион байгуулж хэрэгжилтийг ханган ажилласан.	100%
7.3.2	Өмнө жилийн дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн зэрлэг ан амьтны худгийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих	2 ш	Тайлант онд өмнөх жилүүдэд хийгдсэн зэрлэг ан амьтны худгийн хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд 2025 оны 07-р сарын 27 өдөр болон 10-р сарын 05, 11-ний өдрүүдэд хяналтыг хийж гүйцэтгэсэн.	100%

7.3.1 Ус хангамжийг сайжруулах зорилгоор булгийн эхийг хашиж хамгаалах

Булгийг хаших ажилд 40мм-ийн диаметр бүхий цайран трубаг гагнаж хийсэн бөгөөд, хашааны шон тус бүрийг цементээр цутгаж хөдөлгөөнгүй байдлаар бэхэлсэн. Хашааны нийт хэмжээ нь 24м*9м талбайг хамрав. Хашааг барьж дууссаны дараа төмрийн ногоон өнгийн будгаар будаж хүлээлгэн өгөхөд бэлтгэж Цогтцэций сумын Сийрст багийн засаг дарга болон, байгаль хамгаалагчийг байлцуулан хийгдсэн ажлыг танилцуулсан.

Хүснэгт № 30. Булаг хаших ажилд зарцуулсан материалын тооцоо

д/д	Материалын нэр	Тоо хэмжээ	Техникийн тодорхойлолт
1	Труба /цайран/	40ш	40мм-ийн 3м урттай
2	Труба /цайран/	40ш	20мм-ийн 3м урттай
3	Труба /цайран/	20ш	40мм-ийн 2м урттай



Зураг № 104. Хээрийн булгийг хашиж эхлэхийн өмнөх байдал болон хашиж буй байдал



Зураг № 105. Булгийн эхийг хашиж бууй байдал болон хашиж дууссаны дараах байдал

“Хээрийн булгийн” эхийг хашиж хамгаалж тохижуулсан ажлыг бүрэн шаардлага хангасан гэж үзсэн тул 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр орон нутагт актаар хүлээлгэн өгсөн.

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГЦЭЦИЙ СУМЫН СИЙРСТ БАГИЙН НУТАГ
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ХЭЭРИЙН БУЛАГ”-Н (ЗҮҮН) ЭХИЙГ ШИНЭЭР ХАШИЖ,
ХАМГААЛАН ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН АКТ**

Өмнөговь, Цогтцэций сум 2025 оны 09 дүгээр сарын 15

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2025 оны Байгаль орчны менежментийн талаарх тусгай зөвшөөрлийн гэрээний дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Сийрст багийн нутаг дэвсгэрт орших “Хээрийн булаг”-н (зүүн) булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Булгийн эхийг хашсан байдал:

Булгийг хаших ажилд 40мм-ийн диаметр бүхий цайран трубаг талнах хийсэн бөгөөд, хашаны шон тус бүрийг цементээр цутгаж нөхдөгөөр хийж байсан. Хашаны нийт хэмжээ нь 24х7м талбайг хамрав. Хашааг барьж дууссаны дараа төмрийн ногоон өнгийн будааг будаж хүлээлгэн өгөхөд бэлтгэв.

“Хээрийн булгийн” эхийг хашиж хамгаалсан тохиолотын ажлыг бүрэн шаардлага хангасан гэж дүгнэн хүлээн авав.

Фото зураг хавсаргав.

АКТ ТОГТООСОН:

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:

Байгаль орчны ахлах инженер *[Signature]* /Д.Бурхансүрэг/

Байгаль орчны инженер *[Signature]* /Б.Оюун/

Байгаль орчны инженер *[Signature]* /Т.Нашаг/

Байгаль орчны инженер *[Signature]* /Н.Бямбадорж/

ХҮЛЭЭН АВСАН:

Сийрст багийн засаг дарга *[Signature]* /М.Энхтүвшин/

Цогтцэций сумын орон нутаг хариуцсан Байгаль хамгаалагч *[Signature]* /М.Энхтүвшин/

Зураг № 106. Булаг хашсан ажлыг хүлээлгэн өгсөн акт

7.3.2 Өмнө жилийн дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн зэрлэг ан амьтны худгийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих

Тайлант онд өмнөх жилүүдэд хийгдсэн зэрлэг ан амьтны худгийн хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд 2025 оны 07-р сарын 27 өдөр болон 10-р сарын 05, 11-ний өдрүүдэд хяналтыг хийж гүйцэтгэсэн.



Зураг № 107. 10-р сарын 05-ны өдөр хяналт хийж гүйцэтгэсэн байдал



Зураг № 108. Зэрлэг ан амьтанд зориулсан худгийн бэлэн байдлын шалгаж буй байдал

7.4 Дүйцүүлэн хамгаалах талбайг нэмэгдүүлэх


№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
7.4.1	НБҮ, ЗУХ-н төслүүдийн цар хүрээнд дүйцүүлэн хамгаалах талбайн хэмжээг орон нутагтай хамтран ажиллаж тогтоох	-	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс уг талбайн байршлыг сонгохдоо Цанхийн уурхайн дүйцүүлэн хамгаалах ажил гүйцэтгэж буй байршлын хажууд залгасан байдлаар хийхээр төлөвлөсөн бөгөөд энэ байршлыг баталгаажуулахаар Өмнөговь аймгийн Байгаль орчны газарт 2025 оны 10-р сарын 12-ны өдрийн 3/280 дугаартай албан бичгээр хандаад байна.	100%

7.4.1 НБҮ, ЗУХ-н төслүүдийн цар хүрээнд дүйцүүлэн хамгаалах талбайн хэмжээг орон нутагтай хамтран ажиллаж тогтоох

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь “Нүүрс баяжуулах үйлдвэр”, “Загийн усны хоолой” төслийн үйл ажиллагааг 2022 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2023 онд тус төслүүдийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг “Хатандалай” ХХК-

иар хийлгэсэн бөгөөд тус үнэлгээний хүрээнд зайлсхийх боломжгүй сөрөг нөлөөллийн хэмжээг тогтоож дүйцүүлэн хамгаалал хийх талбайн хэмжээг тогтоолгосон байдаг.

Уг үнэлгээгээр “Загийн усны хоолой” төслийн дүйцүүлэн хамгаалал хийх шаардлагатай талбай нь 906 га, “Нүүрс баяжуулах үйлдвэр” төслийн дүйцүүлэн хамгаалал хийх шаардлагатай талбай нь 87 га байхаар үнэлэгдсэн байдаг.



Зураг № 109. Дүйцүүлэн хамгаалах талбайн хэмжээг БОННУ дээр тооцсон байдал

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс уг талбайн байршлыг сонгохдоо Цанхийн уурхайн дүйцүүлэн хамгаалах ажил гүйцэтгэж буй байршлын хажууд залгасан байдлаар хийхээр төлөвлөсөн бөгөөд энэ байршлыг баталгаажуулахаар Өмнөговь аймгийн Байгаль орчны газарт 2025 оны 10-р сарын 12-ны өдрийн 3/280 дугаартай албан бичгээр хандаад байна.



Зураг № 110. Дүйцүүлэн хамгаалах газрын байршил тогтоохоор илгээсэн албан бичиг

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
8.1	Цагаан овоо багийн иргэдтэй нөхөн олговрын гэрээ байгуулан нөхөн олговор олгож газар чөлөөлөх	16 иргэн	2025 онд 2 иргэнтэй нөхөн олговор олгох гэрээ, 14 иргэнтэй нөхөн олговрын гэрээ дүгнэсэн актыг байгуулж 16 иргэний газар чөлөөлөх ажлыг зохион байгуулж 175,195,496₮-ийн нөхөн олговор олгосон.	100%

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/501 дүгээр тушаалаар “Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх асуудлын хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн өөрийн тусгай зөвшөөрлийн талбай болон уурхайн нөлөөллийн бүсийн айл өрхүүдэд нөхөн олговор олгох ажлыг зохион байгуулах” ажлын хэсэг байгуулагдсан.

Хүснэгт № 31. 2025 онд нүүлгэн шилжүүлэх ажил гүйцэтгэсэн байдал

№	Нөхөн олговор	Тоо хэмжээ	2025 онд хийгдсэн
1	Нөхөн олговор авах иргэн	267	
2	Нөхөн олговор олгох гэрээ байгуулсан	253	2
2.1	Гэрээ дүгнэсэн	249	14
2.2	Гэрээ дүгнээгүй	4	
3	Нөхөн олговор олгох гэрээ байгуулаагүй	14	

Ашигт малтмалын тухай хуулийн 42.1 дэх заалтын дагуу 2023.04.17-ны өдрийн Өмнөговь аймгийн засаг даргатай байгуулсан №ЭТТ-2023/190 дугаартай “Хамтын ажиллагааны гэрээ”, Эрдэнэс Тавантолгой ХК-ны “Нийгмийн хариуцлагын бодлогын баримт бичиг”-г үндэслэн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийг нүүлгэн шилжүүлэх, нөлөөллийн бүсийн иргэдэд нөхөн олговор олгох ажлыг зохион байгуулан ажилласан.

2025 онд 2 иргэнтэй нөхөн олговор олгох гэрээ, 14 иргэнтэй нөхөн олговрын гэрээ дүгнэсэн актыг байгуулж 16 иргэний газар чөлөөлөх ажлыг зохион байгуулж 175,195,496₮-ийн нөхөн олговор олгосон.

Нөхөн олговрын гэрээ байгуулаагүй байгаа 14 иргэн нь хөрөнгийн үнэлгээ зөвшөөрөөгүй ба “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нөхөн олговор олгох санхүүжилтийн асуудлаас шалтгаалаагүй болно. Дээрх иргэдийн хөрөнгийн үнэлгээг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй аж ахуй нэгж холбогдох хууль, журмын дагуу хийсэн.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
9.1	Соёлын өвийг хамгаалах талаар уурхайн ажилчдад таниулах, энэ чиглэлээр хийгдсэн ажлуудыг танилцуулах.	-	2018-2023 оны хооронд “Археологи, Угсаатан зүйн, Палеонтологийн Монгол улсын “Шинжлэх ухааны Академи Археологийн хүрээлэн” болон “Палеонтологийн Хүрээлэн”-ийн судалгааны үр дүнд гарсан олдворуудын мэдээллийг нэгтгэн уурхайн болон гэрээт компаниудын баруун зүүн уурхайн оператор, инженер техникийн нийт 190 ажилтанд танилцуулсан.	100%
9.2	Үндэсний шагайн харвааны салбар зөвлөлийн тэмцээн зохион байгуулах	3-р уиралд	Соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд “ЭТТ” ХК-ийн ЗГОБЭ төлөөлөгчийн багийн ахлагчийн 2025.07.29 А/297 тоот тушаалаар 2025.08.01-2025.08.03-ний өдрүүдэд Дундговь аймгийн Дэрэн сумын нутаг Наранхөгцтийд зохион байгуулагдсан.	100%
9.3	Цогтцэций сумын 9 гайхамшигт орсон Цавчирын задгайг тохижуулах	2, 3-р удиралд	Цавчирын задгай орчмын тохижуулах ажлыг дуусгаж гэрээт компани хүнтэй, сумын БО байцаагч, байгаль хамгаалагч нартай хамтран явж танилцуулсан. Цавчир задгай тохижуулах ажлыг суманд хүлээлгэн өгч акт үйлдсэн.	100%

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
9.4	Археологийн авран хамгаалах малтлага хийлгэх	30 дурсгал	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий MV-011953 дугаартай “Салбарын Цанхийн зүүн уурхай” нэртэй 12860 га хэмжээтэй, MV-011954 дугаартай “Бор тээг” нэртэй 8941 га хэмжээтэй болон MV-011955 дугаартай “Шар тээг” 23803 га хэмжээтэй ашиглалтын гурван талбайд тус тус археологийн авран хамгаалах малтлага судалгааны ажлыг 2025 оны 09-р сарын 07-ны өдрөөс 10-р сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.	100%

9.1 Соёлын өвийг хамгаалах талаар уурхайн ажилчдад таниулах, энэ чиглэлээр хийгдсэн ажлуудыг танилцуулах

Соёлын өвийг хамгаалах талаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбай дахь 2018-2023 оны хооронд “Археологи, Угсаатан зүйн, Палеонтологийн Монгол улсын “Шинжлэх ухааны Академи Археологийн хүрээлэн” болон “Палеонтологийн Хүрээлэн”-ийн судалгааны үр дүнд гарсан олдворуудын мэдээллийг нэгтгэн уурхайн болон гэрээт компаниудын баруун зүүн уурхайн оператор, инженер техникийн нийт 190 ажилтанд танилцуулсан.



Зураг № 111. Мэдээлэл түгээж сургалт орж буй байдал

ХАБЗАН БОЛОН ХҮНД МАШИН МЕХАНИЗМ АШИГЛАХ, ЖОЛОО БАРИХ ЭРХИЙН СУРГАЛТ ЭХЭЙСН БАЙГУУЛАХ ЖУРМ						
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл аюулын болон хүнд машин механизм ашиглах, жолоо барих эрхийн сургалт зохион байгуулах журмын дөрөвдүгээр хэсэрт						
Сургалтын бүртгэлийн хуудас						
Огноо: 2025.06.22, 23	Ээлж: 65					
Эхлэх цаг: 06:30	Дуусах цаг: 07:00					
Тайлбар: Шүүр өвчин өвчин хамгаалах	1900					
Сургалтын бүртгэлийн хуудас						
№	Овог	Нэр	Регистр дугаар	Албан тушаал	Компани	Гарын үсэг
1	Вилансара	Ганзориг	2024526	оператор	ЭТТ	8/10
2	Норболор	Содномдор	2024422	оператор	ЭТТ	8/00
3	Сонинзор	Норболор	2024551	-	ЭТТ	8/00
4	Сонинзор	Хийдсүр	2024591	-	ЭТТ	8/00
5	Сонинзор	Хийдсүр	2024591	-	ЭТТ	8/00
6	Шар	Мунд	2024254	-	ЭТТ	8/00
7	Шар	Сүхбат	2024000	-	ЭТТ	8/00
8	Шар	Сүхбат	2024834	-	ЭТТ	8/00
9	Шар	Сүхбат	2024028	-	ЭТТ	8/00
10	Шар	Сүхбат	2024627	-	ЭТТ	8/00
11	Шар	Сүхбат	2024552	-	ЭТТ	8/00
12	Шар	Сүхбат	2024532	-	ЭТТ	8/00
13	Шар	Сүхбат	2024281	-	ЭТТ	8/00
14	Шар	Сүхбат	2024281	-	ЭТТ	8/00
15						
16						

Зураг № 112. Сургалтанд хамрагдсан ажилтнуудын бүртгэлийн хуудас

9.2 Үндэсний шагайн харвааны салбар зөвлөлийн тэмцээн зохион байгуулах

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан “Соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх” ажлын хүрээнд хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад бүртгэсэн шагай харвааны төрлийг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.

Зураг № 113. Тэмцээн зохион байгуулах тушаал болон тушаалын хэрэгжилтийн тайлан

“Алтан зурхай” салбар зөвлөлийн тэргүүн Монгол улсын үлэмж дархан мэргэн, спортын мастер Т.Ганбүргэдийн нэрэмжит Наранхөгцтийн тойром харваа тэмцээнийг Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар, Дундговь аймгийн Дэрэн сумын засаг даргын тамгын газар, Монголын шалгайн харвааны холбоотой хамтран 2025 оны 08 дугаар сарын 1,2,3-ний өдрүүдэд Ахмад, насанд хүрэгчид хүүхэд, ахмадын бууны төрлөөр зохион байгуулагдсан. Ерөнхий ивээн тэтгэгч “Эрдэнэс Тавантолгой ХК оролцож зохион байгуулалтыг хийсэн.



Зураг № 114. Тэмцээний нээлт болон шагнал гардуулж буй байдал

9.3 Цогтцэций сумын 9 гайхамшигт орсон Цавчирын задгайг тохижуулах

“Эрдэнэс Тавантолгой” ХК болон Үндэсний Манлайлал Түншлэлийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Сийрст багийн нутаг дэвсгэрт орших “Цавчирын задгай”-н орчмыг орон нутгийн аялал жуулчлалын бүс болгож, аюулгүй тав тухтай орчинг бүрдүүлэх зорилгоор тохижуулах ажлыг 2025 оны 09 сарын 24-ний өдөр эхлүүлж сүүдрэвч барих, мэдээллийн самбарыг хийж гүйцэтгэсэн.



Зураг № 115. Цавчирийн задгайг тохижуулж буй байдал

Цавчирын задгай орчимд төмөр материалаар хийгдсэн 3X4 метр харьцаатай 3 метр өндөртэй сүүдрэвч ширээ, сандлын хамт 1 ширхгийг байрлуулж газартай бат бөх байдлаар бетоноор цутгаж хийсэн. Мөн төмөр материалаар хийгдсэн 2,5 метр өндөртэй төмөр трубагаар хөл хийж суурилуулсан 1 ширхэг анхааруулах мэдээллийн салбарыг гагнаж хийсэн бөгөөд төмөр сүүдрэвч, самбарыг бүрэн будсан.



Зураг № 116. Цавчирын задгайн тохижилтийн ажлыг сумын байгаль хамгаалагч нарт үзүүлж буй байдал

Цавчирын задгай орчмын тохижилтоор эхлүүлсэн ажлыг ЭТТ-ийн төлөөлөл, гүйцэтгэсэн компани төлөөлөл, сумын байгаль хамгаалагч, байцаагч нар байлцан газар дээр нь үзэж танилцсан. Цаашид нэмэлтээр тохижилтын ажлыг сайжруулах зорилгоор сум болон малчдын саналыг үндэслэн 2026 оны төлөвлөгөөнд тусгаж нэмэлтээр хийхээр харилцан тохиролцож актыг баталгаажуулсан.




Зураг № 117. Тохижилтийн ажлыг хүлээлгэн өгсөн акт

9.4 Археологийн авран хамгаалах малтлага хийлгэх

2025 оны 06-р сарын 25-ны өдөр “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас зарлагдсан ЭТТХК/20250103372 дугаартай тендер шалгаруулалтад МУИС-ийн Нүүдэлчдийн археологийн хүрээлэн шалгарсан билээ. Үүний дараа 2025 оны 09-р сарын 05-ны өдөр МУИС-ийн Нүүдэлчдийн археологийн хүрээлэн болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хооронд ЭТТ-2025/537 дугаартай “Археологийн авран хамгаалах малтлага, судалгаа” хийх ажил гүйцэтгэх гэрээг байгуулснаар археологийн авран хамгаалах малтлага судалгааны ажил хийгдэх нөхцөл бүрдсэн.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрөлтэй MV-011953, MV-011954, MV-011955 дугаар бүхий ашигт малтмалын ашиглалтын гурван талбайд 2021 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судлаачдын хийж гүйцэтгэсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгааны үр дүнд илэрч бүртгэгдсэн нийт 30 дурсгалд малтлага судалгааг хийж гүйцэтгэлээ. Мөн тэдгээрээс гадна MV-011954 дугаартай “Бор тээг” нэртэй

талбайгаас шинээр 6 дурсгалыг илрүүлэн малтан судалсан ба нийт 36 дурсгалд археологийн авран хамгаалах малтлага судалгааг хийж гүйцэтгээд байна.



Зураг № 118. Археологийн авран хамгаалах малтлага судалгаа хийх ажлын гэрээ



Зураг № 119. Археологийн малтлага гүйцэтгэж буй байдал

Малтан судлагдаад буй хүрэл зэвсгийн үеэс дундад зууны үеийг хүртэлх хугацаанд хамаарах 36 дурсгалаас шинжлэх ухааны үнэ цэнэтэй мэдээлэл агуулсан, эрдэм шинжилгээний ач холбогдол бүхий 100 орчим олдвор эд өлгийн зүйлс илэрч олддоод байна. Тэдгээрээс онцлох олдворуудыг дурдвал, ShT-01 дугаартай булшны чулуун дарааснаас илэрсэн хүрлийн үеийн дөрвөлжин булшны соёлыг үлдээгчидтэй хамаарах хүн чулуу; BT-02 дугаартай булшнаас илэрсэн үйсэн богтаг малгай, төмөр хайч, хүрэл эдлэл, төмөр арал; BT-06 дугаартай булшнаас илэрсэн үйсэн богтаг малгай, арьсан эдлэл, хүрэл чимэглэлүүд, хүрэл ээмэг, зоос, явуу, ээрүүлийн дунгуй; BT-07 дугаартай булшнаас илэрсэн хүрэл чимэглэл; BT-08 дугаартай булшнаас илэрсэн хүрэл толь, төмөр дэгээ; BT-09 дугаартай булшнаас илэрсэн үйсэн богтаг малгай, төмөр хайч, ээрүүлийн дунгуй, чулуун сувснууд; BT-12 дугаартай булшнаас илэрсэн төмөр хутга; BT-18 дугаартай булшнаас илэрсэн төмөр хонх; BT-19 дугаартай булшнаас илэрсэн чулуун эдлэл; BT-25 (шинээр бүртгэгдсэн) дугаартай булшнаас илэрсэн ясан эдлэл, төмөр эдлэлүүд, хүрэл чимэглэлүүд, сумны зэв, төмөр дөрөө; BT-26 (шинээр бүртгэгдсэн) дугаартай булшнаас илэрсэн үйсэн богтаг малгай, үйсэн саадаг, төмөр дөрөө, төмөр арал, хүрэл чимэглэлүүд, төмөр эдлэлүүд зэрэг байна.


10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

10.1 Нүүрс устөрөгч, химийн бодис асгаргах

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
10.1.1	ХАЛМ болон асгаралтын иж бүрдлийг шаардлагатай ажлын байранд байршуулах	10-аас доошгүй	ХАЛМ болон асгаралтын иж бүрдлийг шаардлагатай ажлын байранд байршуулсан. Асгаралтын иж бүрдлийг “БХЭБЭЭ” ХХК-тай гэрээ байгуулан асгаралтын иж бүрдэлд шаардлагатай нөөц материалын татан авалт хийгдсэн.	100%
10.1.2	Тусгай бэлдсэн талбайд бохирдсон хөрсийг байршуулах	Тодорхойлох боломжгүй	“Эрдэнэс Тавантолгой” ХК болон гэрээт компаниуд тусгайлан бэлтгэсэн “Бохирдсон хөрс саармагжуулах талбай”-д бохирдсон хөрсийг тухай бүрт байршуулан ажилладаг.	100%
10.1.3	Бохирдсон хөрс саармагжуулах талбайг стандартын дагуу шинээр байгуулах	1 талбай	“Эрдэнэс Тавантолгой” ХК нь “Өршөөлтийн ариун” ХХК-тай “Бохирдсон хөрс саармагжуулах талбай байгуулах материал биелүүлэх, гэрээ”-г байгуулж ЦБУ-н 1-р овоолго дээр бохирдсон хөрс саармагжуулах талбайг стандартын дагуу шинээр байгуулсан.	100%
10.1.4	Асгаралтыг бүртгэлжүүлж мэдээллийн сан үүсгэх	-	2022 оны 01-р сараас эхлэн дундын шэйр файл үүсгэж асгаралтын тохиолдол бүрийг бүртгэлжүүлж мэдээллийн сан үүсгэсэн.	100%
10.1.5	Асгаралтын журмыг шинэчлэн сайжруулах, батлуулах	1	“Асгаралтын журам”-д шаардлагатай өөрчлөлтийг оруулан шинэчлэн Салбарын захирлын 2025 оны 10-р сарын 26-ны өдрийн А/61 дугаартай тушаалаар шинэчлэн батлагдсан.	100%

10.1.1 ХАЛМ болон асгаралтын иж бүрдлийг шаардлагатай ажлын байранд байршуулах

Асгаралтыг иж бүрдэл цэнэглэх нөөц материалыг 2025 оны 04 дүгээр сарын 25-нд “БХЭБЭЭ” ХХК-тай ЭТТ-2025/261 дугаар бүхий “Асгаралтын иж бүрдэл цэнэглэх нөөц материал нийлүүлэх гэрээ”-г байгуулж бараа материалыг хүлээн авсан.



Зураг № 120. Асгаралтын иж бүрдэл цэнэглэх нөөц материал нийлүүлэх гэрээ

Уг гэрээний дагуу нийлүүлэгч компаниас 5 төрлийн нийт 3290 ширхэг тос шингээгч арчих материал, хязгаарлагч хөвөө, нитрилэн бээлий, зааварчилгааны хуудас, асгаралтын иж бүрдлийн наалт зэрэг бүтээгдэхүүнийг хүлээн авсан.

Зураг № 121. Асгаралтын иж бүрдэл цэнэглэхээр авсан материалын жагсаалт

№	Бүтээгдэхүүний нэр	Тоо хэмжээ	Техникийн шаардлага	Зураг
1	Тос шингээх арчих материал	2500 ш	50x40 см-ээс багагүй хэмжээтэй, 0.5 литрээс багагүй хэмжээний шингэн шингээх зориулалттай	
2	Хязгаарлагч хөвөө	650 ш	120 см урт, 8 см өргөнтэй, 4.5 литрийн шингэнийг шингээх зориулалттай	
3	Нитрилэн бээлий	100 ш	Аливаа шингэн, тос масло нэвтрэхгүй, нитрил материалтай, цэвэрлэгээний бодист тэсвэртэй	
4	Зааварчилгааны хуудас	20 ш	Асгаралтын иж бүрдлийг ашиглах зааварчилгаа бүхий 20x30 см хэмжээтэй хуудас	
5	Агаралтын иж бүрдлийн наалт	20 ш	240 литрийн багтаамжтай саван дээр наах зориулалттай наалт	

Асгаралтыг хязгаарлах, удирдах зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК болон гэрээт компаниуд асгаралтын иж бүрдэл болон шингээгч материалуудын захиалга, худалдан авалтыг хийж шаардлагатай газруудад буюу засварын шоп, шатахуун түгээх станцын талбайд бэлэн байдалд байлгах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Уурхайн хэмжээнд асгаралт үүсэх үеийн бэлэн байдлыг хангах үүднээс хүнд болон хөнгөн тэрэгний засварын шоп-2ш, нүүрс ачилт логистик төв-2ш, борлуулалтын хэсэгт-1ш, Загийн усны насосны станц, Нүүрс баяжуулах үйлдвэр-12ш нийт 17 байршилд асгаралтын иж бүрдлийг байршуулан шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.



Зураг № 122. Асгаралтын иж бүрдлийг шаардлагатай байршлуудад байршуулсан байдал

Химийн хортой, аюултай нүүрс-устөрөгчийн бодис материал ашиглагдах талбайд химийн бодисийн хор аюулын лавлах мэдээлэл буюу ХАЛМ-г бүрэн гүйцэт бүрдүүлж өөрийн компанийн ХАЛМ-ийн загварт орчуулан /ХАЛМ/ шаардлагатай газруудад байрлуулсан.



Зураг № 123. ХАЛМ-ийг байрлуулсан байдал

10.1.2 Тусгай бэлдсэн талбайд бохирдсон хөрсийг байршуулах

Салбарын захирлын баталсан “Асгаралтын журам”-ын дагуу асгаралт болсон даруйд тухайн асгаралт анх илрүүлсэн ажилтан өөрийн удирдах ажилтан эсвэл байгаль орчны мэргэжилнүүдэд мэдээлж байна. Үүний дагуу гэрээт компаниудын байгаль орчны мэргэжилтэн талбай дээр үзлэг хийж, урьдчилсан мэдэгдлийг холбогдох хэлтэс, нэгжүүдэд хүргүүлэн ажилладаг. Асгаралтын хэмжээ, цар хүрээг тогтоож, хариу арга хэмжээг авч тайлан боловсруулж байна. Мөн гэрээт компаниудад бохирдсон хөрс саармагжуулах талбай байгуулах шаардлагыг тавьж геомембранаар дэвсэлт хийсэн талбайд тос маслоор бохирдсон хөрсийг хуримтлуулж байна. Нийт асгаралтын тохиолдлыг судалж үзэхэд техник ажиллаж байх үед гидрийн шланг задарсан, дамжуулах хоолой задарсан, жийргэвч сэтэрсэн, радиатор цоорсон гэх мэт шалтгааны улмаас асгаралт үүссэн байна.




Зураг № 124. Асгаралтаар бохирдсон хөрсийг цуглуулан авч буй байдал



Зураг № 125. Бохирдсон хөрсийг цуглуулан ачиж бохирдсон хөрсний талбайд буулгаж буй байдал

10.1.3 Бохирдсон хөрс саармагжуулах талбайг стандартын дагуу шинээр байгуулах

“Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Өршөөлтийн Ариун” ХХК-ийн 2025 оны 01 дүгээр сарын 09-ны өдөр байгуулсан ЭТТ-2025/13 дугаартай “Бохирдсон хөрс саармагжуулах талбай байгуулах материал биелүүлэх, гэрээ”-ний дагуу 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 15-н хооронд Өмнөговь аймгийн Цогтцэций сум дахь Цанхийн баруун уурхайн хөрсний 1-р овоолго дээр Бохирдсон хөрс саармагжуулах талбай байгуулах материал нийлүүлж, суурилуулж угсрах ажлыг 6500 м² талбайд 1,5м зузаантай HDPE геомембран материал дэвсэж, хайлцын нөхөөсний гагнаасаар гагнах ажлыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.



Зураг № 126. Бохирдсон хөрс саармагжуулах талбай байгуулах гэрээ, газрын байршил



Зураг № 127. Бохирдсон хөрс саармагжуулах талбай байгуулах үеийн ажлын явц

10.1.4 Асгаралтыг бүртгэлжүүлж мэдээллийн санд бүртгэх

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь уурхайн олборлолтын үйл ажиллагааны дийлэнхийг гэрээт байгууллагуудаар хийж гүйцэтгүүлдэг бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаанд тогтмол хяналт шалгалт хийж ажилладаг. 2025 оны эхний 10 сарын байдлаар нийт 80 асгаралтын тохиолдол бүртгэгдсэн байна. Гэрээт компани тус бүр дээр гарсан асгаралтын бүртгэлийг сайжруулах зорилгоор 2022 оны 01-р сараас эхлэн дундын шэйр файл үүсгэж асгаралтын тохиолдол бүрийг бүртгэлжүүлэх ажил хийгдэж байна. Ингэснээр гэрээт компаниудын байгаль орчны асуудал хариуцсан ажилтнууд онлайнаар бүртгэлийг нэгэн зэрэг хөтлөх боломжийг бүрдүүлсэн.

№	Өдөр	Цагийн суртал	Асгаралтын үйлдлийн төрөл	
1	14.02.2025	12:00	Т.Эн туршилт	Х.Арсгалт
2	17.02.2025	12:00	Т.Эн туршилт	Х.Арсгалт
3	18.02.2025	12:00	Т.Эн туршилт	Х.Арсгалт
4	19.02.2025	12:00	Т.Эн туршилт	Х.Арсгалт
5	19.02.2025	12:00	Т.Эн туршилт	Х.Арсгалт
6	20.02.2025	12:00	Т.Эн туршилт	Х.Арсгалт
7	12.02.2025	12:00	Т.Эн туршилт	Х.Арсгалт
8	12.02.2025	12:00	Т.Эн туршилт	Х.Арсгалт
9	17.02.2025	12:00	Т.Эн туршилт	Х.Арсгалт
10	17.02.2025	12:00	Т.Эн туршилт	Х.Арсгалт
11	23.02.2025	12:00	Т.Эн туршилт	Х.Арсгалт
12	24.02.2025	12:00	Т.Эн туршилт	Х.Арсгалт
13	24.02.2025	12:00	Т.Эн туршилт	Х.Арсгалт
14	27.02.2025	12:00	Т.Эн туршилт	Х.Арсгалт
15	24.02.2025	12:00	Т.Эн туршилт	Х.Арсгалт
16	24.02.2025	12:00	Т.Эн туршилт	Х.Арсгалт
17	24.02.2025	12:00	Т.Эн туршилт	Х.Арсгалт
18	24.02.2025	12:00	Т.Эн туршилт	Х.Арсгалт

Зураг № 128. Асгаралтын бүртгэлийг цахимжуулан GoogleDrive-т холбосон байдал

2025 оны эхний 10 сарын дараах байдлаар Цанхийн уурхайд нийт 84 удаагийн асгаралт бүртгэгдэж, мэдээллийг санд материалыг оруулсан байна.

10.1.5 “Асгаралтын журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулах

ЭТТ ХК-ийн хэлтэс нэгжүүдээс санал авч дотоод хяналтын шалгалтын зөвлөмжийн дагуу “Асгаралтын журам”-г шинэчлэн сайжруулж 2025 оны 10 дугаар сарын 26-нд Салбарын захиралаар батлуулсан. Журмын 1.4, 7.2 дугаар заалт нэмэгдсэн, 4.3, 4.5-д найруулга өөрчлөгдсөн, 4.6 хасагдаж 4.8.4 заалтын дугаар нь 4.7.4 болж өөрчлөгдсөн, 6-р бүлэг хориглох заалт, YAMAT-тай холбоотой албан тушаалын нэршлийг өөрчилж, үйл явцын зураглалыг шинэчилж, дотоод хяналт шалгалтын зөвлөмжийн дагуу өөрчлөлт оруулсан. Энэ журам нь “ЭТТ” ХК-ийн ажилтнууд болон тусгай зөвшөөрлийн талбайд үйл ажиллагаа явуулж байгаа гэрээт болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч компаниудын ажилтнуудад хамаарна. Батлагдсан журмыг хэлтэс нэгж болон гэрээт компаниудад и-мэйлээр хүргүүлсэн.



Зураг № 129. Асгаралтын журмыг шинэчлэн батлуулсан байдал


Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт тайлан 2017 он	2020-12-01	Үзэх
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт тайлан 2016 он	2020-12-01	Үзэх

Зураг № 223. Компанийн цахим хуудсанд 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг байршуулсан байдал

14.2 Багийн иргэдэд БОМТ-ийн хэрэгжилтийг танилцуулах хурал

2025 оны 6 дугаар сарын 30 -ны өдөр уурхайн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг малчид болон багийн иргэд нийтэд танилцуулах үйл ажиллагааг Цогтцэций соёлын соёлын төвд зохион байгуулагдсан “Цагаан овоо” багийн иргэдийн нийтийн хуралд оролцон танилцуулга хийсэн. Мөн 2025 оны 11 сарын 10-ны өдөр Цагаан овоо багийн ИНХ-д 2025 оны БОМТ-ний биелэлтийн тайланг танилцуулсан.



Зураг № 224. Багийн хуралд 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайлан болон 2025 оны БОМТ-ний танилцуулга хийж буй байдал

Цогтцэций сумын Цагаан-Овоо, Сийрст багийн иргэдийн төлөөлөл “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Нүүрс баяжуулах үйлдвэрийн төсөлтэй танилцаж, санал солилцлоо. Зочдод компанийн үйл ажиллагааг танилцуулж, байгаль орчны чиглэлээр болон нийгмийн хариуцлагын хүрээнд хийж буй ажлуудын талаар мэдээлэл өгч цаашид хэрэгжүүлэх төсөл, үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар танилцууллаа. Байгальд ээлтэй, хаягдалгүй, эдийн засгийн өндөр өгөөж бүхий нүүрс баяжуулах үйлдвэр нь хэрэглэсэн усныхаа 96 хувийг дахин ашигладаг технологитой, үйлдвэрийн барилга байгууламжууд бүгд битүүмжлэлтэй, нүүрсний тортгийг гадагш гаргахгүй, байгаль орчинд ээлтэй баригдсанаараа давуу талтай гэдгийг онцлон танилцуулав.



Зураг № 225. Цогтцэций сумын Цагаан-Овоо, Сийрэст багийн иргэдэд Уурхай, нүүрс баяжуулах үйлдвэр болон компанийн хэмжээнд хийж хэрэгжүүлж буй ажлуудыг танилцуулж буй байдал

15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

№	Үйл ажиллагааны чиглэл	Төлөвлөсөн төсөв	Зарцуулсан хөрөнгө /мян. ₮/
1	Нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа	305,300.00	1,700,000.00
2	Зохион байгуулалтын төлөвлөгөө	56,000.00	56,000.00
3	ОХШХөтөлбөр	56,970.00	56,970.00
4	Хог хаягдлын менежмент	327,300.00	327,300.00
5	Соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	53,700.00	259,530.00
6	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	139,200.00	139,200.00
7	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	350,000.00	-
8	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	104,000.00	104,000.00
Нийт		1,312,970.00	2,662,800.00

15. ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУРЫН ДҮН

Бүлэг	Бүлгийн нэр	Төлөвлөсөн ажил	Шалгуур	Хэрэгжилт	Хувь
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө					
5.1.1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Тоос бууруулах бодисыг технологийн замд ашиглана.	15 км	Тайлант онд Цанхийн уурхайд нийтдээ 8.45 км технологийн автозамд тоос барьцалдуулагч DUST-LOC PLUS болон Лигносульфит төрлийн бодисийг ашигласан. Үүнээс Цанхийн зүүн уурхайд “Эко сойл” ХХК-ны нийлүүлдэг DUST-LOC PLUS бодисийг 5 км технологийн замд, Цанхийн баруун уурхайд мөн адил бодисийг 0.55 км технологийн замд, Лигносульфит бодисийг 2.9 км технологийн замд ашигласан байна.	56.3%
5.1.2		Уурхайн ашиглалтын замыг сайжруулах: материал, дэвсэлт хийх	15 км	Тайлант онд Цанхийн баруун уурхайд нийтдээ 72.9 га, 338.2 км зам талбайд 95,591 м3 шаварлаг материал дэвсэж сайжруулах ажил, Цанхийн зүүн уурхайд нийтдээ 11.8 га, 3.8 км зам талбайд 88,113 м3 шаварлаг материал дэвсэж сайжруулах ажил, Цанхийн нийт уурхайн хэмжээнд 84.7 га талбайд 183,704 м3 шаварлаг материал дэвсэж нийт 342 км технологийн автозамд сайжруулах ажил хийгдсэн байна.	100%
5.1.3		Уурхайн зам талбай, нүүрсний агуулах, гаалийн талбайд усалгааны машиныг тогтмол ажиллуулах	>5 ш	Уурхайн өдөр шөнийн ээлжинд Цанхийн баруун уурхайд 18 усны машин, Цанхийн зүүн уурхайд 10 усны машин, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2 усны машин, нүүрсний агуулах болон гаалийн хяналтын талбайд 3 усны машин, нийт 33 машин ажиллаж усалгаа хийгддэг ба энэ оны эхний 10-н сарын байдлаар нийт 866,571 м3 усыг зам усалгаанд ашигласан байна. Үүнээс 540,688 м3 хур борооны хуримтлагдсан ус, 88,428 м3 уурхайн шүүрлийн ус, 74,043 м3 цэвэршүүлсэн саарал ус, 125,783 м3 гүний усыг авч ашигласан байна.	100%
5.1.4		Уурхайн дотоод зам талбайд шороон зам дээгүүр зорчиж буй хөнгөн тэрэг болон уулын машин механизмуудад хурдны хязгаар тогтоож, гэнэтийн хэмжилт шалгалт хийж хяналт тавих	Сард 3	Уурхайн замын хөдөлгөөнд оролцож буй техникүүдийн хурд хэмжилтийг “Эрдэнэс Тавантолгой” ХК болон гэрээт туслан гүйцэтгэгч байгууллагуудын Хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн нар тогтмол 7 хоног бүр гэнэтийн хэмжилтийг хийдэг бөгөөд оны эхний 10 сарын байдлаар Цанхийн зүүн уурхайд 227 удаа, Цанхийн баруун уурхайд 558 удаа, нийт 785 удаа хурдны хэмжилт хийсэн байна.	100%
5.1.5		Ачаа тээврийн авто машинуудыг хатуу	2.9 км	Цогтцэций-Даланзадгад чиглэлийн замаас Баруун нарангийн автозам хүртэлх 7.4 км автозамын арчилгаа хийх хуваарийг	100%

		хучилттай авто замаар зорчуулах тал дээр хяналт тавьж ажиллах		Салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны газрын даргаар батлуулан гэрээт байгууллагуудын сар бүрийн төлөвлөгөөнд тусган тухай бүрт хийлгүүлэн ажилласан.	
5.1.6		Нүүрс тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх	Тогтмол	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Нүүрс ачилт, логистикийн хэлтэст 4-н ээлжинд нийт 32 хучигч ээлжээр ажилладаг ба нүүрс тээврийн ачаатай машиныг хучих ажлыг хариуцан гүйцэтгэдэг тул хучилт хийлгээгүй машин уурхайн бүсээс гарах боломжгүй байдаг.	100%
5.1.7		Ашиглаж буй техник хэрэгслүүдийг автотээврийн хяналтын үзлэгт оруулах	-	Уурхайн хөдөлгөөнт техникүүд болох экскаватор, өөрөө буулгагч, дугуйт ачигч, грейдэр, бульдозерууд болон хөнгөн тэргийг тус тус тээврийн хэрэгслийн техникийн үзлэг, оношилгоонд бүрэн хамруулсан.	100%
5.1.8		Агаарын чанарын хяналтын станцын тоог нэмэгдүүлэх	3 ш	2025.03.31-ний өдөр “Грийн трендс” ХХК-тай байгуулсан ЭТТ-2025/96 дугаартай гэрээний дагуу Aeroqual AQM65 агаарын чанарын 1 ширхэг станц худалдан авч байрлуулан хэмжилтийг тогтмол хийж байна.	33%
5.2.1		Ашиглалтын худагуудад бохирдол үүсэхээс сэргийлэн холбогдох шаардлага, стандартын дагуу худгийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих	Нийт худаг	Унд ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж буй худгуудын усны чанар, түвшингийн өөрчлөлт, ундарга зэргийг тогтмол хянах зорилгоор түвшингийн хэмжилтийг 7 хоногт 2 удаа, ундаргын тооцооллыг сард 1 удаа, усны шинжилгээг улиралд 1 удаа тус тус хийж гүйцэтгэн ажиллаж байна. Мөн хэмжилтийн үр дүнг боловсруулж, хагас жил болон жилийн эцсийн байдлаар ус ашиглалтын тайланг боловсруулж, Өмнөговь аймгийн БОАЖГ, ГӨДСГ, Усны газарт тус тус тогтмол тайлагнан ажиллаж байна.	100%
5.2.2	Гадаргын болон газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрлийг холбогдох журмын дагуу авч, ус ашиглах гэрээ байгуулан ажиллах	-	Цанхийн зүүн уурхайн 2025 оны ус ашиглах дүгнэлтийг 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Е-2501-000417 дугаартай, Цанхийн баруун уурхайн ус ашиглах дүгнэлтийг 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Е-2502-000031 дугаартай гаргуулсан. (Хавсралт №6. Хуудас ...) “Галба Өөш Долоодын Говийн Сав газрын захиргаатай 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 2025/16, ЕТТ-2025/354, 2025/15, ЕТТ-2025/355 дугаартай Ус ашиглах гэрээг байгуулсан. (Хавсралт №7. Хуудас ...)	100%
5.2.3		Усны нөөц ашиглуулах дүгнэлтэд заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй ашиглах, ус ашигласны	Сар бүр	Худгаас ашигласан усны ашиглалт тус бүрээр үзвэл унд ахуйн усны хэрэглээ 3%, мод усалгаанд ашиглаж буй усны хэрэглээ 1%, зам усалгаанд ашиглаж буй усны хэрэглээ 96% байна. Нийт ашигласан усанд эзлэх Худгийн усны хэрэглээ 14.5%,	100%

		төлбөр хураамжыг төлж барагдуулах		шүүрлийн усны хэрэглээ 10.2%, гадаргын усны хэрэглээ 62.4%, дахин ашигласан буюу саарал усны хэрэглээ 8.54%-ийн гүйцэтгэлтэй байна. (Хавсралт №4. Хуудас ...)	
5.2.4		Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрлийг холбогдох журмын дагуу авч, гэрээ байгуулан ажиллах	Тухай бүр	Хаягдал ус зайлуулах зөвшөөрлийг үндэслэн “Хаягдал усыг байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй байгуулах ус бохирдуулсны төлбөрийн гэрээ”-г 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр Галба-Өөш, Долоодын Говийн сав газрын захиргаатай 2025/01, ЭТТ-2025/272 дугаартай гэрээг байгуулсан. (Хавсралт №9. Хуудас 88) Гэрээний дагуу улирал тутам цэвэрлэх байгууламжуудын оролт, гаралтын бохир уснаас дээж авч лабораторид шинжлүүлэн Усны газраар төлбөрийн тооцоог гаргуулан төлбөрийг тогтмол төлж байна. (Хавсралт №10. Хуудас 89-91)	100%
5.2.5		Хаягдал усыг стандартын шаардлага хангасан цэвэрлэх байгууламжид цэвэршүүлэн саарал ус гаргаж зам талбайн тоосжилт дарах, мод усалгаанд ашиглах	-	2025 оны эхний 10 сарын байдлаар нийт 42,971.0 м3 саарал усыг дахин ашигласан бөгөөд эдгээр усыг “Энержи ресурс” ХХК-ны цэвэрлэх байгууламж болон “КА майнинг” ХХК-ны цэвэрлэх байгууламжаас авч нүүрс ачилтын талбайн тоосжилт дарах усалгаанд ашигласан байна.	100%
5.2.6		Газрын доорх усны нөөц, чанарт тогтмол хяналт тавих	3 цэгт	Унд ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж буй худгуудын усны чанар, түвшингийн өөрчлөлт, ундарга зэргийг тогтмол хянах зорилгоор түвшингийн хэмжилтийг 7 хоногт 2 удаа, ундаргын тооцооллыг сард 1 удаа, усны шинжилгээг улиралд 1 удаа тус тус хийж гүйцэтгэн ажиллаж байна. Мөн хэмжилтийн үр дүнг боловсруулж, хагас жил болон жилийн эцсийн байдлаар ус ашиглалтын тайланг боловсруулж, Өмнөговь аймгийн БОАЖГ, ГӨДГСГ, Усны газарт тус тус тогтмол тайлагнан ажиллаж байна.	100%
5.2.7		Ус ашиглалтын бүх эх үүсвэрээс ашиглах усны хэмжээг зөв тодорхойлох зорилгоор тоолууржуулах	-	Уурхайн ашиглалтын худгуудыг бүрэн тоолууржуулсан. Сар бүр ус ашиглалтын хэмжээг гаргаж Сумын Уул уурхай ус хариуцсан байцаагчид акт үйлдэж баталгаажуулсан.	100%
5.3.1	Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах	Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгын технологийн горимын мөрдөлтийг хангуулах, хяналт тавиж ажиллах	-	Цанхийн уурхайд нийтдээ 27 ш шимт хөрсний овоолго үүссэн байна. Шимт хөрсний овоолгууд дээр нийт 6226.9 мян.м³ шимт хөрс хадгалагдаж байна.	100%

5.3.2	Тусгай зөвшөөрлийн талбай дээрх ААН-ийн судалгаа хийх, Сумын ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудтай хамтран зөрчил арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх	1	Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа иргэн, аж ахуйн нэгж, объектын тооллогыг 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрөөс 4 дүгээр сарын 4-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Нийт 446 иргэн, аж ахуйн нэгж, бусад объектуудыг бүртгэлжүүлсэн.	100%
5.3.3	Ахилтад өртөх талбайн шимт хөрсийг >0.3 метр зузаантай хуулж, стандартын дагуу шимт хөрсийг хадгалах	Тухай бүр	Тайлант оны эхний 10 сарын байдлаар Цанхийн зүүн уурхайд нийт 35 зөвшөөрөл олгогдож 824,955.5 м ³ шимт хөрс хуулсан, Цанхийн баруун уурхайд нийт 53 зөвшөөрөл олгогдож 881,995.6 м ³ шимт хөрсийг хуулсан байна. Шимт хөрс хуулсан даруйд төлөвлөгдсөн овоолго руу зөөн байршуулсан байна.	100%
5.3.4	Дүүрсэн шимт хөрсний овоолгуудыг стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг харгалзан үзэж акт үйлдэн хаах	Овоолгын дүүрэлтээс шалтгаална	Цанхийн баруун уурхайд 4.2.13, 7.1.1 дугаартай шимт хөрсний овоолгууд дүүрч тухайн овоолгуудыг хэлбэржүүлэн, акт үйлдэн хаах ажил хийгдсэн. Тус овоолгуудад нийт 86,658 м ³ шимт хөрс хадгалагдаж байна.	100%
5.3.5	Шимт хөрс хуулах зөвшөөрлийг тухай бүр олгож холбогдох журмын дагуу овоолгод байршуулах	Жилийн турш	Шимт хөрс хуулах зөвшөөрлийн дагуу хуулагдсан талбайд байнгын хяналт тавьж, шимт хөрсийг гүйцэт хуулан, зохих овоолгод байршуулан хадгалдаг.	100%
5.3.6	Гэрээт байгууллагуудын ажилчдын хотхон – Уурхай чиглэлд зорчих замын маршрутыг гаргаж, мөрдүүлэх	-	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сум дахь салбараас Барууннаран-Ухаахудаг автозамаас урагш салаалсан Цанхийн баруун уурхайн ажилчдын ээлж солих сайжруулсан шороон замын шинэ маршрут батлуулах албан хүсэлтийг 2025 оны 05-р сарын 21-ний өдрийн 03/120 дугаартай албан бичгээр Цогтцэций сумын ЗДТГ-т хүргүүлэн батлуулсан.	100%
5.3.7	Хөрс бохирдохоос сэргийлж Цогтцэций сумын төвийн зорилтот бүлгийн зарим өрхөд эко жорлон суурилуулах	30ш	Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр Өмнөговь аймгийн Цогтцэций сумын зорилтот бүлгийн 17 өрхөд био ариун цэврийн байгууламжийг суурилуулж хүлээлгэн өгсөн байна. Үлдсэн айлыг 2025 онд багтаан био ариун цэврийн байгууламжтай болгохоор ажиллаж байна.	56%
5.3.8	Ажилчдын хотхоны хог хаягдлын цэгт бактерийн бохирдлоос сэргийлж ариутгал хийх		Тайлант онд катерингийн үйлчилгээ үзүүлэгч компани маань “Хүслэн-Од” ХХК-тай гэрээ байгуулан сард 3-4 удаа 5-н хогийн цэгт ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгүүлж байна.	100%

5.4.1	Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Зөвшөөрөлгүй газар хөндөхөөс сэргийлж, аливаа газар хөндөх ажлыг эхлүүлэхээс өмнө газар хөндөх зөвшөөрөл олгох, хөндөгдсөн газрын бүртгэлийг мэдээллийн санд оруулах	Тухай бүр	Салбарын захирлын 2021.12.11-ний өдөр А/145 дугаар тушаалаар баталсан “Газар хөндөх журам”-ын дагуу газар хөндөх зөвшөөрөл олгосны үндсэн дээр газар шорооны ажлыг хийж гүйцэтгэдэг. Зөвшөөрөл олгосон тухай бүртгэл, хөтлөлт хийн, мэдээллийн сан үүсгэсэн.	100%
5.4.2		Тусгай зөвшөөрлийн талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын явуулж буй ААН судалгаа хийх	Жилд 1 удаа	2024.03.14-ний өдөр А/300 дугаартай Өмнөговь аймгийн Засаг даргын захирамжаар НБҮ-ийн авто замын бүтээн байгуулалтад ашиглах ТТАМ ашиглах түр зөвшөөрөл авсан. Үүний дагуу 2024.05.03-ны өдөр Цогтцэций сумын Засаг даргатай ЭТТ-2024/1104 дугаартай ТТАМ ашиглуулах гэрээг байгуулан ажиллаж байна.	100%
5.5.1	Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Уурхайн ахилтанд өртөж болзошгүй ховор болон, нэн ховор ургамлын байршлыг тогтоож, мэдээллийн санд оруулах, өртөх тохиолдолд шилжүүлэн суулгах	6-8-р сарын хооронд	Ахилтанд өртөх талбайд судалгаа хийж ховор ургамлын 10 ширхэг өргөст ортуузны бодгаль, 15 ширхэг улаан сухайг шилжүүлэн суулгасан.	100%
5.5.2		Нутгийн ургамлыг таниулах зорилго бүхий экологийн боловсрол олгох	2-оос багагүй удаа	Цогтцэций сумын ЕБС-ийн 150 ахлах, төгсөх ангийн сурагчдыг “Экологийн боловсрол олгох” удирдамжийн дагуу “Грийн Центр”-ийн хурлын танхимд сургалт хийж, “Эрдэнэс” агропарк, НБҮ-ийн үйл ажиллагаатай танилцуулсан.	100%
5.6.1	Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрч зэрлэг амьтдын идэш тэжээл ховордох үед хужир, долооц, мөс, өвс тэжээл байршуулан биотехникийн арга хэмжээг зохион байгуулах	>500 боодол	Цогтцэций сумын Засаг Даргын тамгын газраас 2025 оны 02 сарын 14-нд ирүүлсэн 1/115 тоот албан бичиг болон, БОМТ-нд туссаны дагуу “Биотехникийн арга” хэмжээг хэрэгжүүлсэн. Нийтдээ гэрээт байгууллагатай хамтран 5 удаагийн арга хэмжээгээр 530 боодол өвс, 10 боодол ногоон тэжээл, 600 кг хужир, 400 кг долооц Сийрст багийн “Хангинах”-ын хад болон “Цэций” хайрханд зэрлэг амьтанд зориулан байршуулсан. (Хавсралт №17. Хуудас 104)	100%
5.6.2		Зэрлэг амьтдад зориулсан ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах	2 ш	“Эрдэнэс Тавантолгой” ХК-иас Өмнөговь аймгийн Цогтцэций сумын байгаль хамгаалагчид Байршлыг тодорхойлуулах тухай утсаар холбогдож мэдээлсэн. Уг мэдээллийн дагуу Цогтцэций сумын байгаль хамгаалагчаас 2025 оны 07-р сарын 25-ны өдөр албан мэйл ирсэн бөгөөд уг мэйлд малчин иргэд ойлголтын	100%

				зөрүүтэй байдлаас шалтгаалан энэ жил 2 байршилд хөв цөөрөм хийх байршил өгөх боломжгүй талаар мэдэгдсэн..	
5.6.3		Шувууны өртөлтийг багасгах зорилгоор өндөр хүчдэлийн шугамын трассаар хяналт хийж ажиллах	50 км	Шувууны өртөлтийн судалгааг гэрээт компанийн байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран Загийн усны хоолой, Цанхийн зүүн баруун уурхай, Таван толгой дэд станц зэрэг цахилгааны шугамын дагуу нийтдээ 126 км трасс бүхий газарт хийж гүйцэтгэсэн.	100%
5.6.4		“Эрдэнэс Тавантолгой” ХК болон гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын ажилтнуудад хулгайн ангаас сэргийлэх хууль эрхзүйн сургалтыг Цогтцэций сумын экологийн цагдаатай хамтран зохион байгуулах	>500 хүн	Цогтцэций сумын Экологийн цагдаатай хамтран “Грийн Центр”-ийн хурлын танхимд инженер техникийн ажилтнууд болон, гэрээт компанийн байгаль орчны мэргэжилтнүүдийг хамруулан 64 ажилтанд “Хулгайн антай тэмцэх” талаар сургалт орсон. Гэрээт байгууллагууд тус сургалтыг өөрсдийн 817 ажилтнуудад үргэлжлүүлэн сургалтыг зохион байгуулсан. Нийт 881 ажилтанд сураглтыг орсон байна.	100%
Бүлгийн нийт дүн					95%
6. Нөхөн сэргээлтийн төлөвлөө					
6.1.1		Шартээг-13.5км автозамыг холбосон 2.9км хатуу хучилттай авто зам ашиглалтад орсны дараа хуучин шороон замыг нөхөн сэргээх	2.3 га	IDMN хотхоноос Цогтцэций сумын 13.5 км зам хүртэлх хуучин 2.9 км шороон зам буюу 2.76 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж Өмнөговь аймгаас томилогдсон ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.	100%
6.1.2	Техникийн нөхөн сэргээлт	Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн авто зам дагуу 0-25 дахь км хүртэлх замын хажуугаар олон салаа шороон зам үүсэхээс сэргийлсэн шороон далан, шуудууг нөхөн сэргээх	1 га	Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн авто замын 0-25 км хүртэлх замын хажуугаар гарсан олон салаа замыг хааж, шороон далан, суваг шуудууг сэргээн татаж нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%
6.1.3		Шартээг-13.5км автозамыг холбосон 2.9 км хатуу хучилттай авто зам ашиглалтад орсны дараа Баруун нарангийн авто замаас салаалсан ачаа тээврийн 7.4 км шороон	7.4 га	Тавантолгой-Ханги мандал чиглэлийн автозам дагуух сайжруулсан 9 км шороон замын техникийн нөхөн сэргээлтийг Үндэсний манлайлал түншлэл, Кэй Эй майнинг ХХК, Овоот толгой ресурс ХХК-тай хамтран хийсэн.	100%

		замыг хэсэгчлэн нөхөн сэргээх			
6.2.1	Биологийн нөхөн сэргээлт	Хоёр жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлж олон наст өвслөг ургамал тариалах	3 га	Гэрээт компанитай хамтран хаагдсан шимт хөрсний овоолгын 11.3 га талбайд хаврын тарилтаар төлөвлөж 6 га талбайд тарилтыг ажлыг хийсэн.	100%
6.2.2		Модлог ургамлын үрийн нөөц бүрдүүлэх	>10 кг	Дүйцүүлэн хамгаалах талбайгаас шар модот хотирын үр 2 кг түүсэн. Мөн бүйлсний 10 кг, таримал жигд үр 4 кг, таримал агч 14 кг тус тус гэрээт компаниудтай хамтран үрийн нөөц бүрдүүлсэн.	100%
6.2.3		Модлог ургамлын мөчир бэлтгэх	>2000 ш	Эх модны талбайгаас 1-2 сард 5500 ширхэг улиасны модлог мөчир бэлтгэж тарьсан. Гэрээт компаниас 2000 ширхэг мөнгөлөг улиас, шинжаан улиасны мөчир авч бэлтгэсэн “Мөчрийн” талбайд тариалах ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%
6.2.4		Хүнсний ногооны хаягдал ашиглан био компост бордоо бэлтгэх	>500 кг	Бордоошуулах зориулалттай тус бүр нь 300 литр багтаамж бүхий 10 ширхэг саванд хүнсний ангилсан хаягдлыг хийж бордоошуулагч ашиглан 3 тонн бордоо бэлтгэсэн.	100%
6.2.5		Модлог ургамлыг үр, мөчир хэлбэрээр үржүүлэх	>20000 ш	“Эрдэнэс” агропаркийн 10га МҮГ-д үр, мөчрөөр 29000 ширхэг үрсэлгээг бортгонд болон ил талбайд тарьж усалгааг тогтмол хийсэн.	100%
Бүлгийн нийт дүн					100%
7. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө					
7.1.1	Амьтны олон янз байдлыг хамгаалах	Махчин шувууд суух боломжтой хиймэл үүр суурилуулах	5 ш	Дүйцүүлэн хамгааллын талбайд махчин шувуу суух, үүрээ засах боломжтой үүрийг гар доорх материалаар хийж дугант, шангайн хэц орчимор 5 ширхэгийг байрлуулсан.	100%
7.1.2		Хууль бус хулгай антай тэмцэх ажлын хүрээнд орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах	-	2025 онд Цогтцэций сумын нутаг дэвсгэрт хулгайн антай тэмцэх ажлын хүрээнд олборлолтын гэрээт байгууллагуудын тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тус бүр 2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж зардлыг тусгуулан батлуулсан.	100%
7.1.3		Амьтны камерын өгөгдөлийг цуглуулан боловсруулж, дүн шинжилгээ хийх	3	Дүйцүүлэн хамгаалах талбайн Дугант, шангайн хэц орчимд хоёр байршилд амьтны камерыг байрлуулан 5 сарын хугацаанд байршуулан өгөгдлийг цуглуулсан. Амьтны камерын өгөгдөлд ихэвчлэн 5 хошуу мал ихээр бичигдсэн бөгөөд тас шувуу, цармын бүргэд, цөлийн чогчиго зэрэг жигүүртэн шувууд өртсөн байна.	100%

7.1.4		Зүүнбаян чиглэлийн Төмөр замын орчимд хар сүүлтийг хүзүүвчлэн тандан судалгаа гүйцэтгэх	1	Дүйцүүлэн хамгаалах талбайд хийгдэх Зүүнбаян чиглэлийн төмөр замын орчимд хар сүүлт гөрөөсийг хүзүүвчлэн тандан судалгааны ажил гүйцэтгэх ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр захиалгын хуудсыг 2025 оны 02-р сарын 27-ны өдөр батлуулан компанийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Компанид тогтоосон онц байдлаас шалтгаалан одоогоор тэндэр шалгаруулалт зарлагдаагүй байна.	0%
7.2.1		Байгалийн ургамлыг таних, хамгаалах, зөв зохистой ашиглах талаар сургалт, дадлага зохион байгуулах	2 удаа	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах бүлгийн сурагчдад экологийн оловсрол олгох сургалт, дадлага зохион байгуулах ажлын хүрээнд салбарын захирлаар удирдамж батлуулан “Мөрөөдөл” сургуулийн ахлах бүлгийн 98 сурагчийг 2025 оны 09-р сарын 21-ны өдөр, “Т.Борын нэрэмжит сургууль”-ийн 65 сурагчидыг 10-р сарын 04-ны өдөр хүлээн авч зохион байгуулсан.	100%
7.2.2		Дүйцүүлэн хамгаалах талбайд тогтоосон бэлчээрийн хяналтын мониторинг хийх	12 цэгт	Дүйцүүлэн хамгаалах талбайн ургамлын мониторингийн байнгын 12 цэгт 2025 онд хийх мониторингийн ажлыг гэрээгээр нүүрс ачилтийн үйл ажиллагаа явуулж буй “КЭРС” ХХК болон “МСДГ” ХХК-ны 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2025 оны 09-р сарын 01-ны өдөр хийц гүйцэтгэсэн. (Хавсралт №20. Хуудас 117-118)	100%
7.2.3	Ургамлын олон янз байдлыг хамгаалах	Говийн мод, сөөгний тарьц суулгац бэлтгэх талбайг арчилж хамгаалах	3.2 га	Дүйцүүлэн хамгаалах ажил гүйцэтгэж буй Шангай, Дунгант орчимд байрлах 99000 га талбайд 2019 оноос эхлэн говийн бүсийн мод, сөөгний тарьц бэлтгэх ажлын хүрээнд ойн зурвас, эх модны талбай байгуулах ажил хийгдэж эхэлсэн. Уг талбай нь 3.2 га хэмжээтэй бөгөөд 5000 орчим мод 90 гаруй хувийн ургалттай ургаж байна. Тайлант онд уг талбайн усалгаа арчилгааны ажлыг хамтран ажиллах санамж бичиг байгуулсан “Билигт малчин” хоршоо хариуцан усалгаа арчилгааг хийж гүйцэтгэж байна.	100%
7.2.4		Хөрсний шинж чанар, элэгдэл эвдрэл, физик болон хими шинж чанарыг тодорхойлох зорилгоор дээж авч, хөрсний бичиглэл хийх, зураг боловсруулах, доройтлын хүчин зүйлийг тодорхойлох		Дүйцүүлэн хамгаалах талбайд хийгдсэн хөрсний хээрийн судалгааг 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 10 дугаар сарын 08-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв. Хээрийн судалгааг хийхдээ хөрсний төлөөлөл болохуйц цэгт зүсэлт хийх, GPS-ийн хэмжилт, морфологи бичиглэл хийх, дээж авах зэрэг үйлдлийг гүйцэтгэхээс гадна тухайн талбайн хөрсний элэгдэл эвдрэл, бохирдолт, ялзмагт үеийн зузаан, намагжилт, давсжилт, өндөржилт, налуужилт, чулуужилт зэргийг тодорхойлсон.	100%

7.3.1	Уст цэгийн хүрэлцээ хангамжийг сайжруулах	Ус хангамжийг сайжруулах зорилгоор булгийн эхийг хашиж хамгаалах	1 ш	“Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Сийрст багийн нутаг дэвсгэрт орших “Хээрийн булаг”-н (Зүүн) булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд зохион байгуулж хэрэгжилтийг ханган ажилласан.	100%
7.3.2		Өмнө жилийн дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн зэрлэг ан амьтны худгийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих	2 ш	Тайлант онд өмнөх жилүүдэд хийгдсэн зэрлэг ан амьтаны худгийн хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд 2025 оны 07-р сарын 27 өдөр болон 10-р сарын 05, 11-ний өдрүүдэд хяналтийг хийж гүйцэтгэсэн.	100%
7.4.1	Дүйцүүлэн хамгаалах талбайг нэмэгдүүлэх	НБҮ, ЗУХ-н төслүүдийн цар хүрээнд дүйцүүлэн хамгаалах талбайн хэмжээг орон нутагтай хамтран ажиллаж тогтоох	-	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс уг талбайн байршлыг сонгохдоо Цанхийн уурхайн дүйцүүлэн хамгаалах ажил гүйцэтгэж буй байршлын хажууд залгасан байдлаар хийхээр төлөвлөсөн бөгөөд энэ байршлыг баталгаажуулахаар Өмнөговь аймгийн Байгаль орчны газарт 2025 оны 10-р сарын 12-ны өдрийн 3/280 дугаартай албан бичгээр хандаад байна.	100%
Бүлгийн нийт дүн					91%
8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө					
8.1	Цагаан овоо багийн иргэдтэй нөхөн олговрын гэрээ байгуулан нөхөн олговор олгож газар чөлөөлөх		16 иргэн	2025 онд 2 иргэнтэй нөхөн олговор олгох гэрээ, 14 иргэнтэй нөхөн олговрын гэрээ дүгнэсэн актыг байгуулж 16 иргэний газар чөлөөлөх ажлыг зохион байгуулж 175,195,496₮-ийн нөхөн олговор олгосон.	100%
Бүлгийн нийт дүн					5
9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө					
9.1	Соёлын өвийг хамгаалах талаар уурхайн ажилчдад таниулах, энэ чиглэлээр хийгдсэн ажлуудыг танилцуулах.		-	2018-2023 оны хооронд “Археологи, Угсаатан зүйн, Палеонтологийн Монгол улсын “Шинжлэх ухааны Академи Археологийн хүрээлэн” болон “Палеонтологийн Хүрээлэн”-ийн судалгааны үр дүнд гарсан олдворуудын мэдээллийг нэгтгэн уурхайн болон гэрээт компаниудын баруун зүүн уурхайн оператор, инженер техникийн нийт 190 ажилтанд танилцуулсан.	100%
9.2	Үндэсний шагайн харвааны салбар зөвлөлийн тэмцээн зохион байгуулах		3-р улиралд	Соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд “ЭТТ” ХК-ийн ЗГОбЭ төлөөлөгчийн багийн ахлагчийн 2025.07.29 А/297 тоот тушаалаар 2025.08.01-2025.08.03-ний өдрүүдэд Дундговь аймгийн Дэрэн сумын нутаг Наранхөгцтийд зохион байгуулагдсан.	100%

9.3	Цогтцэций сумын 9 гайхамшигт орсон Цавчирын задгайг тохижуулах	2, 3-р удиралд	Цавчирын задгай орчмын тохижуулах ажлыг дуусгаж гэрээт компани хүнтэй, сумын БО байцаагч, байгаль хамгаалагч нартай хамтран явж танилцуулсан. Цавчир задгай тохижуулах ажлыг суманд хүлээлгэн өгч акт үйлдсэн.	100%	
9.4	Археологийн авран хамгаалах малтлага хийлгэх	30 дурсгал	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий MV-011953 дугаартай “Салбарын Цанхийн зүүн уурхай” нэртэй 12860 га хэмжээтэй, MV-011954 дугаартай “Бор тээг” нэртэй 8941 га хэмжээтэй болон MV-011955 дугаартай “Шар тээг” 23803 га хэмжээтэй ашиглалтын гурван талбайд тус тус археологийн авран хамгаалах малтлага судалгааны ажлыг 2025 оны 09-р сарын 07-ны өдрөөс 10-р сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.	100%	
Бүлгийн нийт дүн				100%	
10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө					
10.1.1	Нүүрс устөрөгч, Химийн бодис хяналтгүйгээгээр асгарах	ХАЛМ болон асгаралтын иж бүрдлийг шаардлагатай ажлын байранд байршуулах	10-аас доошгүй	ХАЛМ болон асгаралтын иж бүрдлийг шаардлагатай ажлын байранд байршуулсан. Асгаралтын иж бүрдлийг “БХЭБЭЭ” ХХК-тай гэрээ байгуулан асгаралтын иж бүрдэлд шаардлагатай нөөц материалын татан авалт хийгдсэн.	100%
10.1.2		Тусгай бэлдсэн талбайд бохирдсон хөрсийг байршуулах	Тодорхойлох боломжгүй	“Эрдэнэс Тавантолгой” ХК болон гэрээт компаниуд тусгайлан бэлтгэсэн “Бохирдсон хөрс саармагжуулах талбай”-д бохирдсон хөрсийг тухай бүрт байршуулан ажилладаг.	100%
10.1.3		Бохирдсон хөрс саармагжуулах талбайг стандартын дагуу шинээр байгуулах	1 талбай	“Эрдэнэс Тавантолгой” ХК нь “Өршөөлтийн ариун” ХХК-тай “Бохирдсон хөрс саармагжуулах талбай байгуулах материал биелүүлэх, гэрээ”-г байгуулж ЦБУ-н 1-р овоолго дээр бохирдсон хөрс саармагжуулах талбайг стандартын дагуу шинээр байгуулсан.	100%
10.1.4		Асгаралтыг бүртгэлжүүлж мэдээллийн сан үүсгэх	-	2022 оны 01-р сараас эхлэн дундын шэйр файл үүсгэж асгаралтын тохиолдол бүрийг бүртгэлжүүлж мэдээллийн сан үүсгэсэн.	100%
10.1.5		Асгаралтын журмыг шинэчлэн сайжруулах, батлуулах	1	“Асгаралтын журам”-д гаардлагатай өөрчлөлтийг оруулан шинэчлэн Салбарын захирлын 2025 оны 10-р сарын 26-ны өдрийн А/61 дугаартай тушаалаар шинэчлэн батлагдсан.	100%
10.2.1	Байгалийн аюул, гамшигт нөхцөл байдал	Уурхайн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх	Уурхайн хэмжээнд	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Уурхайн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 2025 оны 2 сард, Уурхайн Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2024 оны 12 сард тус тус Уул уурхайн	100%

		төлөвлөгөөг боловсруулж батлуулах		аврах 09 дүгээр анги болон холбогдох мэргэжлийн байгууллагын удирдлагуудтай хамтран баталгаажуулсан.	
10.2.2		Уурхайн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг нийт ажилтнуудад танилцуулах	>800 хүнд	Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Уурхайн гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг “ЭТТ” ХК болон гэрээт компанийн ажилтнуудад танилцуулсан. Мэргэжлийн ангийн гишүүдэд бэлэн байдлын үзлэг хийсэн.	100%
10.2.3		Үерийн эрсдэл бүхий цэгүүдэд байгуулсан ус зайлуулах суваг шуудууг сэргээх	-	Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх суваг шуудууг сэргээх ажлын төлөвлөгөөг гаргаж хэрэгжилтийг ханган ажилсан.	100%
10.3.1		Галын аюулгүй байдлын журамд тодотгол хийж, түүнийг дагаж мөрдөх	-	Галын аюулгүй байдлын журмыг Салбарын захирлын 2024 оны 05-р сарын 07-ны өдрийн А/23 дугартай тушаалаар шинэчлэн батлуулсан бөгөөд журмын дагуу гал унтраах төлөвлөгөөнд тодотгол хийж галын сайн дурын бүлгийн гишүүдийг томилгоожуулсан.	100%
10.3.2	Гал түймрийн аюул, эрсдэл	Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалын заасан самбар галын аюул болж болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байрлуулах, хяналт тавих	100	Галын аюулгүй байдлын үзлэгийн хуваарийн дагуу гал унтраагуур, дохиоллын үзлэг 24 удаа хийж даралт унасан буюу шинээр гал унтраагуур 2кг-14ш, 4кг-7ш, 6кг-18ш, 9кг-100 ширхэг, бөмбөлгөн гал унтраагуур 3 ширхэг, автомат гал унтраагуур 9 ширхгийг тус тус шинээр сольж галын аюулгүй байдлыг ханган ажилласан.	100%
10.3.3		Шатахуун түгээх станцын талбайд ил гал гаргахыг хориглосон, анхааруулсан тэмдэг, санамж байрлуулах, үерээс хамгаалсан суваг, шуудууг татах, сэргээх	5	Шатахуун түгээх станцад төлөвлөгөөт бус хяналт шалгалт зохион байгуулж анхааруулсан хориглосон тэмдэг тэмдэглэл байрлуулсан.	100%
10.4.1	Байгаль орчинд учруулж болзошгүй эрсдэл	Хөрсний нуралтаас урьдчилан сэргийлэхийн тулд ил уурхайн хөрс хуулалт, шатлал, ухалт, тэсэлгээ зэрэг ажлуудыг	Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд	Салбарын захирлын баталсан журам, заавруудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	100%

		гүйцэтгэхдээ холбогдох горимыг чанад мөрдөж ажиллах			
Бүлгийн нийт дүн					100%
11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө					
11.1.1	Бүх төрийн хог хаягдал	Хог хаягдлын нэгдсэн төв, ландфил байгуулах зураг төслийн ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	1	2025 оны 06-дугаар сарын 17-ны өдөр “Тэмжин” ХХК-тай ЭТТ-2025/343 дугаар бүхий “Уурхайн хог хаягдлын ландфиллын зураг төсөл боловсруулах ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулсан. Зураг төслийн ажил хийгдэж байна.	100%
11.1.2		Хог хаягдлын журмыг шинэчлэх боловсруулж, дагаж мөрдүүлэх	-	“Хог хаягдлын журам”-нд хэлтэс нэгжүүдээс санал авч Хууль зүйн зохицуулалтын хэлтэс, комплайнсын ахлах мэргэжилтэн, холбогдох газрын удирдлагаар хянуулж, Гүйцэтгэх удирдлага томилогдох үед баталгаажуулахаар ажиллаж байна.	100%
11.1.3		Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ангилал тус бүрээр 2 дахь шатны байгууллагад нийлүүлэх	-	Тайлант онд 7.5 тн хуванцар хог хаягдлыг “Цэмцгэр Өмнөговь” ОНӨААТҮГазар болон “Дүүрэн Цэций” ХХК-д нийлүүлсэн.	100%
11.1.4		Ангилан ялгасан хог хаягдлын хяналтыг сайжруулах, бүртгэлжүүлэх	Нэгж тайлан	Хог хаягдлын журмын дагуу өдөр тутмын үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлыг бүртгэж, мэдээллийн сан үүсгэсэн.	100%
11.1.5		Хоолны хаягдлаар бордоо хийх туршилт судалгааны ажлыг гүйцэтгэх	1	Ажилчдын хотхоны гал тогооноос гарч буй хүнс ногооны хаягдал 300л багтаамж бүхий 10ш био компост үйлдвэрлэх бокаши саванд халууны улиралд буюу 7, 8, 9 сард бордоошуулагч бодис ашиглан био компост боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%
11.1.6		Хоолны хаягдал үүсгэхгүй байхад чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулах	2 удаа	8, 10 сард Хоолны хаягдлыг бууруулья, Хоолны хаягдалгүй ажлын хамт болцгооо уриалгыг салбарын мэйлээр хүргэж ажилчдын хоолны зааланд байршуулсан.	100%
11.2.1	Аюултай хог хаягдал	Гэрээт компаниудын хаягдал тос, аюултай хог хаягдал түр хадгалах цэгийн стандартын шаардлагыг хангуулах	Бүх компаниуд	ЦЗУ, ЦБУ-н гэрээт байгууллагууд нь хаягдал тосны байгууламжийн суурийг бетонон, хамгаалах хөмсөгтэй байгуулсан ба засвар үйлчилгээг тухай бүр хийдэг.	50%
11.2.2		ЭТТ ХК-ийн Хаягдал тосны байгууламжийг стандартад нийцүүлэх	1	ЭТТ ХК-ийн Засварын шоп шинээр баригдаж байгаа. Хаягдал тосны байгууламжийг стандартын дагуу хийхээр төлөвлөгдөн барилга угсралтын ажил хийгдэж байна.	50%

11.2.3		Аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй ААН-Д шилжүүлэх, тээвэрлүүлэх	>5 удаа	Аюултай болон овор ихтэй хог хаягдлыг шилжүүлэх, тээвэрлүүлэх гэрээг “Түмэн эгшиг” ХХК-тай байгуулсан ба гэрээний дагуу дагалдах хуудсаар аюултай хог хаягдлыг нийлүүлсэн. 2025 оны төсөвт 144.5 сая төгрөг суулгаж, тендер зарлагдаж “Элемент” ХХК шалгарсан.	100%
11.2.4		Аюултай хог хаягдлыг нийлүүлсэн тусгай зөвшөөрөлтэй ААН-ээс хог устгалын тайлан, дагалдах хуудас зэргийг авч, мэдээллийн сан үүсгэх	Тухай бүр	Аюултай хог хаягдал нийлүүлсэн акт тайланг “Түмэн эгшиг” ХХК-аас авч бүртгэлжүүлсэн.	100%
11.2.5		Аюултай хог хаягдал үүсгэгчийн тайлан боловсруулж, аймгийн байгаль орчны газарт хүргүүлэх	1 удаа	Аюултай хог хаягдал үүсгэгчийн тайланг жил бүрийн 1 сард боловсруулж, аймгийн байгаль орчны газарт хүргүүлдэг.	100%
11.3.1		Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн авто замын 0-25 дахь км зам дагуу талбайн үзлэгийг тогтмол зохион байгуулж, хяналт тавих	12 удаа	2025 онд Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн авто замын 0-25 дахь км зам дагуу хог хаягдлын цэвэрлэгээний ажлын төлөвлөгөөг “Эрдэнэс Тавантолгой” ХК Салбар болон “Гашуун сухайт авто зам” ХХК-тай хамтран баталж сар болгон 1 ширхэг дугуйт ачигч, 2 ширхэг өөрөө буулгагч 50-80 гаруй хүний бүрэлдэхүүнтэй хог хаягдлын их цэвэрлэгээг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.	100%
11.3.2	Бүх нийтийн цэвэрлэгээ хяналт шалгалт	Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн авто замын 0-25 дахь км зам дагуу хог хаягдлын цэвэрлэгээг сар бүр хийж, тайланг БОГ болон сумын ЗДТГ-г хүргүүлэх.	12 удаа	Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн авто замын 0-25 дахь км зам дагуу хог хаягдлын цэвэрлэгээний ажлын төлөвлөгөөний дагуу хийж тус цэвэрлэгээний тайланг боловсруулан Өмнөговь аймгийн Цогтцэций сумын сумын Байгаль орчны улсын байцаагчид тухай бүр хүргүүлэн ажилладаг.	100%
11.3.3		Сум орон нутгаас зохион байгуулж буй хог хаягдлын цэвэрлэгээнд оролцох	Тухай бүр	2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн Өмнөговь аймаг Цогтцэций сумын Засаг даргын “Бүх нийтийн хог цэвэрлэгээ зохион байгуулах тухай” захирамжийг үндэслэн 2025 оны 02 дугаар сарын 23, 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр “Бүх нийтийн хог хаягдлын их цэвэрлэгээний төлөвлөгөө”-г Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны газрын даргаар батлуулан цэвэрлэгээ зохион байгуулсан.	100%

11.3.4		Уурхай болон сум-хотхон хоорондын авто зам дагуу хог хаягдлын цэвэрлэгээ хийх	4	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Салбарын захирлын “Орчны болон ажлын байрны цэвэрлэгээний цагтай болох тухай” тушаал, Бүх нийтийн хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэдэг.	100%
		Хог хаягдлын цэгүүдэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах.	12 удаа	2025 оны 10 дугаар сарын 27-ний байдлаар хог хаягдлын цэгүүдэд нийт 17 удаагийн шалгалт ажлын байрны үзлэгийг хийж гүйцэтгэж, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээн авч ажилласан байна.	100%
Бүлгийн нийт дүн					100%
12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө					
12.1.1	Агаарын чанарын хяналт	Агаар дахь тоосонцорын хэмжилт	7 хоногт >60 цаг	Цанхийн баруун, зүүн уурхайн хэмжээнд 5 цэгт тоосны агууламжийн хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Хэмжилтийг 7 хоногт 2 удаа, 1 хэмжилтийг 45-с багагүй цаг байхаар тохируулж хийсэн ба нийт 5 цэгт 10,713 цаг/жил хэмжилт хийж гүйцэтгэсэн.	100%
12.1.2		Цаг уурын үзүүлэлтийн хэмжилт	Хяналтын 1 цэгт	2025.01.31-ны өдөр Агаарын чанарын суурин станц нийлүүлэх гэрээ байгуулж, 3.31-нд хүлээн авч хэмжилтийг хийж эхлүүлсэн. Мөн Өмнөговь аймгийн Цаг уурын хүрээлэнгээс цаг агаарын мэдээг авсан.	100%
12.1.3		Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ /NO ₂ , SO ₂ , H ₂ S, CO, Formaldehyde/	Хяналтын 10 цэгт.	2025.09.12-нд “Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ хийх гэрээ” байгуулж 9-р сарын 25-29 ны хооронд хяналтын цэгүүдэд хэмжилтийг хийсэн.	100%
12.1.4		Гадаад орчны дуу шуугианы хэмжилт	14 хоногт 1 удаа	Уурхайн хяналтын цэгүүдэд 14 хоног бүр тэмдэглэл хийж хэмжилтийг хийсэн.	100%
12.1.5		Тоосонцорын агууламжийн хүнд металлын шинжилгээ	Уурхай болон ажилчдын хотхоны 6 цэгт	2025.05.03-нд “Тоосонцорын агууламж дахь хүнд металлын хэмжилт хийлгэх гэрээ” байгуулж хяналтын цэгүүдэд 7 байршил 6-р сард агаарын сорьц цуглуулсан. 10-р сарын 3-р долоо хоног агаарын сорьц цуглуулан шинжүүлэхээр хүргүүлсэн.	100%
12.1.6		Цацрагийн хяналт, шинжилгээ	Уурхайн хяналтын 10 цэгт	2025.06.17-нд хяналтын 10цэгт цацрагийн хяналт, шинжилгээ хийсэн.	100%
12.2.1	Усан орчны хяналт, шинжилгээ	Газрын доорхи усны гормиын судалгаа	6 цаг тутам	Уурхайн үйл ажиллагаанаас гүний усанд нөлөөлөл үзүүлж байгаа эсэхийг хянах зорилгоор гүний усны хяналтын 2023 оноос Цанхийн зүүн уурхайн W-21 цооног, Цанхийн баруун уурхайн W-11 цооногуудад хэмжилтийг тогтмол хийж байна. Уурхайд ашиглагдаж буй гүний усны худгууд болон гүний усны хяналтын цооногуудын усны түвшиний мэдээг усны түвшин	100%

				хэмжигч автомат багаж болон гар түвшин хэмжигч ашиглан жилийн турш хэмжиж гидрогеологич инженертэй хамтран өөрчлөлтийг хянаж ажилласан.	
12.2.2		Бага гүний усны түвшин хэмжилт	12 цаг тутам	Уурхайн нөлөөллийн бүсийн сонгогдсон бага гүний уст малчны худгуудад усны автомат түвшин хэмжигч багаж суурилуулан 6 цаг тутам хэмжилт хийж гүйцэтгэж байна. Мөн хэмжилтийг баталгаажуулах зорилгоор гар багажаар түвшиний хэмжилтийг хийж гүйцэтгэсэн.	100%
12.2.3		Газрын доорхи усны геохимийн судалгаа	Уурхайн худаг болон Ахуйн хэрэглээний худаг /Нийт 17 худаг/	Уурхайн ашиглалтын худгууд болон нөлөөллийн бүсийн малчны худгуудаас улирал тутам дээж авч макро, микро элементүүдийг шинжлүүлсэн. Шинжилгээний хариуг хавсралтаар оруулав.	100%
12.2.4		Ахуйн усны эрүүл ахуйн үзүүлэлтийн судалгаа		Ажилчдын амрах хотхон болон захиргааны байрны хэрэглээнд ашиглаж буй ахуйн усны худгууд, цэвэр усны нөөцийн сав, усны машины ёмкост, гал тогооны цоргоноос улирал тутам усны дээж авч усны эрүүл ахуйн үзүүлэлтүүдийг шинжлүүлсэн.	100%
12.2.5		Саарал усны хяналт шинжилгээ	Цэвэрлэх байгууламжийн саарал ус /4 цэвэрлэх байгууламж/	Цанхи хотхон, Эрдэнэс хотхон, уурхайн оффис болон Грийн центрийн цэвэрлэх байгууламжаас улирал тутам усны дээж авч бохир усны үзүүлэлтүүдийг шинжлүүлэн ажиллаж байна.	100%
12.3.1	Хөрс, ургамлан бүрхэвчийн мониторинг	Хөрсний чанар - Хими физикийн ерөнхий үзүүлэлтүүд	Мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэсэн байна.	Тайлант онд хөрсний мониторингийн хяналтын 10 цэгээс дээж авч 2 удаа шинжлүүлсэн.	100%
12.3.2		Хөрсний чанар - нянгийн шинжилгээ		“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн цэвэрлэх байгууламжууд болон гэрээт байгууллагуудын цэвэрлэх байгууламжийн орчмын 5 цэгээс 2 удаа хөрсний дээж авч шинжлүүлсэн.	100%
12.3.3		Хөрсний чанар - Хүнд металлын шинжилгээ		2025 онд Уурхайн шатахуун түгээх станц болон хаягдал тосны талбай ойр орчим зэрэг 17 байршлаас 2 удаа хөрсний дээж авч итгэмжилсэн лабораторид шинжлүүлсэн.	100%
12.3.4		Шимт хөрсний овоолгын чанарын шинжилгээ		2025 онд Уурхайд хадгалагдаж буй шимт хөрсний овоолгуудын давхардсан тоогоор 36 байршлаас 2 удаа хөрсний дээж авч итгэмжилсэн лабораторид шинжлүүлсэн.	100%
12.3.5		Тусгай зөвшөөрлийн талбайд ургамлын мониторинг хийх		6 Трансектийн дагуу нийт 26 цэгт ургамлын мониторинг хийхээр төлөвлөгөө боловсруулж цэг тус бүр дээр 3 өөр байрлал сонгон бичиглэл хийн нийт 78 удаагийн давтамжтайгаар ургамлын бичиглэлийг гэрээт компаниудын хамт 6-р сар болон 9-р саруудад тус тус хийж гүйцэтгэсэн.	100%

Бүлгийн нийт дүн				100%
13. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө				
13.1	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Байгаль орчны инженерүүд болон гэрээт компанийн Байгаль орчны мэргэжилтнүүдэд сургалт, зааварчилгаа хүргэх	2 удаа	Гэрээт компаниудын байгаль орчны мэргэжилтэн нарт сая тонн-сая мод хөтөлбөрийн дагуу БОМТ-нд тусгагдсан мод тарих ажил эхлэхээс өмнө модны төрөл, норм хэмжээ, ажлын даалгавар, ойжуулалтын хөрс боловсруулах ажлуудыг нормын дагуу танилцуулж, сургалт орсон.	100%
13.2	Гэрээт туслан гүйцэтгэгч компаниудын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг зохион байгуулах.	Тухай бүр	Гэрээт байгууллагын “Уулын ажлын гэрээ”-нд Байгаль орчны чиглэлээр хийгдэх ажлын талаар тусган батлуулж түүний хэрэгжилтийн төлөвлөгөөг сар бүр батлаж KPI оноо өгөн дүгнэдэг. Мөн жил бүр Байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулан 2 талаас баталгаажуулан хэрэгжилтийг хангуулан ажилладаг.	100%
13.3	Гэрээт компаниудын гэрээний хэрэгжилтийг сар бүр KPI оноогоор үнэлэж гэрээ дүгнэлтийн Тайлан төлөвлөгөөний стандартыг хангуулах.	Тогтмол	Уулын ажил гүйцэтгэх гэрээнд Байгаль орчныг хамгаалах талаархи гүйцэтгэгийн үүрэгт 12 заалт бүхий ажлуудыг оруулж өгсөн байдаг бөгөөд тухайн гэрээний хэрэгжилтийг хангуулан ажилладаг.	100%
13.4	Тавантолгой- Гашуун сухайт чиглэлийн тээврийн зам дагуу нөлөөллийг бууруулах ажлыг зохион байгуулах.	Тогтмол	“Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2024 оны 11-р сарын 29-ний өдрийн 01/2556 дугаартай албан бичгээр Гашуунсухайт автозамын 6 дахь км-ийн орчимд 183.2 га талбайг автотээврийн машины зогсоолын зориулалтаар ашиглах хүсэлтийг хүргүүлсэн боловч тухай байршил нь өмнөх эзэмшигчээс шалтгаалан шүүхийн маргаантай байгаа тул зогсоолын талбайг нэмэгдүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн.	100%
13.5	Цагаан-Овоо багийн малчдын хоршооллыг дэмжих	-	“Билэгт малчин” хоршоотой байгуулсан санамж бичгийн хүрээнд тайлант онд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уурхайн үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах ажлыг хэрэгжүүлж буй талбайд байрлах “Ойн зурвас”-ийн усалгаа арчилгааны ажлыг “Билэгт малчин” хоршоонд бүрэн хариуцуулан өгсөн байна.	100%
13.6	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг зохион байгуулах	2 удаа	Дэлхийн ойн өдөр, Дэлхийн усны өдөр, Дэлхийн байгаль хамгаалах өдрүүдээр Цогтцэций, Цогт-Овоо сум болон Дорноговь аймгийн Сайншанд сумын сургуулийн сурагчдын дунд арга хэмжээг хамтран зохион байгуулсан.	100%
13.7	Галба-Өөш долоодын говийн сав газрын захиргааны зөвлөлийн хурлыг зохион байгуулах.	1 удаа	Монгол улсын Усны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/57 тушаалаар батлагдсан “Сав газрын	100%

			талуудын оролцооны зөвлөл байгуулах, ажиллах журам”-ын дагуу ГАЛБА-ӨӨШ-ДОЛООДЫН говийн сав газрын талуудын оролцооны зөвлөлийн 12 дугаар хуралдаан 2025 оны 06 дугаарын сарын 05-06-ны өдрүүдэд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Цогтцэций салбарт амжилттай зохион байгуулсан.	
13.8	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд Баян-Овоо, Номгон, Манлай, Цогт-Овоо сумдад “Заг” төсөл хэрэгжүүлэх. />50 га/	50 га-аас багагүй	2025 онд Манлай суманд 50га талбайд 5000ш мод тарьсан. Цогт-Овоо суманд 50га талбайд 40000ш мод тарих бэлтгэл ажил 10/17-нд эхэлсэн. Номгон сумын Хармагтай багийн 50га талбайд 40000ш мод тарих бэлтгэл ажил эхэлсэн.	100%
13.9	“Тэрбум үндэсний хөтөлбөрийн хүрээнд Цогтцэций суманд “Ногоон зам” төслийн дагуу хамгаалалтын ойн зурвас байгуулах. />10 га/	10 га	Цогтцэций сумын “Ногоон зам” төслийн дагууд хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлын хүрээнд гэрээт байгууллагатай хамтран 09 дүгээр сарын байдлаар 148.500ш мод тарьсан байна.	100%
13.10	Орвог гашууны тооройг ойн аж ахуйн арга хэмжээг авч хэрэгжүүлэх /5 га/	5 га	Тоорой хамгаалах, байгалийн сэргэн ургалтад зориулан Хилийн Цэргийн 0133 дугаар тусгай салбартай хамтран 08/27-ны өдөр хамгаалах цэгийг тогтоосон. Номгон суманд 10/22-нд хашааны материал ачигдаж ирсэн. Номгон суманд загаар ойжуулах ажилтай зэрэгцэн хашааг барихаар төлөвлөж байна.	100%
Бүлгийн нийт дүн				100%
14. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт				
14.1	2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгууллагын цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулах	Компанийн сайтад байршуулсан байна.	Компанийн www.ett.mn веб хуудсанд 2024 оны БОМТ-ийн биелэлтийн тайлан болон 2025 оны БОМТ-г байршуулсан.	100%
14.2	Цогтцэций сумын Цагаан-Овоо, Билгэх, Сийрст, Өгөөмөр багийн иргэд	Олон нийтийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах /жилд 2 удаа/	2025 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Уурхайн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг малчид болон багийн иргэд нийтэд танилцуулах үйл ажиллагааг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “Грийн центр”-т зохион байгуулсан.	100%
Бүлгийн нийт дүн				100%
Нийт дүн				98.6 98.59%